


# БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ГАРЫН АВЛАГА



”

Монгол Улсын олборлох  
үйлдвэрлэлийн салбарт  
үйл ажиллагаа явуулж буй  
компаниудад зориулав.



### Хянасан:

**Редактор:**

## Орчуулагч

Д.Ганхуяг

Д.Хулан

**Хэвлэсэн:** Улаанбаатар хот, 2023 он

**Хэвлэлийн эхийг:** Mining Insight сэтгүүлийн редакцид бэлтгэв.

# АГУУЛГА

|                      |                                                                                       |    |
|----------------------|---------------------------------------------------------------------------------------|----|
| <b>Товчилсон үгс</b> |                                                                                       | 5  |
| <b>Бүлэг 1.</b>      | <b>Танилцуулга</b>                                                                    |    |
| 1.1.                 | БОНЗ-ын гарын авлагын зорилго                                                         | 7  |
| 1.2.                 | БОНЗ-ын гарын авлагын бүтэц                                                           | 9  |
| 1.3.                 | БОНЗ-д юуг хамааруулах, юуг үл хамааруулах вэ?                                        | 11 |
| 1.4.                 | Уул уурхайн компаниуд яагаад БОНЗ-ын шаардлагуудын талаар бодож үзэх шаардлагатай вэ? | 13 |
| 1.5.                 | БОНЗ-ын шаардлагуудын сүүлийн үеийн чиг хандлага                                      | 15 |
| <b>Бүлэг 2.</b>      | <b>БОНЗ-ын экосистем</b>                                                              |    |
| 2.1.                 | БОНЗ-ын экосистемийн тойм                                                             | 18 |
| 2.2.                 | Санхүүжүүлэгч байгууллагуудын зүгээс тавигддаг БОНЗ-тай холбоотой шаардлагууд         | 21 |
| 2.2.1.               | Институцийн хөрөнгө оруулагчид                                                        | 25 |
| 2.2.2.               | Хөрөнгийн биржүүд                                                                     | 28 |
| 2.2.3.               | Олон улсын санхүүгийн байгууллагууд                                                   | 32 |
| 2.2.4.               | Арилжааны банкнууд                                                                    | 32 |
| <b>Бүлэг 3.</b>      | <b>БОНЗ-ын аргачлал</b>                                                               |    |
| <b>Аргачлал 1:</b>   | БОНЗ-ын шаардлагуудын үзэл баримтлалыг хэрхэн компанид нэвтрүүлэх вэ?                 | 39 |
| <b>Аргачлал 2:</b>   | Компанийн дотоод дахь БОНЗ-ын баримт бичгүүд                                          | 44 |
|                      | Эрхэм зорилго, алсын хараа                                                            |    |
|                      | БОНЗ-ын бодлого, зарчмууд                                                             |    |
|                      | БОНЗ-ын зорилго, зорилт                                                               |    |
|                      | Бусад баримт бичгүүд                                                                  |    |
| <b>Аргачлал 3:</b>   | Оролцогч талуудын зураглалыг хэрхэн гаргах вэ?                                        | 51 |
| <b>Аргачлал 4:</b>   | Материаллаг нөлөөллийг хэрхэн тодорхойлох вэ?                                         | 54 |
|                      | Материаллаг нөлөөлөл, үүнийг тодорхойлох ямар алхмууд байдаг вэ?                      | 55 |

|                    |                                                                                              |    |
|--------------------|----------------------------------------------------------------------------------------------|----|
|                    | Материаллаг нөлөөллийн жишээнүүд                                                             | 58 |
| <b>Аргачлал 5:</b> | Өөрийн хэрэгжүүлэх БОНЗ-ын хүрээлэл/ шаардлага, стандарт болон арга зүйг хэрхэн сонгох тухай | 60 |
| <b>Аргачлал 6:</b> | Байгаль орчинд төвлөрөх нь-Хүлэмжийн хийн ялгаруулалтаа хэрхэн тооцоолох вэ?                 | 65 |
|                    | Хүлэмжийн хийн ялгаруулалт гэж юу вэ?                                                        | 65 |
|                    | Хүлэмжийн хийн ялгаруулалтаа яагаад тооцоолох шаардлагатай вэ?                               | 66 |
|                    | Хүлэмжийн хийн ялгарлыг хэрхэн тооцоолох вэ?                                                 | 68 |
| <b>Аргачлал 7:</b> | Нийгмийн чиглэлд төвлөрөх нь-Жендэр болон Хүний эрх                                          | 71 |
| <b>Аргачлал 8:</b> | Засаглалын чиглэлд төвлөрөх нь-ТУЗ-ийн бүрэлдэхүүн, БОНЗ-ын хороо                            | 74 |
|                    | ТУЗ-ийн бүрэлдэхүүн                                                                          |    |
|                    | БОНЗ-ын хорооны чиг үүрэг                                                                    |    |
| <b>Бүлэг 4.</b>    | Судалгааны жишээ: Брумадино (Brumadinho) дахь хаягдлын далан задарсан түүх                   | 79 |
|                    | Юу тохиосон бэ?                                                                              |    |
|                    | Гамшгийн шалтгаан юу байв?                                                                   |    |
|                    | Үр дагавар, нөлөөлөл                                                                         |    |
|                    | Яагаад энэ зүйл тохиосон бэ?                                                                 |    |
|                    | Сургамжууд                                                                                   | 82 |
| <b>Хавсралт 1.</b> | Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн салбарт хамаарах дотоод, гадаадын хүрээлэл/шаардлагууд   | 85 |
| <b>Хавсралт 2.</b> | БОНЗ-тай холбоотой түгээмэл ашигладаг үг хэллэгүүд                                           | 98 |

## ТОВЧИЛСОН ҮГС

|                 |                                                                                                    |
|-----------------|----------------------------------------------------------------------------------------------------|
| <b>АТСХ03</b>   | Австралийн тэтгэврийн сангийн хөрөнгө оруулагчдын зөвлөл                                           |
| <b>АМЕП</b>     | Австрали- Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр                             |
| <b>АХБ</b>      | Австралийн хөрөнгийн бирж                                                                          |
| <b>УБАХ</b>     | Удирдаж буй актив хөрөнгө                                                                          |
| <b>КМТАХТС</b>  | Калифорни мужийн төрийн албан хаагчдын тэтгэврийн систем                                           |
| <b>СО2</b>      | Нүүрстөрөгчийн давхар исэл                                                                         |
| <b>ЕСБХБ</b>    | Европын сэргээн босголт, хөгжлийн банк                                                             |
| <b>БОНЗ</b>     | Байгаль орчин, нийгэм, засаглал                                                                    |
| <b>СЗХ</b>      | Санхүүгийн зохицуулах хороо                                                                        |
| <b>СҮЗ</b>      | Санхүүгийн үйлчилгээний зөвлөл                                                                     |
| <b>БӨЗЗЗ</b>    | Байгууллагын өсөлтийн зах зээлийн зөвлөл<br>(Хонконгийн хөрөнгийн биржийн салбарын Удирдах зөвлөл) |
| <b>ХХ</b>       | Хүлэмжийн хий                                                                                      |
| <b>ОУТС</b>     | Олон улсын тайлагналын санаачилга                                                                  |
| <b>ДДТХ09</b>   | Даян дэлхийн тогтвортой хөрөнгө оруулалтын эвсэл                                                   |
| <b>ОУДДП</b>    | Олон улсын дэлхийн дулаарлын потенциал                                                             |
| <b>ХКХБ</b>     | Хонконгийн хөрөнгийн бирж                                                                          |
| <b>ОУМУУЗ</b>   | Олон улсын металл, уул уурхайн зөвлөл                                                              |
| <b>ОУСК</b>     | Олон улсын санхүүгийн корпорац                                                                     |
| <b>СТОУС</b>    | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт                                                         |
| <b>ОУХБ</b>     | Олон улсын хөдөлмөрийн байгууллага                                                                 |
| <b>ДБХХ</b>     | Дэлхийн байгаль хамгаалах холбоо                                                                   |
| <b>ХХК</b>      | Хязгаарлагдмал хариуцлагатай компани                                                               |
| <b>МУУУА</b>    | Монголын уул уурхайн үндэсний ассоциаци                                                            |
| <b>УУХҮЯ</b>    | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам                                                                    |
| <b>ҮС</b>       | Үндэсний стандарт                                                                                  |
| <b>МХБ</b>      | Монголын хөрөнгийн бирж                                                                            |
| <b>ТоСХ</b>     | Тогтвортой санхүүжилтийн холбоо                                                                    |
| <b>АБЭМАА</b>   | Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа                                                         |
| <b>ОТ</b>       | Оюутолгой                                                                                          |
| <b>ТБНББСЗ</b>  | Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл                                      |
| <b>ҮЦБХ</b>     | Үнэт цаас, биржийн хороо                                                                           |
| <b>ТХЗ</b>      | Тогтвортой хөгжлийн зорилтууд                                                                      |
| <b>УАӨСМТАХ</b> | Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийн мэдээллийг тайлагнах Ажлын хэсэг                           |
| <b>ХХБ</b>      | Хаягдал хадгалах байгууламж                                                                        |
| <b>ТХБ</b>      | Торонтогийн хөрөнгийн бирж                                                                         |
| <b>НҮБХХ</b>    | НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр                                                                           |
| <b>НҮБ</b>      | Нэгдсэн Үндэсний Байгууллага                                                                       |
| <b>НҮББОХ</b>   | НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр                                                                      |
| <b>НҮБУАӨСК</b> | НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц                                                     |
| <b>АНУ</b>      | Америкийн Нэгдсэн Улс                                                                              |
| <b>АНУБОХА</b>  | АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлаг                                                           |
| <b>ЭЭМЗ</b>     | Эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх зарчмууд                                                            |

## МЭДЭГДЭЛ


Энэхүү гарын авлагыг Австрали Улсын Засгийн газар, Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам санхүүжүүлсэн уг гарын авлагад илэрхийлсэн үзэл санаа нь Австрали Улсын Засгийн газрын бус гагцхүү зохиогчийн үзэл бодол болно. Түүнчлэн энэ гарын авлагад тусгасан үзэл баримтлалыг Австрали Улсын Засгийн газар дэмжиж байгаа гэж ойлгож болохгүй. Тус улсын Засгийн газар энэ гарын авлагад багтсан мэдээллийн бүрэн болон үнэн зөв эсэхийг батлахгүй.

Энэхүү хэвлэлд орсон тоо баримт, мэдээ материал алдаа мадагтай, дутуу хагас байж болзошгүй бөгөөд түүнээс үүдэн гарах аливаа хохиролд Австрали Улсын Засгийн газар, хариуцлагатай албан тушаалтан, ажилтан, албан хаагч, гэрээт ажилчид ямар нэг хариуцлага хүлээхгүй болно. Энэхүү гарын авлага нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой. Аливаа шийдвэр гаргахаас өмнө гарын авлагыг уншиж, хэрэглэж буй тал мэдээллийн анхдагч эх сурвалжтай холбогдон, мэдээ баримтаа лавшруулан шалгаж, бие даасан судалгаа хийн, зөвлөгөө авах нь зүйтэй.

## ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

**Adam Smith  
International**

Австрали Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр (АМЭП 2)-ийг Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам (Австралийн тусламжийн хөтөлбөр) санхүүжүүлж, Адам Смит Интернэйшнл зөвлөх компани хэрэгжүүллээ.



## БҮЛЭГ 1. ТАНИЛЦУУЛГА

БОНЗ-ын экосистем

БОНЗ-ын аргачлал

Судалгааны жишээ:

Брумадино (Brumadinho) дахь хаягдлын  
далан задарсан түүх

Хавсралт 1, 2

# Бүлэг 1. Танилцуулга

## 1.1. БОНЗ-ЫН ГАРЫН АВЛАГЫН ЗОРИЛГО

Байгаль орчин, нийгэм, Засаглалын (БОНЗ) гарын авлага нь Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн компаниуд, уг салбарын ханган нийлүүлэгч компани, аж ахуйн нэгжүүдэд Байгаль орчин (E-Environment), Нийгэм (S-Social), Засаглалын (G-Governance) шаардлагуудыг танилцуулах, улмаар цаашдын үйл ажиллагаанд нь чиглэл болох зорилготой юм. Түүнчлэн тогтвортой хөгжлийн үйл ажиллагаа, дадлаа сайжруулах замаар хөрөнгө оруулалт татахыг зорьсон компаниудад ч зохих дэмжлэг болохыг зорив.

БОНЗ-ын гарын авлагад Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын БОНЗ-ын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, төлөвлөхөд ашиглагдахуйц арга хэрэгсэл, аргачлалуудыг багтаасан болно. Мөн жишээ, хэрэгцээт мэдээллийг агуулсан лавлагаа материал бүхий практик удирдамж юм.

Гарын авлага нь компаниудын хувьд эхлэлийн цэг бий болгохын зэрэгцээ цаашлаад БОНЗ-ын суурь үзэл баримтлал, зарчмуудыг хэрэгжүүлэх их аянд нь хөтөч болно. БОНЗ-ын хэрэгжилтийн түвшин, гаргаж буй ахиц зэргээс хамааран компаниуд нь гарын авлагад тусгасан аргачлалуудыг нэг нэгээр нь, эсвэл хослуулан ашиглах боломжтой.

Нийтэд нь авч үзвэл БОНЗ-ын гарын авлагын зорилго нь тогтвортой, хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг дэмжин урамшуулах төдийгүй хөрөнгө оруулагч болон бусад талуудын хувьд компанийн тогтвортой хөгжлийн гүйцэтгэлийг үнэлэхэд ашиглаж болохуйц стандартчилсан, объектив арга замыг хангаж өгөх явдал юм. Улмаар уул уурхайн компаниуд нь БОНЗ-ын гүйцэтгэлээ сайжруулан, илүү хариуцлагатай, илүү тогтвортой үйл ажиллагаа явуулах, түүний үндсэн дээр уул уурхайн олборлолтоос үүддэг байгаль орчин, нийгэм болон орон нутгийн иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хувь нэмрээ оруулах боломжтой.



## 1.2. БОНЗ-ЫН ГАРЫН АВЛАГЫН БҮТЭЦ

Гарын авлага нь 4 бүлгээс бүрдэнэ.

**Бүлэг 1.** Танилцуулгад БОНЗ-ын гарын авлагын талаарх ерөнхий мэдээлэл бүтцийг тайлбарласны зэрэгцээ БОНЗ-ын үндсэн хөдөлгөгч хүч, орчин үеийн дэлхий нийтийн чиг хандлагатай холбоотой мэдээллийг багтаав.

**Бүлэг 2.** БОНЗ-ын экосистем бүлэгт БОНЗ-ын экосистемийн тойм, Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн салбарт хамааралтай санхүүжүүлэгч талуудыг дэлгэрэнгүй танилцуулж, тэдгээрээс тавигддаг БОНЗ-ын шаардлагуудыг багтаасан. Мөн энэ хэсэгт Монгол Улсын аж ахуйн нэгжүүдийн нийтлэг нөхцөл байдал, бие даасан үүрэг хариуцлага, тэдгээрийн харилцан хамаарал болон санхүүгийн байгууллагуудын зүгээс тавигддаг БОНЗ-ын шаардлагууд нь эцсийн хэрэглэгчдэд хэрхэн тусгалаа олдог талаарх ойлголтыг өгнө.

**Бүлэг 3.** БОНЗ-ын аргачлалууд нь компани, аж ахуйн нэгжүүдэд БОНЗ-ын суурь зарчмуудыг нэвтрүүлэхэд туслах 8 аргачлалаас бүрдэнэ.

### **Аргачлал 1: БОНЗ-ын үзэл баримтлалыг нэвтрүүлэх**

БОНЗ-ын үзэл баримтлалыг нэвтрүүлэх шийдвэр гаргахдаа авч хэрэгжүүлэх бодит алхмуудыг тусгав.

### **Аргачлал 2: Зайлшгүй харгалзан үзэх ёстой БОНЗ-ын дотоод бодлого, зарчмууд**

Компаниудын хувьд зайлшгүй боловсруулан баталж, хэрэгжүүлэх шаардлагатай БОНЗ-ын үндсэн баримт бичгүүдийг жишээгээр оруулав. Энэхүү аргачлал Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудад БОНЗ-ын хандлага, бодлогоо хөтлөн жолоодоход чухал ач холбогдолтой баримт бичгүүдийг тодорхойлох, сонгох, боловсруулахад дэмжлэг болно.

### **Аргачлал 3: Оролцогч талуудын зураглал гаргах**

Компаниуд үйл ажиллагааныхаа бүхий оролцогч талыг хэрхэн тодорхойлж, ангилан, зураглах талаар тайлбарласан.

### **Аргачлал 4: Материаллаг нөлөөллийг тодорхойлох аргачлал**

БОНЗ-ын үзэл баримтлалын хамгийн чухал хэсэг болох материаллаг нөлөөллийн суурь ойлголтыг тайлбарлахын зэрэгцээ нүүрс, металл, уул уурхай, газрын тос, байгалийн хийн салбараас үзүүлдэг материаллаг нөлөөллийг хэрхэн тодорхойлохыг заасан.

**Аргачлал 5:** *БОНЗ-ын хүрээлэл/ шаардлага, стандарт болон арга зүйг сонгох аргачлал*

Компаниудад олон улсын болон үндэсний түвшний олон тооны стандарт, арга зүйгээс тохирох сонголт хийхэд дэмжлэг үзүүлнэ. Энэхүү бүлэгт Монгол Улсын компаниудыг түгээмэл байдлаар хамааруулан, тэдгээрийн төрөл бүрийн хүрээлэл, стандарт, арга зүйн тохиромжтой байдлыг багтаасан болно.

**Аргачлал 6:** *Байгаль орчинд төвлөрөх нь: Хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох*

Хүлэмжийн хийн ялгаруулалт нь уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн компаниудын хувьд байгаль орчны асуудлын төв цэг тул энэхүү аргачлал нь Цар хүрээ 1, 2 болон 3 талаар, мөн хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолоход ашиглаж болох арга зүйг тайлбарласан.

**Аргачлал 7:** *Нийгмийн чиглэлд төвлөрөх нь: Жендэр болон Хүний эрх*

БОНЗ-ын нийгмийн чиглэлд компаниуд хэрхэн хандахыг тайлбарлаж, жендэрийн тэгш байдлын гүйцэтгэлээ сайжруулахад нь туслах, давуу болон сул тал, боломжуудаа тодорхойлоход дэмжлэг үзүүлнэ.

**Аргачлал 8:** *Засаглалын чиглэлд төвлөрөх нь: ТУЗ-ийн бүрэлдэхүүн, БОНЗ-ын хороо*

Стратегийн тэргүүлэх чиглэлээ тодорхойлоход компаниудын ТУЗ-ийн үүрэг, хариуцлагын талаар тайлбарласан.

БОНЗ-ын гүйцэтгэлийн талаарх жишиг судалгааг **Бүлэг 4-т** оруулахдаа дэлхийн эрдэс баялгийн салбарын бодит жишээгээр БОНЗ-д хамаарах асуудлын ач холбогдлыг харуулахыг зорьсон.

Хавсралт 1 дээр Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн салбарт хамаарах дотоодын болон олон улсын хүрээлэл/ шаардлагуудын жагсаалт, товч тайлбаруудыг багтаав.

Хавсралт 2 дээр БОНЗ-ын асуудалд түгээмэл ашигладаг үг хэллэгүүдийг тусгав.

### **1.3. БОНЗ-Д ЮУГ ХАМААРУУЛЖ, ЮУГ ҮЛ ХАМААТУУЛАХ ВЭ?**

БОНЗ буюу англи хэлээр ESG (Environment, Social and Governance) нь Байгаль орчин, Нийгэм, Засаглал хэмээх үгсийн товчлол бөгөөд аливаа бизнес эсвэл байгууллагын зүгээс тогтвортой хөгжилд нөлөөлдөг гурван гол чиглэлийг өргөн хүрээнд төлөөлдөг. БОНЗ-ын үзэл баримтлал нь уур амьсгалын өөрчлөлт, нийгэм, оролцогч талууд, эдийн засаг, засаглал, хүрээлэн буй орчин, филантроп зэрэг чухал чиглэлээр бизнесийн байгууллага, компаниудаас үзүүлдэг үр нөлөө, ололт амжилтад анхаарал хандуулдаг. Энэхүү үзэл баримтлал нь бизнесийн үйл ажиллагаанаас хүмүүс болон хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөллийг нөхөн сэргээгдэхгүй нөөц эх үүсвэр талаас нь, ялангуяа байгалийн нөөцийг нөхөн сэргээх боломжгүй тул ашигт суурилсан бизнесийн загвар нь тогтвортой бус байх бөгөөд үүнийг дан ганц бизнесийн эрх ашгийн үүднээс ашиглаж болохгүй гэсэн үзэл баримтлалд төвлөрдөг.

#### **БОНЗ-ын шаардлагууд нь дараах онцлогтой байна:**

- Бизнесийн байгууллагуудын тогтвортой хөгжлийн үйл ажиллагаа, оролцогч талууддаа үзүүлж буй нөлөөлөлд төвлөрдөг;
- Санхүүгийн үр өгөөжөөс илүүтэй иж бүрэн хандлагаар нь асуудлыг авч үздэг;
- Нэг удаагийн үйл ажиллагааг гүйцэтгэх биш системтэй арга хандлагыг хэрэгжүүлдэг;
- Байгаль орчин, нийгэм болон оролцогч талуудад үзүүлж буй нөлөөллийн үүднээс чухалд тооцогдох бүхий л асуудлыг хамардаг;
- Тогтвортой хөгжилд гарч буй өөрчлөлт, ахиц дэвшлээс хамааран хувьсан өөрчлөгдөж байдаг.

Нөхцөл байдал эсвэл талуудаас хамааран БОНЗ-ыг илэрхийлэх олон хувилбар байж болно. Жишээ нь хөрөнгө оруулагч, санхүүгийн байгууллагуудын уламжлалт санхүүгийн арга хэрэгслээс гадна БОНЗ-ын хүчин зүйлсэд тэргүүлэх ач холбогдол өгөх хөрөнгө оруулалтын арга, стратегийг түгээмэл ашигладаг. Эрсдэлийн менежерүүд нь БОНЗ-ыг ашиглан тухайн байгууллагын тогтвортой хөгжилтэй холбоотой эрсдэл, боломжуудыг хэрхэн удирддаг талаар оролцогч талуудад ойлголт өгөх боломжтой.

**Тухайн нөхцөл байдлаас хамаардаг БОНЗ-ын зарим хэрэглээнд дараах зүйлс багтана:**

- БОНЗ-ын хүрээлэл гэдэг нь хамаарах гурван чиглэлээр гарсан, гүйцэтгэлийг сайжруулах зорилго бүхий стандарт, хөтөч, зааварчилгаа, дүрэм, зарчим, код, санаачилга болон сайн туршлага зэргийг хамтад нь илэрхийлсэн нэр томьёо юм.
- БОНЗ-ын харилцан уялдаа, интеграци гэдэг нь БОНЗ-ын хүчин зүйлсийг компани эсвэл байгууллагын хөрөнгө оруулалтын шийдвэр, стратеги, бодлого, системд тогтвортой, урт хугацааны өгөөж хүртэх зорилгоор тусгасан, уялдааг хангах үйл явцыг хэлнэ.
- БОНЗ-ын зэрэглэл гэдэг нь БОНЗ-ын гүйцэтгэлд үндэслэн, ихэвчлэн гуравдагч тал буюу хараат бус рейтинг тогтоогч байгууллага эсвэл судалгааны хүрээлэнгийн зүгээс компани эсвэл хөрөнгө оруулалтад өгсөн үнэлгээ юм.

Олборлох үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй компаниудын хувьд БОНЗ-ын үндсэн гурван чиглэлд дараах сэдвүүд багтаж болох юм. Тэгэхдээ нэг сэдэв нэг шалгуурт хамаарахгүйгээр ихэнхдээ харилцан уялдаатай буюу гурван чиглэлийн аль алинд хамаарах нь бий.

| Байгаль орчин                 | Нийгэм                                   | Засаглал             |
|-------------------------------|------------------------------------------|----------------------|
| Хүлэмжийн хийн ялгаруулалт    | Хүний эрх                                | Авлига, хээл хахуул  |
| Усны менежмент                | Хөдөлмөрийн харилцаа                     | Зэвсэгт мөргөлдөөн   |
| Газар ашиглалт                | Орон нутгийн харилцаа                    | Ил тод байдал        |
| Биологийн олон янз байдал     | Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа            | Ёс зүй               |
| Уурхайн хог, хаягдал          | Нүүлгэн шилжүүлэлт                       | Нийцэл               |
| Дуу чимээ/ тоосжилт           | Орон нутгийн эдийн засаг                 | Кибер аюулгүй байдал |
| Аюултай/ хорт бодис           | Ханган нийлүүлэлтийн сүлжээний менежмент | Эрсдэлийн удирдлага  |
| Уурхайн хаалт, нөхөн сэргээлт | Соёлын өв                                | ТУЗ, хороод          |
| Эрчим хүчний хэрэглээ         |                                          |                      |

**БОНЗ гэж юу болох, түүний үндсэн онцлогуудыг ойлгох нь чухал ч БОНЗ-д юуг хамаатуулахгүй вэ гэдгийг мэдэх нь дутахгүй чухал юм. БОНЗ-д хамаарахгүй зүйлс:**

- Улиран өнгөрсөн хандлага биш: БОНЗ нь сүүлийн жилүүдэд ихээхэн түгээмэл болж буйн зэрэгцээ ирээдүйд, эсвэл тогтвортой хөгжилд тулгарч буй асуудал, сорилтууд бүрэн шийдэгдэх хүртэл тэргүүлэх ач холбогдлоо хэвээр хадгалах магадлал өндөр.
- Тодорхой төрлийн хөрөнгө оруулалт биш: БОНЗ нь тодорхой хөрөнгө оруулалт эсвэл компанийг БОНЗ-ын гүйцэтгэлд үндэслэн үнэлэхэд ашигладаг хүрээлэл, арга зам биш юм.
- Стандарт шийдэл биш: БОНЗ-ын арга ажиллагаа нь салбар, газар зүйн байршил, бусад хүчин зүйлсээс шалтгаалах ба компани эсвэл хөрөнгө оруулалт бүрт БОНЗ-ын сэдэв ялгаатай байдаг.
- Санхүүгийн шинжилгээг орлохгүй: БОНЗ-ын хүчин зүйлс нь харгалзан үзэх ёстой чухал үзүүлэлт боловч хөрөнгө оруулалт эсвэл компанийг үнэлэхэд зайлшгүй ашигладаг санхүүгийн шинжилгээг орлохгүй. БОНЗ-ын хүчин зүйлсийг санхүүгийн шинжилгээ хийхдээ нэмэлтээр авч үзэх нь зүйтэй.
- Нэг удаагийн санаачилга биш: БОНЗ нь тогтвортой хөгжлийн урт хугацааны, системтэй арга хандлагад төвлөрдөг тул нэг удаагийн үйл ажиллагаа, санаачилгыг БОНЗ-ын нэг хэсэг хэмээн ангилан үзэх боломжгүй.
- Цоо шинэ зүйл биш: БОНЗ-ын салбар чиглэлүүд өмнө нь ч байсан бөгөөд эдгээрийг нэгдмэл хандлагаар ашиглах зорилгоор нэг дээвэр дор нэгтгэсэн юм.

#### **1.4. УУЛ УУРХАЙН КОМПАНИУД ЯАГААД БОНЗ-ЫН ШААРДЛАГУУДЫГ АВЧ ҮЗЭХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?**

Аливаа компани, аж ахуйн нэгжийн хувьд БОНЗ-ын шаардлага, үзэл баримтлалыг боловсруулах, нэвтрүүлэхэд нөлөөлөх дотоод болон гадаад хүчин зүйлс байдаг. Ялангуяа ажиллах хүч, технологийн өндөр хэрэглээтэй, байгаль орчин, нутгийн иргэд, нийгэм болон эдийн засагт ихээхэн нөлөөлөл үзүүлдэг уул уурхайн салбарын тогтвортой, хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих нь чухал ач холбогдолтой.

Ойрын хугацаанд БОНЗ нь сонголтоор бус заавал даган мөрдөх шаардлага болох магадлал өндөр. Тэр үед компаниуд БОНЗ-ын үзэл баримтлалыг боловсруулах шийдвэр гаргах хэрэгтэй болно. Энэхүү гарын авлагад яагаад БОНЗ-ын асуудалд ач холбогдол өгөх шаардлагатайг компаниуд ойлгоход туслах гадаад болон дотоод тус бүр гурван хүчин зүйлийн талаар танилцуулсан.

## ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛС

### 1. Нэр хүнд, итгэлцэл бий болгох

Дэлхий нийтийн хэмжээнд олон тооны БОНЗ-ын сорилтууд тулгарах тусам тогтвортой байдал болон БОНЗ-ын зарчимд тэмүүлэх хүчин чармайлт нь төр, түншлэгчид, бусад талууд, олон нийтэд нэр хүнд, итгэлцлийг бий болгоход тусалдаг.

Капитал хөрөнгө  
татах

Зохицуулалтын  
шаардлагуудыг даган  
мөрдөх

Нэр хүнд, итгэлцэл  
бий болгох

### 2. Капитал хөрөнгө татах

Олон тооны санхүүжүүлэгч байгууллагууд тогтвортой хөгжил болон БОНЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг санхүүжилтийн шийдвэртэйгээ уялдуулж байна.

Зохицуулалтын  
шаардлагуудыг даган  
мөрдөх


Нэр хүнд, итгэлцэл  
бий болгох

Капитал хөрөнгө  
татах

### 3. Зохицуулалтын шаардлагуудыг даган мөрдөх

БОНЗ-тай холбоотой асуудлаарх хууль, журмыг төрийн байгууллагууд зохицуулах эрх бүхий байгууллагууд эсвэл олон улсын байгууллагууд гаргадаг. Ихэнх тохиолдолд эдгээрийг заавал даган мөрдөх ба хэрэгжилтэд хамаарах арга хэмжээ дагалдан хэрэгжинэ.

## ДОТООД ХҮЧИН ЗҮЙЛС



### 1.5. БОНЗ-ЫН ШААРДЛАГУУДЫН СҮҮЛИЙН ҮЕИЙН ХАНДЛАГА

НҮБ-ын гишүүн улс орнууд 2015 онд **Тогтвортой хөгжлийн зорилгод** нэгдэн гарын үсэг зурж, **2030 он хүртэлх** Тогтвортой хөгжлийн 17 зорилтыг тодорхойлсон билээ<sup>1</sup>. Тухайн жил мөн уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох болон санхүүгийн асуудлуудыг тусгасан Парисын гэрээ<sup>2</sup> байгуулагдсан. **Парисын гэрээний үндсэн зорилго нь агаарын дундаж температурыг аж үйлдвэржилтийн өмнөх түвшнээс Цельсийн 2 хэмээс хэтрүүлэхгүй байх**, ингэснээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг тогтвортойгоор бууруулах явдал юм.

<sup>1</sup> <https://sdgs.un.org>

<sup>2</sup> <https://www.un.org/en/climatechange/paris-agreement>

Энэхүү 2 баримт бичиг нь төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, бизнесийн байгууллагуудын зүгээс олон улсын хэмжээнд хэрэгжүүлэх санаачилгын тэргүүн эгнээнд байдаг. Түүнчлэн НҮБ-ын Даян дэлхийн гэрээ нь компани, аж ахуйн нэгжүүдэд хүний эрх, хөдөлмөр, байгаль орчин болон авлигын эсрэг түгээмэл зарчмуудтай уялдуулан нийгмийн зорилтуудыг урагшлуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг уриалсан олон улсын санаачилга юм.

Өөр нэг томоохон санаачилга нь **Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмууд (PRI)**<sup>3</sup> бөгөөд уг чиглэлээр дэлхийд тэргүүлэх удирдамж юм. Эдгээр зарчмыг НҮБ бүхэлд нь дэмждэг. Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмууд нь БОНЗ-ын хувьд тухайн хөрөнгө оруулалтаас үзүүлэх нөлөөлөлд төвлөрдөг. Эдгээр зарчим хөрөнгө оруулагчдыг хариуцлагатай хөрөнгө оруулалт хийх, өгөөжөө нэмэгдүүлэх, эрсдэлээ илүү сайн удирдахад хөхиүлэн дэмжих юм. Гарын үсэг зурж нэгдэн орсон талууд дор дурдсан зарчмыг даган мөрдөх үүрэгтэй.

График 1.



2022 оны байдлаар Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмуудад гарын үсэг зурж нэгдсэн компанийн тоо 4,900 давсан бөгөөд тэдний удирдаж буй нийт актив хөрөнгийн хэмжээ 121 их наяд ам.долларт хүрчээ.

Сүүлийн жилүүдэд улс орнууд болон байгууллагуудын зүгээс гаргаж буй **БОНЗ-ын олон тооны хүрээлэл, стандарт, арга зүй** ихээхэн түгэн дэлгэрч байгааг бид харж байна. Компаниудын заавал даган мөрдөх БОНЗ-ын дүрэм, журмыг улс орнууд батлан хэрэгжүүлж байна. ЕХ, Япон улс, Хонконг нь БОНЗ-ын тайлагналын чиглэлээр өндөр шаардлага бүхий дүрэм журмууд нэвтрүүлжээ. Тухайлбал, ЕХ нь 500-гаас дээш тооны ажилтантай компаниудаас тогтвортой хөгжлийн тайлан гаргахыг шаарддаг бөгөөд 2025 оноос энэхүү журмыг 250-иас дээш тооны ажилтантай, эсвэл 40 сая еврогоос дээш хэмжээний эргэлтийн хөрөнгө бүхий бүх компани хэрэгжүүлэхээр болжээ.<sup>4</sup>

<sup>3</sup> <https://www.unpri.org/about-us/about-the-pri>

<sup>4</sup> <https://www.europarl.europa.eu/news/en/press-room/20221107IPR49611/sustainable-economy-parliament-adopts-new-reporting-rules-for-multinationals>





Танилцуулга

## БҮЛЭГ 2. БОНЗ-ЫН ЭКОСИСТЕМ

БОНЗ-ын аргачлал

Судалгааны жишээ:  
Брумадино (Brumadinho) дахь хаягдлын  
далан задарсан түүх

Хавсралт 1, 2

## Бүлэг 2. БОНЗ-ын экосистем

### 2.1. БОНЗ-ЫН ЭКОСИСТЕМИЙН ТОЙМ

Санхүүгийн бүхийл байгууллага, тэрдундаа капитал хөрөнгийн санхүүжилт хийдэг байгууллагууд нь үйлчлүүлэгчдээсээ заавал биелүүлэх журам, шаардлагуудын багцтай байдаг. Хөрөнгө босгох, санхүүгийн хэрэгцээгээ хангахын тулд компаниуд тэдгээр шаардлагыг сайтар ойлгож, ханган биелүүлэх ёстой. Сүүлийн жилүүдэд Хариуцлагатай хөрөнгө оруулалт, БОНЗ-ын шаардлагуудыг тэргүүлэх чиглэлээ болгож буй олон улсын хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчдийн тоо өсөн нэмэгдэж байна. БОНЗ-ын шаардлагууд нь хамгийн чухал шалгуурын нэг шийдвэр гаргалтад чухал үүрэг гүйцэтгэх болсныг хөрөнгө оруулагчдын мэдэгдлүүдээс харж болно. БОНЗ нь Монгол Улсын бизнес эрхлэгчдийн дунд хэт эртэднэ гэж үзэх хүмүүс байж болох ч Монгол Улсад хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч нар нь БОНЗ-ын шаардлагууд, олон улсын санхүүгийн байгууллагуудаас тавигддаг нөхцөлүүдийг баримталж байгааг анхаарахгүй өнгөрч болохгүй юм.

“Хариуцлагатай хөрөнгө оруулалт бол бидний хөрөнгө оруулалтын философийн гол зүрх юм”

Нидерландын  
тэтгэврийн сан (ABP)

“БОНЗ-ын шаардлагуудыг бид хөрөнгө оруулалтын судалгаа, багц бүрдүүлэлт, хариуцлагын үйл явцтайгаа нягт уялдуулсан”

Блэкрөк (Blackrock)

“Өсөлтөд чиглэсэн арга барил, чиг хандлага хувьсан өөрчлөгдөж, нийгэм болон эдийн засгийн өгөөж, өртгийг иж бүрнээр нь харгалзах боллоо”

Андреас Ютерманн, Алианз  
Глобал Инвесторын Гүйцэтгэх  
захирал (Allianz Global Investors)

Хөрөнгө оруулагчид санхүүжилтийн шийдвэр гаргахдаа нэн тэргүүнд БОНЗ-ыг харгалзан үзэж, энэ талын мэдээллийг олон эх үүсвэрээс авахыг эрмэлздэг. Нэгд, компанийн ил тод болгосон мэдээлэлтэй танилцдаг. Хоёрт, БОНЗ-ын чиглэлийн мэргэжилтэн, шинжээчийг ажиллуулж судлуулдаг. Гуравт, компаниудыг БОНЗ-ын үзүүлэлтээр нь эрэмбэлдэг байгууллагуудын гаргасан зэрэглэл, индекс зэргийг авч үздэг байна.

График 2.

## БОНЗ-ын шаардлагуудын талаарх мэдээллийн эх сурвалжууд





График 3-т БОНЗ-ын экосистемийн талаарх мэдээллийг тоймлон улмаар санхүүжүүлэгч, дундын зууч болон уул уурхайн салбарын компаниуд хоорондын харилцааг дэлгэрэнгүй харуулахдаа тэдгээрийн чиг үүргийг тайлбарлан, хоорондын мэдээлэл, капиталын урсгалыг үзүүлэв.

График 3.

## БОНЗ-ын экосистемийн тойм



Эх сурвалж: EX-ны Нийгмийн нөлөөлөл бүхий хөрөнгө оруулалт хэмээх баримт бичгээс авав. Miguel Maduro et al, 2018


Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудад зориулав.

Санхүүжүүлэгч гэдэг нь хөрөнгө оруулах капиталыг эзэмшигч тал бөгөөд тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтөд санаа тавьж, БОНЗ-ын асуудлаар хүчин чармайлт гаргаж буй байгууллага юм. Ихэнхдээ тэд олон улсын гэрээ хэлэлцээрт (жишээ нь НҮБ-ын Даян дэлхийн гэрээ, Парисын гэрээ) нэгдэн орсон төдийгүй Олон улсын тайлагналын санаачилга, Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийн мэдээллийг тайлагнах Ажлын хэсэг (TCFD) (Хавсралт 1-ээс дэлгэрэнгүйг үзнэ үү) зэрэг БОНЗ-ын төрөл бүрийн хүрээллийг даган мөрдөж, тэдгээр тэргүүлэх зүйлсийг хийж буй санхүүжилтдээ тусгасан байдаг. Институцийн хөрөнгө оруулагч, зээлдүүлэгчид нь БОНЗ-ын шаардлагуудыг тусгасан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

График 4-т Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн салбарт санхүүжилт олгож буй байгууллагуудыг холбогдох жишээний хамт харуулав. Гарын авлагын дараагийн дэд хэсэгт эдгээр санхүүгийн байгууллагууд, тавьдаг шаардлага, нөхцөл зэргийг БОНЗ болон тогтвортой хөгжлийн үүднээс авч үзсэн болно.

График 4.

#### Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн салбарт хамаарах санхүүжүүлэгч байгууллагууд



Санхүүжүүлэгч талууд нь санхүүгийн бус зууч байгууллага, эсвэл гуравдагч талын үзүүлдэг мэргэжлийн үйлчилгээг санхүүжилтийн үйл явцад ашигладаг. Жишээ нь БОНЗ-ын зэрэглэл гаргадаг компаниуд энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг. Ийм агентлагууд компаниудад системтэй үнэлгээ хийж, нөхцөл байдалд нь оноо өгснөө харуулж, үнэлгээнд хамруулсан байгууллагуудыг хооронд нь харьцуулах боломжтойгоор зэрэглэл гаргадаг. Зэрэглэл гаргадаг агентлагууд нь компаниудын гүйцэтгэлийг олон төрлийн арга зүй, шалгуураар үнэлдэг. Агентлагууд харьцангуй залуу зах зээлд шинэ тоглогч болж орж ирж байгаа ч үйлчилгээний нэр төрлөө эрчимтэй нэмэгдүүлж буйг дурдах нь зүйтэй. Тэдгээр агентлагуудын заримаас дор дурдвал:

1. MSCI ESG Ratings (ЭмЭсСиАй)
2. Sustainalytics (Састайналатикс)
3. RobecoSAM (РобекЭсАйЭМ)
4. ISS ESG (АйЭсСи)
5. Vigeo Eiris (Вигео Эйрис)
6. Moody's ESG Solutions (Мүүдийс)
7. Refinitiv ESG (Рифинитив)
8. FTSE Russell ESG Ratings (Франкфуртын хөрөнгийн бирж)
9. Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо

Тэргүүлэх агентлагуудын нэг болох ЭмЭсСиАй нь (MSCI) дор харуулсан үнэлгээний системийг ашиглан БОНЗ-ын материаллаг эрсдэлийг тодорхойлж байна.

График 5.

#### ЭмЭсСиАй агентлагийн БОНЗ-ын зэрэглэлийн систем

| ССС                                                                                                         | В | ВВ                                                                                                                                                      | ВВВ | А | АА                                                                                                                | ААА |
|-------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|---|-------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| <b>ХОЦОРЧ БУЙ</b><br>БОНЗ-ын томоохон эрсдэлүүдийг удирдах чиглэлээр салбарын хандлагаас хоцорч буй компани |   | <b>ДУНДАЖ</b><br>Салбарын ижил төстэй компаниудтай харьцуулбал БОНЗ-ын томоохон эрсдэлүүдийг удирдах чиглэлээр холимог эсвэл хүлээлтэд хүрээгүй компани |     |   | <b>МАНЛАЙЛАГЧ</b><br>БОНЗ-ын хамгийн том эрсдэл болон боломжуудыг удирдах чиглэлээр салбараа тэргүүлж буй компани |     |

## 2.2. САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ЗҮГЭЭС ТАВИГДДАГ БОНЗ-ТАЙ ХОЛБООТОЙ ШААРДЛАГУУД

### 2.2.1. Институцийн хөрөнгө оруулагчид

Институцийн хөрөнгө оруулагчид гэж капитал зах зээл дээрх хамгийн том, нөлөө бүхий тоглогчдыг хэлдэг. Тэдний тавьдаг шаардлага, хөрөнгө оруулалтын шалгуурууд нь бүхий л салбарын чиг хандлагыг тодорхойлдог. БОНЗ-ын шалгуур ашигладаг хөрөнгө оруулагчдын хувь хэмжээ нь бүс нутаг, хөрөнгө оруулагчийн төрөл, хөрөнгө оруулалтын онцлог стратеги зэргээс хамааран өөрчлөгддөг. Гэхдээ сүүлийн жилүүдэд БОНЗ-ын шалгуур баримталдаг хөрөнгө оруулагчдын тоо ихээхэн нэмэгдэж байна.

**Олон улсын тогтвортой хөрөнгө оруулалтын эвслээс** (GSIA) 2020 онд бэлтгэн гаргасан тайланд дурдсанаар Европ, АНУ, Япон, Канад, Австрали/Шинэ Зеланд гэсэн 5 зах зээлийн тогтвортой хөрөнгө оруулалтын нийт актив хөрөнгийн хэмжээ 2020 оны эхний байдлаар 35.3 их наяд ам.долларт хүрчээ. Энэ нь 2018-2020 он буюу 2 жилийн хугацаанд 15%-ийн өсөлт үзүүлсэн байна.<sup>5</sup>

Дараах хэсэгт институцийн хөрөнгө оруулагчид болон тэдгээрийн зүгээс тавьдаг БОНЗ-ын бодлого, шаардлагуудыг тусган харууллаа.

### **Аппиан Капитал Адвайсори (Appian Capital Advisory LLP)**

Аппиан Капитал Адвайсори хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл нь хувийн хөрөнгө оруулалтын хоёр санг удирддаг. Эдгээр нь зөвхөн уул уурхай болон түүнтэй холбогдох компаниудад хөрөнгө оруулдаг байна. Тус фирм нийтдээ 23 уурхайд хөрөнгө оруулсан бөгөөд нийт 3.6 тэрбум ам.долларыг удирдаж байна. Аппиан Капитал Адвайсори нь өндөр чанартай актив хөрөнгийг урт хугацааны капитал болон мэдлэг туршлагатай хослуулан удирддаг.

Аппиан нь БОНЗ-ын стандартыг бүхий л хөрөнгө оруулалтынхаа тулгын чулуу гэж үздэг. Өөрийнх нь багцад хамаарч буй компаниуд олон улсын стандартуудыг дагаж мөрдөхийг баталгаажуулсны үндсэн дээр хөрөнгө оруулалт хийдэг байна. Аппиан нь “360 хэм” хэмээх магадлан шинжилгээний ажил хэрэгжүүлдэг. Үүний хүрээнд компаниудын байгаль орчинтой холбогдох үүрэг хариуцлага, нөхөн сэргээлт болон уурхайн хаалтын төлөвлөгөө, тухайн улс орны хууль тогтоомж, зөвшөөрөл олгохтой холбоотой шаардлагууд, нутгийн иргэд, бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй бусад уурхай зэргийг судлан үзнэ. Аппианы зүгээс хариуцлагатай, зүй зохистой үйл ажиллагааны үндсэн дээр олборлох бизнесийг тогтвортой явуулж болно гэж үздэг. Улмаар нутгийн иргэдэд үр өгөөж хүртээж, цэвэр эрчим хүчний шилжилтийг хурдасгана гэсэн үзэл баримтлалтай. Аппианы БОНЗ-ын зорилго нь биологийн олон янз байдал, усны менежмент, уурхайн хаягдал, агаарын бохирдол, дуу чимээ, эрчим хүч, нүүрсхүчлийн ялгаруулалт, хүлэмжийн хий, хорт бодис зэрэгт төвлөрдөг. Мөн хүний эрх, газар ашиглалт, эмзэг бүлгийнхэн, жендэр, хөдөлмөрийн харилцаа, ажилтнууд/ нутгийн иргэдийн эрүүл мэнд болон аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, эрх зүйн хэрэгжилт, ёс зүй, авлигатай тэмцэх, ил тод байдалд хяналт шинжилгээ хийж, удирддаг.<sup>6</sup>

<sup>5</sup> <https://www.gsi-alliance.org/wp-content/uploads/2021/08/GSIR-20201.pdf>

<sup>6</sup> <https://appiancapitaladvisory.com>

Аппиан нь Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмуудын гишүүн бөгөөд 6 зарчмыг даган мөрддөг. Аппианы Тогтвортой байдлын тайланг **эндээс** үзнэ үү.

<https://appiancapitaladvisory.com/esg/sustainability-reports/>

### БиПи тэтгэврийн сан (BP Pension Fund)

БиПи тэтгэврийн сан нийт 27.3 тэрбум паундын актив хөрөнгө бүхий тэтгэврийн сан бөгөөд Хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмуудад (PRI) гарын үсэг зурж нэгджээ. Хариуцлагатай хөрөнгө оруулалтын шийдвэрт санхүүгийн материаллаг эрсдэлээс гадна БОНЗ-ын хүчин зүйлийг тусгасны үндсэн дээр эрсдэлээ удирдаж, тогтвортой, урт хугацааны өгөөж бүрдүүлдэг.

#### БиПи сангийн хариуцлагатай хөрөнгө оруулалт

**a)** БОНЗ-ын хүчин зүйлс, түүн дотроо уур амьсгалын өөрчлөлт болон үүгээр үл хязгаарлагдах бусад хүчин зүйлс нь Санд эрсдэл, боломжийн аль алийг үүсгэх ба эдгээр нь санхүүгийн хувьд материаллаг хэмжээтэй байж болно.

**b)** Хариуцлагатай хөрөнгө оруулалт хийж, урт хугацааны эрсдэлд тохируулсан өгөөж хүртэх нь Санд өөрийн үүрэг хариуцлагыг хангах боломжийг нээнэ.

**c)** Тогтоосон өгөөж бүхий хуримтлалын сангийн өр төлбөр нь харгалзан үзэх гол зүйл бөгөөд үндсэндээ урт хугацааны хөрөнгө оруулалтад хамаарна. Үүнд БОНЗ-ын хүчин зүйлс чухал ач холбогдолтой. Хуримтлагдах тэтгэврийн сангийн хувьд хөрөнгө оруулагчид бүхий л амьдралынхаа туршид хөрөнгө оруулалт хийх нь бидний хүлээлт юм.

**d)** Хөрөнгө оруулалт хүлээн авагч компани, актив хөрөнгө удирдаж буй талуудын оролцоог хангах нь өөрчлөлт гаргах үр дүнтэй арга зам бөгөөд цаашдын урт хугацааны эрсдэл тооцсон өгөөжийг нэмэгдүүлнэ. Оролцоог хангахад хөрөнгө эзэмшлээс үүдэн гарч буй саналын эрхийг идэвхтэй ашиглах явдал багтах бөгөөд боломжтой бүхий л нөхцөлд Сангийн актив хөрөнгийг зөв зохистой зарцуулах хэрэгтэй гэдэгт бид итгэл төгс байдаг.

**e)** Бидний актив хөрөнгийн удирдлага нь БОНЗ-ын боломжит хүчин зүйлсийг өөрийн хөрөнгө оруулалтын шинжилгээ, шийдвэрт тусгаж, хэрэгжүүлэх алхам болно гэдэгт найдна. Бидний зааварчилгаагаар ажиллаж, Сангийн өмнөөс хөрөнгө оруулалт хийж буй менежерүүд хүлээлтийн дагуу ажиллаж хөрөнгө оруулална гэдэгт итгэдэг.

### Блэкрок (BlackRock)

Блэкрок нь ойролцоогоор 10 тэрбум ам.долларын актив хөрөнгийг удирддаг томоохон хэмжээний институцийн хөрөнгө оруулагч юм. Тус компани БОНЗ-ын баримжаатай хөрөнгө оруулалтыг манлайлж, 2020 онд тогтвортой хөгжлийг хөрөнгө оруулалтынхаа шинэ стандарт болгожээ. Багц бүрдүүлэх, эрсдэл удирдах ажиллагаандаа бүрэн тусгаж, салшгүй хэсгээ болгосон байна. Улмаар орлогынх нь 25-аас дээш хувийг бүрдүүлдэг эрчим хүчний нүүрсний компаниудыг санхүүжилтээсээ хасжээ. Тогтвортой индекст санхүүжилт болон ногоон бонд

зэрэг илүү тогтвортой хөрөнгө оруулалтын сонголтуудыг үйлчлүүлэгчдэдээ санал болгох замаар БОНЗ-ын эрсдэл, боломжуудын талаарх тайлагналаа сайжруулсан байна.

### **Калифорни мужийн төрийн албан хаагчдын тэтгэврийн систем (The California Public Employees' Retirement System (CalPERS))**

АНУ-ын хамгийн том тэтгэврийн сан бөгөөд нийт 400 тэрбум гаруй ам.долларын актив хөрөнгийг удирддаг. Тус сан хөрөнгө оруулалтын салбарт БОНЗ-ын зарчмыг нэвтрүүлсэн анхдагч юм. Тогтвортой хөгжил, хариуцлагатай хөрөнгө оруулалт хариуцсан тусгай багуудтай бөгөөд **Тогтвортой хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй.**<sup>7</sup> Уг хөтөлбөрийн хүрээнд шинээр гарч ирсэн тогтвортой хөрөнгө оруулалтын асуудлыг судлан үзсэний үндсэн дээр санхүүгийн хамгийн өндөр үнэ цэнээр нь эрэмбэлдэг. Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа тогтвортой хөрөнгө оруулалт, БОНЗ-ын хүчин зүйлсийг харгалздаг. Тогтвортой хөрөнгө оруулалт, санхүүгийн зах зээлийн нөлөөллийн үйл ажиллагааг манлайлан, оролцогч талуудын оролцоог хангах замаар нөөц эх үүсвэрийг хамгийн өндөр боломж бүхий санхүүгийн сэдэвт чиглүүлж эрэмбэлдэг. Калифорни мужийн төрийн албан хаагчдын тэтгэврийн систем нь бүх ангиллын активыг тогтвортой хөрөнгө оруулалтын сэдвээрх төвлөрсөн удирдлага, стратегийн хүрээнд удирдан чиглүүлдэг.

### **АКСА (АХА)**

Олон улсын даатгалын компани болох Акса нь **Уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын асуудлыг тусгасан стратегитэй.** Нүүрсхүчлийн ялгарал өндөр салбарт (нүүрс, занар) хөрөнгө оруулалт хийхээс татгалзсан. Хөрөнгийн болон Гэнэтийн ослын бүтээгдэхүүн, Амьдралын болон Хуримтлалын бүтээгдэхүүний өгөөжийг "ногоон/ тогтвортой" бүтээгдэхүүн болгож, хөгжиж буй улс орнуудад зориулсан даатгалын шинэ шийдэл санал болгохдоо нүүрсний салбарт хязгаарлалт хийхээр заажээ.

### **БиЭнПи Париба (BNP Paribas)**

БиЭнПи Париба нь **Уул уурхайн салбарт баримтлах бодлогоо** тодорхойлж, дараах нөхцөлд санхүүгийн үйлчилгээ үзүүлэхгүй гэж заажээ:

• Уул уурхайн үйл ажиллагааны бүс нутаг эсвэл хамаарах байгууламж нь дараах байршилд буй бол:

- » ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн газар нутаг
- » Рамсарын конвенцын жагсаалтад багтсан ус намгархаг газар
- » Alliance for Zero байгууллагын устаж буй газрын жагсаалтад орсон бүс нутаг
- » Олон улсын байгаль хамгаалах холбооны (International Union for Conservation of Nature) I-IV ангиллын бүс нутаг

<sup>7</sup> <https://www.calpers.ca.gov/page/investments/sustainable-investments-program>



- Франц, Европын Холбоо, АНУ болон НҮБ-ын хоригт багтсан улс орнуудад;
- Зэвсэгт мөргөлдөөн идэвхтэй үргэлжилж буй газар нутагт;
- Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ILO) тодорхойлсон хүүхдийн болон албадан хөдөлмөр ашигладаг бол;
- Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1995 оны Уул уурхайн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн шаардлагуудын дагуу үйл ажиллагаа явуулаагүй бол;
- Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөгүй бол;
- Шөрмөсөн чулуу олборлодог бол;
- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны төлөвлөгөө гаргаагүй бол, үйл ажиллагаа явуулж буй төслийн хувьд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаатай холбоотой асуудал үүсэж байсан бол;
- Гар аргаар ашигт малтмал олборлодог бол;
- Хаягдлыг гол нуур, далайн усанд хаядаг бол;
- Эрчим хүчний нүүрс олборлох төсөл;
- Эрчим хүчний нүүрсэнд зориулсан дэд бүтцийн төсөл, жишээ нь боомт барих эсвэл шинэчлэх, авто болон төмөр замаар эрчим хүчний нүүрс тээвэрлэх, нүүрс хадгалах (агуулах) төсөл.

БиЭнПи Париба нь төслийн санхүүжилтийн зээл, уул уурхайн төслүүдэд зөвлөх үйлчилгээ, мөн зээлдэгч нь уул уурхайн төсөл эзэмшдэг, зээлийн 50-иас дээш хувь нь уул уурхайн чиглэлд зарцуулагддаг бизнесийн зээлүүддээ **Экваторын зарчмуудыг**<sup>8</sup> баримталдаг.

### 2.2.2. ХӨРӨНГИЙН БИРЖҮҮД

Хөрөнгийн биржүүд нь олон нийтээс хөрөнгө босгон төвлөрүүлэх боломжийг бизнесийн байгууллагуудад бүрдүүлж өгдөг. Хөрөнгийн бирж болгон бүртгэлийн журамтай. Уг журмын дагуу бүртгүүлсэн компаниуд цаашид бүхий л шаардлагыг ханган биелүүлэх үүрэг хүлээдэг. Монголын болон Австрали, Хонконгийн хөрөнгийн биржүүдийн дүрэм журам, БОНЗ-тай холбоотой шаардлагуудыг дор танилцуулж байна.

#### **Монголын хөрөнгийн бирж**

Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан **Компанийн засаглалын кодекс**<sup>9</sup> нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьд заавал даган мөрдөх шаардлага байдаг бол бусад компанийн хувьд сайн дурын шинжтэй. Кодексийн гол зорилго нь олон улсын сайн туршлагуудыг нэвтрүүлж, урт хугацааны үнэ цэн бий болгох замаар хөрөнгө оруулагчид, бусад талуудын эрх ашгийг хамгаалах явдал. Энэхүү код гол 9 зарчимтай. Үүнд ТУЗ, болон бүрэлдэхүүн, хороодын чиг үүрэг; Тайлагнал болон мэдээллийн ил тод байдал; Аудит болон хяналтын тогтолцоо; Эрсдэлийн удирдлага; Цалин урамшуулал; Компанийн соёл; болон Хувьцаа эзэмшигчийн эрх багтдаг. Бүртгэлийн ерөнхий шаардлагын хувьд компаниуд

<sup>8</sup> <https://equator-principles.com>

<sup>9</sup> <http://www.frc.mn/resource/frc/Document/2022/04/26/85t02rdnesh38wp2/Компанийн%20засаглалын%20кодекс.pdf>

дараах гол мэдээллийг олон нийтэд ил тод болгох үүрэг хүлээдэг:

- Санхүүгийн тайлангууд
- Компанийн засаглалын өөрийн үнэлгээний тайлангууд
- Гол хувьцаа эзэмшигчид, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд гарах өөрчлөлтүүд
- Үйл ажиллагааны тайлангууд
- ТУЗ-ийн хуралдаан, шийдвэрүүд

МХБ-д бүртгүүлэхээр хүсэлт гаргасан уул уурхайн компаниудыг санхүүжилт татах баримт бичигтээ дараах мэдээллийг тусгахыг шаарддаг:

- Техникийн тайлан, дүгнэлтүүд
- Ирээдүйн хэтийн төлөв, хайгуул, олборлолт, газар ашиглалт, үйлдвэрлэлийн мэдээлэл
- Хайгуул, олборлолтын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зөрчлийн мэдээлэл.

Түүнчлэн **Монголын компаниудад зориулсан БОНЗ, тогтвортой байдлын удирдамжид**<sup>10</sup> бүртгэлтэй компаниуд, бусад үнэт цаас гаргагчид нь тогтвортой байдлын бодлого, үйл ажиллагаагаа тайлагнан мэдээлэх тусгайлсан арга хэмжээ, алхмуудыг заасан байдаг. Энэхүү баримт бичигт мөн тогтвортой хөгжилтэй холбоотой мэдээллийг ил тод болгоход ашиглах үзүүлэлтийг тусгасан. Удирдамж нь бүхий л компаниудад зориулагдсан тул тодорхой нэг салбарт чиглэсэн зөвлөмжүүд багтаагүй. Одоогоор удирдамжийг дагаж мөрдөх нь сайн дурын шинжтэй ч СЗХ-ны зүгээс 2023 оноос эхлэн хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудад дээрх удирдамжийн хэрэгжилтийн тайланг гаргах шаардлага тавихаар төлөвлөж байна.

### **Австралийн хөрөнгийн бирж**

Тус хөрөнгийн биржид бүртгүүлэхэд БОНЗ-ын тайлан гаргах шаардлага тавьдаггүй. Гэсэн хэдий ч Австралийн хөрөнгийн биржийн зүгээс 2019 онд гаргасан **Компанийн засаглалын зөвлөлийн зарчим, зөвлөмжүүдэд**<sup>11</sup> (4 дүгээр хэвлэлт) шинээр нэмсэн Зөвлөмж 7.4-д “Бүртгэлтэй аж ахуйн нэгж нь байгаль орчны эсвэл нийгмийн ямар нэгэн эрсдэлийг материаллаг байдлаар үзүүлж буй бол энэхүү эрсдэлийг хэрхэн удирдаж эсвэл удирдахаар төлөвлөж буй талаар нээлттэй мэдээлж байх ёстой” гэж заажээ.

Түүнчлэн Бүртгэлийн журмын 4.10.3-т зааснаар бүртгэлтэй бүх компаниуд засаглалын тайлан гаргаж, үүнд Зөвлөлийн гаргасан зөвлөмжүүдийг тайлант хугацаанд хэрхэн хэрэгжүүлснээ тайлагнаж байхыг үүрэг болгожээ. Хэрэгжүүлээгүй бол үндэслэл, шалтгаанаа тайлбарлан, баримт нотолгоог ил

<sup>10</sup> [http://www.frc.mn/resource/frc/File/2022/04/15/h7pxzdd60hzxn1yf/БОНЗ\\_тогтвортой\\_байдлын\\_тайлагналын\\_удирдамж.pdf](http://www.frc.mn/resource/frc/File/2022/04/15/h7pxzdd60hzxn1yf/БОНЗ_тогтвортой_байдлын_тайлагналын_удирдамж.pdf)

<sup>11</sup> <https://www.asx.com.au/documents/asx-compliance/cgc-principles-and-recommendations-fourth-edn.pdf>

тод болгох үүрэгтэй. Санхүүгийн үйлчилгээний зөвлөл (FSC) болон Австралийн тэтгэврийн сангийн хөрөнгө оруулагчдын зөвлөл (ACSI)-өөс **“Австралийн компаниудад зориулсан БОНЗ тайлагналын хөтөч”**<sup>12</sup>-ийг 2015 онд гаргажээ.

### **Хонконгийн хөрөнгийн бирж**

Хонконгийн хөрөнгийн бирж (HKEX) нь бүртгэлтэй компаниуддаа БОНЗ-ын мэдээллийг ил тод болгож, хэрэгжүүлэхийг бүртгэлийн дүрэм журам болон мэдлэг олгох явцдаа үүрэг болгодог. Тус бирж 2013 онд анх БОНЗ-ын тайлагналын удирдамж гаргаснаас хойш бүртгэлтэй компаниудад тавигдах ил тод мэдээллийн шаардлагаа тогтмол шинэчилж иржээ. Үндсэн самбарт бүртгүүлэх журмын 27-р хавсралтад **Байгаль орчин, нийгэм, засаглалын тайлагналын журмыг**<sup>13</sup> тусгасан байдаг. Энд ил тод мэдээлэх хоёр шатны үүргийг: (а) заавал ил тод мэдээлэх үүрэг болон (б) “даган мөрдөх эсвэл тайлбарлах” заалтуудаар зохицуулдаг. Тус журамд тайлагнах зарчмууд, сэдэв чиглэл, хамаарах зүйлс болон БОНЗ-ын чиглэл бүрээр гүйцэтгэлийн гол үзүүлэлтийг багтаажээ.

- **Байгаль орчин, нийгэм, засаглалын тайлагналын журмыг**<sup>14</sup> жижиг дунд компаниудад зориулсан Байгууллагын өсөлтийн зах зээл (GEM)-ийн бүртгэлийн журмын Хавсралт 20-д тусгасан байдаг. Энэ хүрээнд дараах мэдээллийг ил тод мэдээлэхийг үүрэг болгодог:
- Хүлэмжийн хийн ялгаруулалт
- Нөөцийн ашиглалт
- Хүрээлэн буй орчин, байгалийн нөөц
- Уур амьсгалын өөрчлөлт
- Хөдөлмөр эрхлэлт
- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
- Сургалт, хөгжил
- Хөдөлмөрийн стандарт
- Ханган нийлүүлэлтийн сүлжээний менежмент
- Хариуцлагатай бүтээгдэхүүн
- Авлигатай тэмцэх
- Нутгийн иргэдийн оролцоо

<sup>12</sup> <https://www2.asx.com.au/content/dam/asx/about/corporate-governance-council/acsi-fsc-esg-reporting-guide-final-2015.pdf>

<sup>13</sup> <https://en-rules.hkex.com.hk/rulebook/environmental-social-and-governance-reporting-guide-0>

<sup>14</sup> <https://en-rules.hkex.com.hk/rulebook/environmental-social-and-governance-reporting-guide>

### 2.2.3. ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД

#### Олон улсын санхүүгийн корпорац (IFC)

Олон улсын санхүүгийн корпорацын гаргасан **Гүйцэтгэлийн найман стандарт**<sup>15</sup> нь ялангуяа том төслүүдийн (уул уурхайн гэх мэт) байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын асуудлыг хамаардаг. Энэхүү стандарт нь байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын нэгдсэн үнэлгээ, төслийн бүхий л хугацаанд талуудын оролцоо, байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн менежментийн ач холбогдлыг тодорхойлсон байдаг. Мөн төслийн түвшинд тайлагнах үүргийг зааж, компаниудыг тогтвортой хөгжлийн тайлан гаргахыг хөхиүлэн дэмждэг. ОУСК-ын Гүйцэтгэлийн стандартуудыг ямар ч компани ашиглаж болох бөгөөд үүнийг баримтлан ажиллах нь ОУСК-аас санхүүжилт авах урьдчилсан нөхцөл болдог. Эдгээрт дор дурдсан стандартууд багтана:

| Гүйцэтгэлийн стандартууд                                                                                  | Зорилтууд                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
|-----------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>ГҮЙЦЭТГЭЛИЙН СТАНДАРТ 1:</b><br><br><b>Нийгэм, байгаль орчны эрсдэл, нөлөөллийн үнэлгээ, удирдлага</b> | <ul style="list-style-type: none"> <li>Төслийн байгаль орчин болон нийгэмд үзүүлэх эрсдэл, нөлөөлөх байдлыг тодорхойлж, үнэлэх.</li> <li>Ажилтнууд, нутгийн иргэд болон хүрээлэн буй орчинд учирч буй эрсдэл болон нөлөөллийг урьдчилан тогтоох болон зайлсхийх арга хэмжээг эрэмбэ дараатай хэрэгжүүлэх, зайлсхийх боломжгүй бол бууруулах, нөлөөлөл зайлшгүй үлдэх тохиолдолд нөхөн олговор олгох/ дүйцүүлэх арга хэмжээ авах.</li> <li>Менежментийн тогтолцоог ашиглах замаар үйлчлүүлэгчдийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг сайжруулахыг дэмжих.</li> <li>Сөрөг нөлөөнд өртсөн нутгийн иргэд болон бусад талуудаас хүлээн авсан гомдолд хариу арга хэмжээ авч, зохистойгоор удирдах.</li> <li>Төслийн нийт хугацааны турш нутгийн иргэдэд сөргөөр нөлөөлж буй асуудлаар зохист оролцооны арга замыг дэмжсэн байгаль орчин, нийгмийн чиглэлийн мэдээллийг ил тод болгон, түгээхийг баталгаажуулж байх.</li> </ul> |
| <b>ГҮЙЦЭТГЭЛИЙН СТАНДАРТ 2:</b><br><br><b>Ажиллах хүч ба ажлын байрны нөхцөл</b>                          | <ul style="list-style-type: none"> <li>Ажилтнуудаа үл ялгаварлан гадуурхах шударга харилцаа, тэгш боломжоор хангахыг хөхиүлэн дэмжих.</li> <li>Ажилтнууд-удирдлага хооронд харилцаа үүсгэх, тогтмолжуулах, сайжруулах.</li> <li>Дотоодын ажил эрхлэлт болон хөдөлмөрийн хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангах.</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |

<sup>15</sup> [https://www.ifc.org/wps/wcm/connect/c02c2e86-e6cd-4b55-95a2-b3395d204279/IFC\\_Performance\\_Standards.pdf?MOD=AJPERES&CVID=kTjHBzk](https://www.ifc.org/wps/wcm/connect/c02c2e86-e6cd-4b55-95a2-b3395d204279/IFC_Performance_Standards.pdf?MOD=AJPERES&CVID=kTjHBzk)

|                                                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                       | <ul style="list-style-type: none"> <li>• Ажилтнуудыг (хүүхэд, цагаач ажилчин, гуравдагч талуудын ажилчид, үйлчлүүлэгчийн ханган нийлүүлэлтийн сүлжээний ажилчид) хамгаалах.</li> <li>• Эрүүл, аюулгүй ажиллах нөхцөл, ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих.</li> <li>• Албадан ажил эрхлүүлэхээс зайлсхийх.</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| <p>ГҮЙЦЭТГЭЛИЙН<br/>СТАНДАРТ 3:</p> <p><b>Нөөцийг үр ашигтай ашиглаж, бохирдлоос урьдчилан сэргийлэх</b></p>          | <ul style="list-style-type: none"> <li>• Төслийн үйл ажиллагаанаас үүсэх бохирдлоос, эсвэл бууруулах замаар хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх.</li> <li>• Эх үүсвэрийн, үүнд эрчим хүчний болон усны эх үүсвэрийн илүү тогтвортой хэрэглээг хөхиүлэн дэмжих.</li> <li>• Төсөлд хамаарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах.</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| <p>ГҮЙЦЭТГЭЛИЙН<br/>СТАНДАРТ 4:</p> <p><b>Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал</b></p> | <ul style="list-style-type: none"> <li>• Хэвийн болон хэвийн бус нөхцөлд төслийн бүхий л хугацаанд сөрөг нөлөөнд өртөж буй нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлийг урьдчилан таамаглаж, зайлсхийх.</li> <li>• Ажилтнууд болон эд хөрөнгийг хамгаалах үйл ажиллагааг хамаарсан хүний эрхийн зарчмуудын дагуу сөрөг нөлөөнд өртөж буй нутгийн иргэдэд тулгарах эрсдэлээс зайлсхийж, бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх.</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |
| <p>ГҮЙЦЭТГЭЛИЙН<br/>СТАНДАРТ 5:</p> <p><b>Газар чөлөөлөлт, албадан нүүлгэн суурьшуулалт</b></p>                       | <ul style="list-style-type: none"> <li>• Төслийн сонголтод бусад төлөвлөлтийг эрэлхийлэх замаар нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх, боломжгүй бол бууруулах.</li> <li>• Хүчээр нүүлгэн шилжүүлэхээс зайлсхийх.</li> <li>• Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх үйл явцад нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, хэрэв зайлсхийх боломжгүй бол (i) эд хөрөнгийн нөхөн олговрыг тухайн эд хөрөнгийг нөхөхүйц хэмжээгээр олгох, (ii) нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой мэдээллийг зохистой байдлаар ил тод болгох, зөвлөлдөх, сөрөг нөлөөлөлд өртсөн хүмүүсийн оролцоог ханган, нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар сөрөг нөлөөллийг бууруулах.</li> <li>• Нүүлгэн шилжүүлсэн хүмүүсийн амьжиргаа, амьдралын чанарыг сайжруулах, эсвэл сэргээх.</li> <li>• Нүүлгэн шилжүүлсэн газарт хангалттай хэмжээний амьдрах байр орон сууц эзэмших эрхийг баталгаатайгаар хангах замаар нүүлгэн шилжүүлсэн хүмүүсийн амьжиргааны нөхцөлийг сайжруулах.</li> </ul> |

|                                                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>ГҮЙЦЭТГЭЛИЙН<br/>СТАНДАРТ 6:</p> <p><b>Биологийн олон янз<br/>байдлын хамгаалал,<br/>амьд байгалийн<br/>нөөцийн тогтвортой<br/>удирдлага</b></p> | <ul style="list-style-type: none"> <li>• Биологийн олон янз байдлыг хамгаалж, хадгалан үлдээх.</li> <li>• Экосистемийн үйлчилгээнээс үзүүлэх үр өгөөжийг хадгалан үлдээх.</li> <li>• Амьд байгалийн нөөцийн тогтвортой менежментийг байгаль орчныг хамгаалах болон хөгжлийн тэргүүлэх чиглэл тогтоох бүхий л шатанд хангах.</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| <p>ГҮЙЦЭТГЭЛИЙН<br/>СТАНДАРТ 7:</p> <p><b>Нутгийн уугуул иргэд</b></p>                                                                              | <ul style="list-style-type: none"> <li>• Хөгжлийн үйл явц нь хүний эрх, эрхэм чанар, хүсэл тэмүүлэл, соёл, уугуул иргэдийн байгалийн нөөцөд суурилсан амьжиргааг бүрэн хүндэтгэхийг баталгаажуулах.</li> <li>• Төслийн зүгээс нутгийн иргэд болон уугуул оршин суугчдад үзүүлж болох сөрөг нөлөөллийг урьдчилан тогтоож, эдгээрээс зайлсхийх, хэрэв зайлсхийх боломжгүй бол тухайн сөрөг нөлөөллийг бууруулах/багасгах болон/эсвэл нөхөн олговор олгох.</li> <li>• Тогтвортой хөгжлийн өгөөж болон боломжуудыг уугуул иргэдийн соёлд нийцтэй арга замаар түгээн сурталчлах.</li> <li>• Төслийн бүхий л хугацааны туршид сөрөг нөлөөнд өртөж буй уугуул иргэдтэй зөвлөлдөх, мэдээлэл оролцоог хангасан байнгын харилцаа үүсгэх, үргэлжлүүлэн хадгалах.</li> <li>• Энэхүү гүйцэтгэлийн стандартад дурдсан нөхцөл байдал үүссэн тохиолдолд нөлөөнд өртсөн болон уугуул иргэдэд урьдчилан мэдээлэл өгөх, тэднээс санал зөвшөөрөл авсан байхыг баталгаажуулах.</li> <li>• Уугуул иргэдийн соёл, мэдлэг, арга ажиллагааг хүндэтгэх, хадгалан үлдээх.</li> </ul> |
| <p>ГҮЙЦЭТГЭЛИЙН<br/>СТАНДАРТ 8:</p> <p><b>Соёлын өв</b></p>                                                                                         | <ul style="list-style-type: none"> <li>• Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллөөс соёлын өвийг хамгаалах, хадгалан үлдээхэд дэмжлэг үзүүлэх.</li> <li>• Соёлын өвийг ашигласнаас үүдэх өгөөжийг тэгш хуваарилах явдлыг дэмжин урамшуулах.</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |

### Европын сэргээн босголт, хөгжлийн банк (EBRD)

Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) нь Монгол Улс дахь хамгийн том хувийн хэвшлийн хөрөнгө оруулагч бөгөөд нийт 2,275 сая еврогийн багцтай. Одоогоор ЕСБХБ нь Монгол Улсад 32 төслийг санхүүжүүлж буйгаас 4 нь “Монголын Алт”, “Алтайн хүдэр”, “Оюутолгой”, ЖиСиАр зэрэг компаниудын уул уурхайн төсөл байна.

ЕСБХБ-наас хөрөнгө оруулсан болон зээл авсан бүх компани **Байгаль орчин, нийгмийн бодлогыг**<sup>16</sup> нь даган мөрдөх үүрэг хүлээдэг. Төслийн нөхцөл байдлаас хамааран ЕСБХБ-ны зүгээс Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийхийг шаардаж болно. Төслийн үйл ажиллагааг удирдаж буй талууд санхүүжилтийн баримт бичигт дурдсан БОНЗ-ын шаардлагуудыг биелүүлэх үүрэг хүлээнэ. ЕСБХБ-ны үйлчлүүлэгчид Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон, Нийцлийн тайланг олон нийтэд ил тод болгох үүрэг хүлээдэггүй.

#### Шаардлагууд нь дараах 10 чиглэлд хамаардаг:

1. Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ болон менежмент
2. Ажиллах хүч, нөхцөл
3. Нөөцийн үр ашигтай байдал, бохирдлоос сэргийлэх болон хянах
4. Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал
5. Газар чөлөөлөх, газар ашиглалтад тавигдах хязгаарлалт, албадан чөлөөлөлт
6. Биологийн олон янз байдлыг хамгаалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент
7. Уугуул иргэд
8. Соёлын өв
9. Санхүүгийн зуучлагчид
10. Мэдээлэл ил тод болгох, оролцогч талуудын оролцоо

<sup>16</sup> <https://www.ebrd.com/news/publications/policies/environmental-and-social-policy.html>

## 2.2.4. АРИЛЖААНЫ БАНКНУУД

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкууд нь агаарын бохирдлыг бууруулах, ногоон барилга, эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр ногоон эдийн засгийг дэмжсэн зээлийн бүтээгдэхүүнүүдийг санал болгож байна. Ногоон зээлийн нийт 40 гаруй бүтээгдэхүүн байгаа бөгөөд дэдгээр бүтээгдэхүүний тоо, олгож буй банкуудыг доорх график харууллаа.

График 6.

### Монгол Улсын арилжааны банкуудын ногоон зээлийн бүтээгдэхүүнүүд

|                                                                                    |   |                                                                                   |                                                                                    |   |                                                      |
|------------------------------------------------------------------------------------|---|-----------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------|---|------------------------------------------------------|
|   | 5 | Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх:<br>ХААН, Хас, Голомт, Төрийн банк,<br>Капитрон |   | 4 | Хог хаягдал:<br>ХХБ, Голомт, Капитрон, Төрийн банк   |
|   | 2 | Ногоон барилга:<br>Голомт, Ариг                                                   |   | 4 | Хөдөө аж ахуй:<br>ХААН, Хас, Төрийн банк             |
|   | 9 | Бохирдол бууруулах /агаар, хөрс/:<br>ХААН, Хас, ХХБ, Капитрон, Ариг банк          |   | 6 | Тээвэр:<br>Хас, ХХБ, Капитрон, Ариг, Төрийн банк     |
|  | 3 | Усны хэмжилт:<br>ХААН, ХХБ, Капитрон банк                                         |  | 8 | Байгаль хамгаалал:<br>ХААН, ХХБ, Голомт, Төрийн банк |

Эх сурвалж: Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо



## ХААН БАНК

Тус банкны ногоон зээл нь жижиг, дунд болон томоохон бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эрчим хүч, ус, материалын үр ашигтай, зохистой хэрэглээ, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, хог хаягдлын менежментийг сайжруулах зориулалттай зээлийг санхүүжүүлдэг. Энэхүү зээлийг олгохдоо хөндлөнгийн зөвлөх үйлчилгээний байгууллагаас зээлээр санхүүжүүлэх үйл ажиллагаа ногоон зээлийн шаардлагыг хангаж буй эсэх дүгнэлт гаргуулах бөгөөд тус үйлчилгээний зардлыг ХААН банк хариуцдаг.

Мөн ЕСБХБ-ны тодорхойлсон эрчим хүчний хэмнэлттэй технологи буюу <https://techselector.com/mongolia-en/> вэб сайтад заасан техник, тоног төхөөрөмжийг худалдан авах тохиолдолд шууд санхүүжүүлэх боломжтой.

| Төрөл                                              | Боломжит харилцагч                                                                                                                                                                | Боломжит төсөл                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | Давуу тал                                                                                                                                                                                                                                                                                              |
|----------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Ногоон барилга, эрчим хүчний хэмнэлт бүхий барилга | <ul style="list-style-type: none"> <li>• Зочид буудал</li> <li>• Ресторан</li> <li>• Оффисын зориулалттай барилга</li> <li>• Супермаркет</li> <li>• Үйлдвэрлэл эрхлэгч</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүчний хэмнэлттэй халаалтын болон хөргөлтийн систем</li> <li>• Барилгын дулаалга (хана, дээвэр, шал, цонх)</li> <li>• Эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг, гэрлийн шил</li> <li>• (LED эсвэл катодын флюорисент гэрэл)</li> <li>• Нарны фотоволтайк систем</li> <li>• Нарны цахилгаан үүсгүүр ашигласан ус халаах систем</li> <li>• Ногоон барилгын гэрчилгээ</li> <li>• Ухаалаг систем (цахилгаан, ус ашиглалтын)</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүчний хэрэглээ болон зардал буурна</li> <li>• Тав тух нэмэгдэнэ</li> <li>• Ажилчдын ажлын бүтээмж нэмэгдэнэ</li> <li>• Барилгын зах зээлийн үнэлгээ нэмэгдэнэ</li> <li>• Зочид буудал, рестораны хувьд үйлчлүүлэгчид болон орлого нэмэгдэнэ</li> </ul> |

| Төрөл                                     | Боломжит харилцагч                                                                                                                                                                                              | Боломжит төсөл                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | Давуу тал                                                                                                                                                                                                                                                                                                     |
|-------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шинэчлэл | <ul style="list-style-type: none"> <li>• Хүнсний үйлдвэр</li> <li>• Нэхмэлийн үйлдвэр</li> <li>• Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр</li> </ul>                                                              | <ul style="list-style-type: none"> <li>• Хүнс боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж</li> <li>• Нэхмэл сүлжмэлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж</li> <li>• Тоон хяналтын системтэй тоног төхөөрөмж</li> </ul>                                                                                                                                                                                                                                                              | <ul style="list-style-type: none"> <li>• Үйлдвэрлэлийн гарц нэмэгдэнэ</li> <li>• Бүтээгдэхүүний чанар сайжирна</li> <li>• Цахилгааны хэрэглээ, зардал буурна</li> <li>• Ажиллах хүчний бүтээмж нэмэгдэнэ</li> <li>• Өндөр үнэтэй түүхий эд, материалын хэрэглээ багасна</li> <li>• Хаягдал багасна</li> </ul> |
| Үйлдвэрлэл                                | <ul style="list-style-type: none"> <li>• Хүнс болон шингэн хүнс боловсруулах үйлдвэрлэл</li> <li>• Хүнс үйлдвэрлэл</li> </ul>                                                                                   | <ul style="list-style-type: none"> <li>• Шарах төхөөрөмж</li> <li>• Хатаалтын тоног төхөөрөмж</li> <li>• Уурын бойлер</li> <li>• Халуун усны бойлер</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                           | <ul style="list-style-type: none"> <li>• Бүтээгдэхүүний гарц нэмэгдэнэ</li> <li>• Аюулгүй байдал сайжирна</li> <li>• Эрчим хүч болон түлшний хэрэглээ багасна</li> <li>• Бүтээгдэхүүний төрөл нэмэгдэж, чанар сайжирна</li> </ul>                                                                             |
| Хөргөлтийн системийн тоног төхөөрөмж      | <ul style="list-style-type: none"> <li>• Хүнс, шингэн хүнс боловсруулах үйлдвэрлэл</li> <li>• Жижиглэн худалдаа болон супермаркет</li> <li>• Зочид буудал, ресторан</li> <li>• Логистикийн үйлчилгээ</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Хөргөлтийн систем</li> <li>• Битүүмжлэл сайтай хөргүүрийн өрөө</li> <li>• Хөргөлтийн кабинет</li> <li>• Мөс үйлдвэрлэх тоног төхөөрөмж</li> <li>• Хөргөх төхөөрөмжтэй, агаарын хүйтэн/дулаан урсгалын эргэлт тохируулах хавхлаг, тохируулга бүхий дулааны насостой агааржуулагч төхөөрөмж</li> <li>• Цонх, хана, тааз эсвэл шаланд бэхлэх зориулалттай агааржуулагч төхөөрөмж</li> <li>• Дулаан барьдаг хадгалах сав</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Бүтээгдэхүүний чанар сайжирна</li> <li>• Эрүүл ахуйн нөхцөл, стандарт сайжирна</li> <li>• Хүнсний аюулгүй байдал нэмэгдэнэ</li> <li>• Эрчим хүчний хэрэглээ, зардал буурна</li> </ul>                                                                                |

| Төрөл                                      | Боломжит харилцагч                                                                                                                                                     | Боломжит төсөл                                                                                                                                                                             | Давуу тал                                                                                                                                                                                                                                                                                               |
|--------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Тээвэр                                     | <ul style="list-style-type: none"> <li>• Логистик үйлчилгээний компани</li> <li>• Зорчигч тээврийн компани</li> </ul>                                                  | <ul style="list-style-type: none"> <li>• Түлшний хэмнэлттэй суудлын автомашин</li> <li>• Түлшний хэмнэлттэй ачааны машин</li> </ul>                                                        | <ul style="list-style-type: none"> <li>• Түлшний хэрэглээ, зардал багасна</li> <li>• CO2 ялгарал багасна</li> <li>• Яндангаас гарах бусад бохирдол багасна</li> </ul>                                                                                                                                   |
| Биомасс                                    | <ul style="list-style-type: none"> <li>• Тариалан эрхлэгч</li> <li>• Мал аж ахуй эрхлэгч</li> <li>• Цагаан идээ, хүнс үйлдвэрлэгч</li> </ul>                           | <ul style="list-style-type: none"> <li>• Цахилгаан эсвэл дулаан гаргах биомасс бойлер/ конгенерацын станц</li> <li>• Цахилгаан эсвэл дулаан гаргах био хийн үйлдвэр</li> </ul>             | <ul style="list-style-type: none"> <li>• Цахилгаан, дулааны зардал хэмнэнэ</li> <li>• Цахилгааны төв сүлжээ болон уламжлалт түлшнээс хамаарал бага</li> <li>• Үйлдвэрлэсэн цахилгааныг төв сүлжээнд нийлүүлж орлого олох боломжтой</li> </ul>                                                           |
| Фотоволтайк систем<br>Photovoltaic systems | <ul style="list-style-type: none"> <li>• Үйлдвэрлэгчид</li> <li>• Жижиглэнгийн худалдаа болон супермаркет</li> <li>Ресторан</li> <li>Газар тариалан эрхлэгч</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Дээвэр дэх фотоволтайк систем</li> <li>• Цахилгааны төв шугамд холбогдсон фотоволтайк систем</li> <li>• Бие даасан фотоволтайк систем.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Цахилгааны зардал бага</li> <li>• Үйлдвэрлэсэн цахилгааныг төв сүлжээнд нийлүүлж орлого олох боломжтой</li> <li>• Үйлдвэрлэлийн явцад дуу чимээ бага</li> <li>• Арчилгаа бага</li> </ul>                                                                       |
| Бага оврын усан цахилгаан станц            | <ul style="list-style-type: none"> <li>• Бага оврын усан цахилгаан станцад хөрөнгө оруулагч</li> </ul>                                                                 | <ul style="list-style-type: none"> <li>• Голын урсгалыг ашиглан эрчим хүч гаргах усан цахилгаан станц</li> </ul>                                                                           | <ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүч үйлдвэрлэн худалдах</li> <li>• Баталгаат эрчим хүчээр хангагдах</li> <li>• Бохирдолгүй эрчим хүчний үйлдвэрлэл</li> <li>• Байгалийн нөөцийг үр ашигтай ашиглан эрчим хүч үйлдвэрлэх</li> </ul>                                                       |
| Тоног төхөөрөмж үйлдвэрлэл, худалдаа       | <ul style="list-style-type: none"> <li>• Үйлдвэрлэл эрхлэгч</li> <li>• Худалдаа эрхлэгч</li> </ul>                                                                     | <ul style="list-style-type: none"> <li>• Ахуйн хэрэглээний нарны панел</li> <li>• Эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг</li> <li>• Барилгын дулаалга</li> </ul>                              | <ul style="list-style-type: none"> <li>• Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт авах боломж</li> <li>• Орчин үеийн, үр ашиг өндөр бүтээгдэхүүн санал болгож орлогоо нэмэгдүүлэх</li> <li>• Өрсөлдөөний давуу тал</li> <li>• Зах зээлд байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлдэг тул нэр хүнд өснө.</li> </ul> |



Хас банк нь хүлэмжийн хийн ялгарлыг хамгийн багадаа 20%-иар бууруулах бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдаалах, суурилуулах төсөлд ногоон зээл олгож байна. Зээлийн зориулалт нь дараах байдлаар байж болно:

36

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ГАРЫН АВЛАГА

| Зориулалт                                             | Ашиглаж болох чиглэл:                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
|-------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Барилгын засвар, сайжруулалт (цахилгааны хувьд)       | <ul style="list-style-type: none"> <li>• Цахилгаан утас;</li> <li>• Трансформатор;</li> <li>• Цахилгааны тоолуур;</li> </ul>                                                                                                                                                                                                                                                             |
| Барилгын засвар, сайжруулалт (барилгын бүтцийн хувьд) | <ul style="list-style-type: none"> <li>• Дулаан тусгаарлалт (бүтцийн болон шугам сүлжээний);</li> <li>• Барилгын дулаалгын материал;</li> <li>• Агааржуулалт.</li> </ul>                                                                                                                                                                                                                 |
| Халаалт, хөргөлтийн систем                            | <ul style="list-style-type: none"> <li>• Усан халаалтын зуух сайжруулах эсвэл солих;</li> <li>• Эйр кондейшн;</li> <li>• Дулааны тоолуур;</li> <li>• Агааржуулалт.</li> </ul>                                                                                                                                                                                                            |
| Тоног төхөөрөмжийн шинэчлэл                           | <ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж;</li> <li>• Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж;</li> <li>• Боловсруулах тоног төхөөрөмж (усны хэмнэлттэй тоног төхөөрөмж, хаягдал ус цэвэршүүлэх төхөөрөмж);</li> <li>• Хөлдөөгч, хөргөгчийн систем.</li> </ul>                                                                                              |
| Хог хаягдлаас эрчим хүч гаргах                        | <ul style="list-style-type: none"> <li>• Хаягдал/ илүүдэл эрчим хүч ашиглах (Цемент, тоосго, ноолуур үйлдвэрлэлийн);</li> <li>• Хог хаягдлаас эрчим хүч үйлдвэрлэх (дулааны эрчим хүч үйлдвэрлэх).</li> </ul>                                                                                                                                                                            |
| Сэргээгдэх эрчим хүч/ Эрчим хүчний бусад эх үүсвэр    | <ul style="list-style-type: none"> <li>• Нар, салхи, ус, газрын гүний эрчим хүчний систем (нарны ус халаагч);</li> <li>• Дизель болон сэргээгдэх эрчим хүчний хосолсон үүсгэвэр;</li> <li>• Биохий;</li> <li>• Биомасс.</li> </ul>                                                                                                                                                       |
| Цэвэр түлш / Сайжруулсан түлш                         | <ul style="list-style-type: none"> <li>• Хийн түлш (газ);</li> <li>• Энгийн хөдөлгүүртэй машин, автобусыг газ хөдөлгүүртэй эсхүл газ бензин хосолмол хөдөлгүүртэй болгох;</li> <li>• Био дизель, Био-Этанол түлш;</li> <li>• Шахмал түлш: <ul style="list-style-type: none"> <li>- Коксжсон нүүрс</li> <li>- Био массын шахмал түлш</li> <li>- Үртсэн шахмал түлш</li> </ul> </li> </ul> |
| Бусад                                                 | <ul style="list-style-type: none"> <li>• Хүлэмжийн хийг дор хаяж 20%-иар бууруулах бизнес төслүүд</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                             |



Голомт банкны зээлдэгч нарт байгаль орчны зорилтуудад ихээхэн хувь нэмэр оруулахуйц төслүүдэд боломж олгосон санхүүжилтийн нэг хэлбэр нь Ногоон зээл юм. Зээлдэгчийн бизнесийн үндсэн үйл ажиллагаа нь Монголбанкны гаргасан Ногоон таксаномид багтсан байх ёстой<sup>17</sup> ба үйл ажиллагаа болон зээлийн зориулалт нь Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээгээр “бага эрсдэлтэй” хэмээх ангилалд багтсан байхын зэрэгцээ банкны зүгээс дотооддоо хийдэг байгаль орчин, нийгмийн эрсдэлийн судалгаагаар эрсдэлийн түвшний шалгуурт нийцсэн байх шаардлагатай. Банк нь зээлийн эрсдэл, байгаль орчин, нийгэм, хүний эрх, соёлын өвд үзүүлэх нөлөөллийг судлахаас гадна зээлийн багцын БОНЗ-ын эрсдэлийн үнэлгээний мэдээллийн сан бүрдүүлдэг.


2021 онд Голомт банк ойролцоогоор 1,340 бизнесийн зээл олгосноос 64%-д байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ хийжээ. Барилга, үйлдвэрлэл, уул уурхай, дэд бүтэц болон нефть хими зэрэг байгаль орчин, нийгэмд эрсдэл бүхий салбаруудад Голомт банк 298 зээл олгосноос 213-д нь БОНЗ-ын дэлгэрэнгүй үнэлгээ хийжээ.

Доорх хүснэгтээс Голомт банкны 2019-2021 оны ногоон зээлийн багцын талаарх статистик мэдээллийг үзнэ үү (сая төгрөгөөр).

|                                | 2019         |       | 2020      |       | 2021      |       |
|--------------------------------|--------------|-------|-----------|-------|-----------|-------|
| Бизнесийн зээл                 | 1,991,474.60 | 5%    | 1,833,208 | 59.8% | 1,991,276 | 58.2% |
| Бөөний болон жижиглэн худалдаа | 498,171      | 15.1% | 493,367   | 16.1% | 739,101   | 21.6% |
| Уул уурхай                     | 261,650      | 7.9%  | 414,758   | 13.5% | 325,661   | 9.5%  |
| Үйлдвэрлэл                     | 396,004      | 12.0% | 272,260   | 8.9%  | 205,294   | 6.0%  |
| Засвар үйлчилгээ               | 32,808       | 1.0%  | 57,865    | 1.9%  | 202,104   | 5.9%  |
| Барилга                        | 387,019      | 11.8% | 252,791   | 8.2%  | 137,095   | 4.0%  |
| Санхүү                         | 15,790       | 4.6%  | 136,792   | 4.5%  | 101,696   | 3.0%  |
| Олон улсын байгууллага         | -            | 0.0%  | -         | 0.0%  | 87,828    | 2.6%  |
| Тээвэр, харилцаа холбоо        | 103,171      | 3.1%  | 61,233    | 2.0%  | 60,711    | 1.8%  |
| Үл хөдлөх хөрөнгө              | 21,602       | 0.7%  | 34,010    | 1.1%  | 32,120    | 0.9%  |
| Зочид буудал, ресторан         | 38,789       | 1.2%  | 31,937    | 1.0%  | 30,896    | 0.9%  |
| Хөдөө аж ахуй                  | 25,758       | 0.8%  | 18,375    | 0.6%  | 17,524    | 0.5%  |
| Эрүүл мэнд                     | 25,504       | 0.8%  | 19,324    | 0.6%  | 16,775    | 0.5%  |
| Боловсрол                      | 13,006       | 0.4%  | 11,739    | 0.4%  | 13,521    | 0.4%  |
| Цахилгаан холбоо               | 17,150       | 0.5%  | 15,574    | 0.5%  | 12,720    | 0.4%  |
| Богино хугацаат зээл           | 10,286       | 0.3%  | 5,167     | 0.2%  | 4,593     | 0.1%  |
| Нийгмийн үйлчилгээ             | 1,157        | 0.0%  | 909       | 0.0%  | 1,783     | 0.1%  |
| Аялал жуулчлал                 | 7,036        | 0.2%  | 6,657     | 0.2%  | 1,689     | 0.0%  |
| Бизнес эрхлэлт                 | 476          | 0.0%  | 412       | 0.0%  | 164       | 0.0%  |
| Нийтийн үйлчилгээ              | 1,090        | 0.0%  | 37        | 0.0%  | -         | 0.0%  |

Эх сурвалж: Голомт банкны Тогтвортой хөгжлийн тайлан 2021

<sup>17</sup> <http://toc.mn/ufiles/uploaded/files/1600244565177.pdf>



Танилцуулга

БОНЗ-ын экосистем

### БҮЛЭГ 3. БОНЗ-ЫН АРГАЧЛАЛ

Судалгааны жишээ:  
Брумадино (Brumadinho) дахь хаягдлын  
далан задарсан түүх

Хавсралт 1, 2

## Бүлэг 3. БОНЗ-ын аргачлал

### АРГАЧЛАЛ 1: БОНЗ-ЫН ШААРДЛАГУУДЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ХЭРХЭН КОМПАНИД НЭВТРҮҮЛЭХ ВЭ?

#### АРГАЧЛАЛ 1

Ямар аргачлал вэ?

Энэхүү аргачлал нь аливаа компанид БОНЗ-ын талаарх үзэл баримтлалыг алхам алхмаар нэвтрүүлэхэд туслах хөтөч юм.

Яагаад энэ нь ач холбогдолтой вэ?

Аргачлал нь бүхий л компани ашиглаж болох нийтлэг хүрээлэл/бүтцийг тусгасан.

Хэрхэн ашиглах вэ?

1. Заасан алхмуудыг даган мөрдөж, онцлог зүйлсийг нь өөрийн компанид тусгах боломжтой.
2. Жишээг судлан үзнэ үү.

Хэрэв та уул уурхайн компанийг төлөөлж буй бол БОНЗ-ын чиглэлийн аяллаа хэдийнэ эхлүүлсэн гэсэн үг. Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулахын тулд тусгай зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Танд олгосон тусгай зөвшөөрлийг дагалдан хэд хэдэн нөхцөл, шаардлага тавигддаг. Жишээ нь Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулиар<sup>18</sup> хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, газар болон ус ашиглах гэрээ байгуулсан байх үүрэгтэй – Доор буй шигтгээг үзнэ үү.

<sup>18</sup> <https://legalinfo.mn/mn/detail/63>

## МОНГОЛ УЛСЫН АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

### 38 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг

38.1. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

38.1.1 Тусгай зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор байгаль орчны хяналтын алба болон хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргатай зөвшилцөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулах;

38.1.2 Энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөнд хүрээлэн байгаа орчны бохирдолтыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээг тусгах;

38.1.3 Энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөг тухайн хайгуулын талбай байрших сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж батлуулах;

38.1.4 Энэ хуулийн 38.1.3-т заасны дагуу батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хувийг хайгуулын талбай байршиж байгаа орон нутгийн байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх;

38.1.5 Хайгуулын ажлын явцад үүссэн байгаль орчны сөрөг нөлөөллийг тухай бүр бүртгэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний жилийн тайланд тусгах бөгөөд уг тайланг байгаль орчны хяналтын алба болон тухайн сум, дүүргийн Засаг даргад хүргүүлэх;

38.1.6 Энэ хуулийн 38.1.5-д заасан тайланд байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хайгуулын ажилд ашигласан шинэ техник, технологи, байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх чиглэлээр төлөвлөгөөнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай саналыг тусгаж уг өөрчлөлтийг сум, дүүргийн Засаг даргаар батлуулах;

38.1.7 Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтанд хайгуулын талбайд нэвтрэн орох, газар дээр нь шалгалт хийх бололцоо олгох;

38.1.8 Байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх.

38.2. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 38.1.3, 38.1.6-д заасан төлөвлөгөө, түүний өөрчлөлтийг хүлээн авснаасаа хойш 10 хоногийн дотор хянан баталж тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.

38.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 38.1.8-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна.

38.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн бол энэ хуулийн 38.1.8-д заасан хөрөнгийг түүнд буцааж өгнө.



### **39 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг**

39.1 Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

39.1.1 Энэ хуулийн 24.1-д заасан этгээд ашиглалтын тусгай зөвшөөрөл авахын өмнө, сонгон шалгаруулалтын журмаар ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд уг зөвшөөрөл авсны дараа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах;

39.1.2 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тухайн уурхайн ажиллагааны явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг урьдчилан тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлох;

39.1.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд уурхайн ажиллагааг байгаль орчинд хохирол багатай явуулах, агаар мандал болон усны бохирдолт, хүн, амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээг тусгах;

39.1.4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд энэ хуулийн 39.1.3-т зааснаас гадна дараах зүйлийг тусгах:

39.1.4.1. хортой болон хор хөнөөл учруулж болзошгүй бодис, материалыг хадгалах, хяналт тавих;

39.1.4.2. газрын гадаргуугийн болон гүний усыг хамгаалах, ашиглах, хуримтлуулах;

39.1.4.3. уурхайн хаягдлын далан барих, уурхайн талбайн аюулгүй байдлыг хангах;

39.1.4.4. энэ хуулийн 38.1.2-т заасан нөхөн сэргээх арга хэмжээ;

39.1.4.5. тухайн уурхайн ажиллагааны онцлогтой холбогдсон бусад арга хэмжээ.

39.1.5. Энэ хуулийн 39.1.1-д заасны дагуу боловсруулсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

39.1.6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдмагц тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тэдгээрийн хуулбарыг тухайн ашигт малтмалын орд байршиж байгаа нутаг дэвсгэрийг харьяалах аймаг, сум, дүүргийн Засаг дарга болон байгаль орчны хяналтын албанд хүргүүлэх;

39.1.7. Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан сөрөг нөлөөллийг тухай бүр бүртгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон тайланг жил бүр гарган байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн аймаг, сум, дүүргийн Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад тус тус хүргүүлэх бөгөөд уг тайланд дараах зүйлийг тусгах:

39.1.7.1. байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;

39.1.7.2. ашигласан шинэ техник, технологи;

39.1.7.3. үйлдвэрийг өргөтгөж хүчин чадлыг нь нэмэгдүүлсний улмаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнтэй холбогдуулан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал.

39.1.8. Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтанд уурхайн талбайд нэвтрэн орох, газар дээр нь шалгалт хийх бололцоо олгох;

39.1.9. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8-д заасны дагуу зохицуулна.

Дээрхийн нэгэн адил танай компанид хэдийнэ хэрэгжээд эхэлчихсэн байх магадлал бүхий олон тооны бусад үзэл баримтлалууд ч байдаг. Тиймээс байгаа зүйлсээ БОНЗ-ын үүднээс судлан үзэж, БОНЗ-ын нэгдмэл хүрээлэлд уялдуулан хэрэгжүүлэхийн тулд системтэй, зорилтот арга хандлагыг ашиглах нь зүйтэй. БОНЗ-ын үзэл баримтлалуудыг нэвтрүүлэх бодит алхмуудыг График 7-гоос үзнэ үү.

График 7.

### БОНЗ-ын үзэл баримтлалуудыг нэвтрүүлэх алхмууд



#### Алхам 1: Өнөөгийн нөхцөл байдал, статусаа тодорхойл

- Байгууллагын өөрийн үнэлгээг хийж гүйцэтгэх: Хөдөлмөрийн харилцаа, байгаль орчны үнэлгээ, хөрөнгө оруулагчдын харилцаа, бусад БОНЗ-тай хамаарах өгөгдөл, мэдээллийг цуглуулж эхэл. Энэ нь БОНЗ-ын чиглэлд хамаарах бодлого, хэдийнэ хэрэгжиж буй санаачилга зэргээр дамжуулан байгууллагынхаа суурь нөхцөл байдлыг ойлгоход тань тусална.
- Эрх зүй, зохицуулалтын орчин, түүнчлэн өнөөгийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчийнхаа БОНЗ-ын шаардлага, сонирхлыг судлан шинжлэх.
- Салбар болон хэмжээ цар хүрээний хувьд ижил төстэй эсвэл ижил үнэт зүйл бүхий компаниудын БОНЗ-ын орчин нөхцөлийг судлах.
- Байгууллагынхаа одоогийн стратеги, арга хандлагад буй дутагдал, хийдлийг дүн шинжилгээ хийж тодорхойлох.

## **Алхам 2: БОНЗ-ын чиглэлээрх манлайлал/ удирдлагын хүсэл эрмэлзлийг тогтоо**

- Манлайллын хүсэл эрмэлзэл, хичээл зүтгэлийг удирдан залахад дараах алхмуудыг харгалзан үз: ТУЗ-ийн түвшинд БОНЗ-ын стратегийг гаргах, хянах чиг үүрэг бүхий БОНЗ-ын хороо байгуулах. Бусад арга замын хувьд одоо үйл ажиллагаа явуулж буй хороодын чиг үүргийг өргөтгөн, БОНЗ-ын асуудлыг багтаах (шинэ хороо байгуулахын оронд) эсвэл БОНЗ-ын чиг үүргийг аль нэг хороонд даалгаж болно (Аргачлал 8 дээр үзнэ үү).
- Удирдлагад БОНЗ-ын стратегийг боловсруулах болон хэрэгжүүлэх үүргийг оногдуулах шаардлагатай. БОНЗ/Тогтвортой хөгжлийг тусдаа нэг чиг үүрэг болгох эсвэл бизнесийн үйл ажиллагааны бусад салбарт тус тусад нь хэрэгжүүлж болохын зэрэгцээ ирэх жилүүдэд хамгийн их амжилттай байх бизнесийн чиг үүрэгт БОНЗ-ын чиглэлийн үйл ажиллагааг тусгах боломжтой.
- БОНЗ-тай хамаарал бүхий үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүргийг бий болгох талаар судлах.

## **Алхам 3: Байгууллагын стратеги, бодлого болон зорилтуудыг тодорхойл (Аргачлал 2 дээр үзнэ үү)**

- Хэмжээ цар хүрээний хувьд ижил төстэй бусад компанийн баримталж буй стратеги, арга хандлагыг судлан үз.
- Хэрэв шаардлагатай/ боломжтой бол бусад гаднын талуудаас тусламж ав.
- БОНЗ-ын өндөр түвшний стратеги, арга хандлагыг боловсруул.
- Бодит, хүрэх боломжтой ч амбиц өндөртэй зорилтуудыг БОНЗ-ын чиглэлээр эрэмбэлсэн салбаруудаар гарга.
- Төсөв, хэрэгжих хугацаа болон эх үүсвэрүүдийг тогтоо.

## **Алхам 4: БОНЗ-ын тогтолцоог бүрдүүл**

- Оролцогч талуудыг тодорхойл (Аргачлал 3 дээр үзнэ үү).
- Материаллаг нөлөө бүхий сэдэв, хэмжээс болон гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдийг тогтоож, шийд (Аргачлал 4 дээр үзнэ үү).
- Өөрийн компанид тохирох тайлагналын хүрээллийг судлан, сонголт хий (Аргачлал 5 дээр үзнэ үү).
- Өгөгдөл цуглуулах, тайлагнах, ил тод мэдээлэх үйл явцыг бий болго.

## **Алхам 5: БОНЗ-ын стратегийг хэрэгжүүл**

- Өөрийн зорилгодоо хүрэхийн тулд БОНЗ-ын стратегийг хэрэгжүүл (Аргачлал 6 болон 7 дээр үзнэ үү).

## **Алхам 6: Хэрэгжилтэд хяналт- шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд шинэчил**

- Зорилгоо хэрэгжүүлэх, мониторинг хийх арга замуудыг бий болго.
- Бодлого, стратеги, зорилтуудыг эргэн харж, шаардлагатай бол шинэчил.
- БОНЗ-ын чиглэлээр гарч буй ахиц дэвшлийг компанийн хэмжээнд (бизнесийн бүхий л бүтцэд) мэдээлж, компанийн баримталж буй БОНЗ-ын арга хандлагад үндэслэн, цаашид нөөц бололцоо гарахад нэг эсвэл дээш тооны БОНЗ-ын чиглэлийг нэмж үргэлжлүүл.

## АРГАЧЛАЛ 2: КОМПАНИЙН ДОТООД ДАХЬ БОНЗ-ЫН БАРИМТ БИЧГҮҮД

### АРГАЧЛАЛ 2

Ямар  
аргачлал  
вэ?

Энэхүү аргачлал нь танд компанидаа харгалзан үзэх БОНЗ-тай хамаарах баримт бичгүүдийн жагсаалтыг өгнө.

Яагаад  
энэ нь ач  
холбог-  
долтой  
вэ?

БОНЗ-ын баримт бичигтэй байх нь хөрөнгө оруулагчид, бусад талуудад БОНЗ-ын арга ажиллагааныхаа талаар тодорхой мессеж хүргэх боломж олгоно.

Хэрхэн  
ашиглах  
вэ?

1. Харгалзан үзэж болох баримт бичгүүдийн жагсаалтыг судлах.
2. БОНЗ-ын бодлого болон зарчмуудад тусгах асуудлуудыг судлах.
3. Бусад уул уурхайн компаниудын жишээг ашиглан БОНЗ-ын асуудлыг үндсэн баримт бичгүүдэд тусгах.

БОНЗ-ын эрсдэл болон боломжуудад үр дүнтэй хариу арга хэмжээ авдаг байхын тулд байгууллагынхаа эрхэм зорилго, алсын хараанд БОНЗ-ыг тусгах, хамаарах бодлого, зарчмуудыг боловсруулах нь чухал. БОНЗ-ын зарчмуудыг хэрэгжүүлэх эрмэлзэлтэй, энэ талаар ойлголттой гэдгээ илтгэн харуулснаар уул уурхайн компаниуд нь оролцогч талууддаа итгэлцэл бий болгож, нийгмийн зөвшөөрлөө баталгаажуулах боломжтой.

Түүнчлэн хэмжигдэхүйц зорилго, зорилт бүхий тодорхой стратеги чухал ач холбогдолтой юм. Эдгээрийг батлан хэрэгжүүлж эхэлснээр байгууллагынхаа цахим хуудсаар тогтмол мэдээлж хэвших нь зүйтэй.

Энэхүү аргачлалд зориулан бид БОНЗ-ын зарчмуудтай нийцүүлсэн эсвэл шинээр боловсруулсан бодлогын голлох баримт бичгийн жишээг оруулж, компаниуд эдгээр баримт бичгийг хэрхэн боловсруулах талаар дурдсан болно.

### Эрхэм зорилго, алсын хараа

Компаниуд БОНЗ-ын чиглэлээр манлайлал үзүүлж буйгаа харуулахын тулд тогтвортой хөгжил, БОНЗ-ын үзэл баримтлалыг эрхэм зорилго, алсын хараандаа тусгадаг. Ялангуяа уул уурхай нь байгалийн нөөцийг асар ихээр ашиглагдаас гадна байгаль орчин, нийгэм, эдийн засаг болон нутгийн иргэдэд нөлөөлөл үзүүлдэг салбарын хувьд илүү тогтвортой, хариуцлагатай байх зарчмаа алсын хараа, эрхэм зорилгодоо тусгах нь чухал байдаг.

“Ягуар Майнинг Инк” компани алсын хараа, эрхэм зорилгоо хэрхэн тодорхойлсныг дор үзүүлэв.

### ЯГУАР МАЙНИНГ ИНК (JAGUAR MINING INC)

“Ягуар Майнинг Инк” (Jaguar Mining Inc) нь Канадад бүртгэлтэй алтны хайгуул, олборлолтын жижиг дунд компани. Бразил улсад уул уурхайн гурван төсөлтэй. Хайгуул хийж буй талбайн хэмжээ ойролцоогоор 65,000 га байна.



**ЭРХЭМ ЗОРИЛГО:** Уул уурхайн салбар дахь хамгийн шилдэг арга ажиллагааг ашиглан, ажилтнууд болон үйл ажиллагаа явуулж буй орчиндоо эрүүл аюулгүй, сайн сайхан байдлыг хангах замаар оролцогч талууддаа тогтвортой үнэ цэн бий болгон, нэмэгдүүлэх.



**АЛСЫН ХАРАА:** Тогтвортой үйлдвэрлэлд төвлөрсөн алт олборлолтын компани болж хүлээн зөвшөөрөгдөх, шилдэг үйл ажиллагааг хангах эрмэлзлээ хэрэгжүүлэн, ажилтнуудаа үнэлэн, хөгжүүлэх.



#### ҮНЭТ ЗҮЙЛС:

- **Тэг хохирол** - Ажилтнууд, нутгийн иргэд болон байгаль орчинд үл хохирол учруулах нь бидний зорилго байна.
- **Эрхэм чанар, хүндлэл** - Эрхэм чанар, хүндлэлд суурилсан ил тод байдлаар бүх ажилтнуудад тэгш хандаж, боломж нээж өгөх, өөриймшүүлэх мэдрэмжийг түгээн дэлгэрүүлнэ.
- **Тогтвортой байдал** - Аюулгүй, ашигтай, нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаагаар дэмжигдсэн тогтвортой өсөлтийг хангаж, урт хугацааны нөөц эх үүсвэрийг хөгжүүлнэ.
- **Хамтын ажиллагаа** - Бүхий л оролцогч талууд, олон нийт, орон нутгийн иргэд болон төрийн байгууллагуудтай бүтээлч, ёс зүйтэй хамтын ажиллагаа тогтоож, ил тод, идэвхтэй харилцан яриаг өрнүүлнэ.
- **Тэргүүлэл** - Бизнесийн хамгийн сайн арга ажиллагаанд төвлөрсөн соёлыг бүрдүүлнэ.

### БОНЗ-ын бодлого, зарчмууд

Компаниуд нь БОНЗ-ын гол санаа, арга хандлагуудаас сонгон авах байдлаар байгууллагынхаа БОНЗ-ын бодлогыг боловсруулан гаргаж болно. Жишээ нь “Бритиш Интернейшл Инвестмент компани **БОНЗ-ын гарын авлагадаа**<sup>19</sup> байгаль орчин, нийгмийн бодлогоо боловсруулахдаа дараах зөвлөмжүүдийг хэрхэн хэрэгжүүлснээ заажээ.

<sup>19</sup> <https://toolkit.bii.co.uk>

| Хэлэлцүүлгийн сэдэв/<br>асуултууд                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | Баталгаажуулалт,<br>мэдээллийн эх сурвалж                                                                                                                                                                                                                                                          | Аргачлал, зөвлөгөө                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <ul style="list-style-type: none"> <li>Компанийн бодлого нь байгаль орчин, засаглалын гол эрсдэл, боломжууд дээр төвлөрч байна уу?</li> <li>Энэ нь асуудлыг бүхлээр нь (үүнд хөдөлмөр, ажил эрхлэлтийн үйл явц, ханган нийлүүлэлтийн сүлжээ, бусад гуравдагч талуудыг багтаагаад) хамарч, компанийн хангахаар төлөвлөж буй стандартуудыг бүрэн тодорхой тусгаж байна уу?</li> <li>Бодлого нь байгаль орчин, нийгмийн ямар стандартуудыг хангахыг зорьж байна уу?</li> <li>Бодлогын хэрэгжилт, хяналтын чиг үүрэг, үүрэг хариуцлагууд ямар байх, хэнд хамаарах вэ?</li> <li>Бодлогын талаар ажилтнууд болон бусад талуудтай зөвлөлдсөн үү (мөн хөрөнгө оруулагчидтай)?</li> <li>Бодлого нь олон нийтэд нээлттэй, гарч буй ахиц дэвшлийн талаар нийтэд хандан тайлагнах уу?</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Дараах талуудтай уулзалт хийх (шаардлагатай бол):</li> <li>Дээд удирдлага</li> <li>Хүний нөөцийн ажилтнууд</li> <li>Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтнууд</li> <li>Ажилтнууд</li> <li>Гэрээт гүйцэтгэгчид (хамааралтай тохиолдолд)</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Хамгийн сайн бодлого нь ихэнхдээ товч, тодорхой үг хэллэгтэй байдаг. Бодлогын бичвэрийг хэрэгжилтийн зааварчилгаатай хослуулах (Стандарт үйл ажиллагааны журам) Менежментийн протоколд тусгасан болон компанийн нийгмийн хариуцлагын талаар (компанийн үүсгэж буй гол эрсдэл болон асуудлуудад төвлөрөөгүй) дурдсан Бодлогын хувьд эдгээрийг хослуулан тусгасан байх ёстой.</li> <li>Бодлогод дараах зүйлс туссан байна: <ul style="list-style-type: none"> <li>Байгаль орчин, нийгмийн чиглэлийн өндөр хэмжээний гүйцэтгэлийг хангахын тулд байгаль орчин, нийгмийн зорилтууд, зарчмуудыг тодорхой боловсруулан гаргасан байх.</li> <li>Байгаль орчин, нийгмийн үнэлгээ, удирдлагын үйл явцын хүрээллийг тусгасан байх.</li> </ul> </li> </ul> |

| Хэлэлцүүлгийн сэдэв/<br>асуултууд                                                                                      | Баталгаажуулалт,<br>мэдээллийн эх сурвалж | Аргачлал, зөвлөгөө                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <ul style="list-style-type: none"> <li>Бодлого нь цаашид хувьсан өөрчлөгдөж байна гэдгийг юугаар нотлох вэ?</li> </ul> |                                           | <ul style="list-style-type: none"> <li>- Компани нь дотоодын болон хамаарах олон улсын эрх зүй, хууль тогтоомж, дүрэм журмыг баримталж, боломжтой тохиолдолд олон улсын стандартуудыг (жишээ нь ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандартууд) ханган биелүүлэхээ дурдан заах.</li> <li>- Бодлогын хэрэгжилтийг хариуцах этгээдийг тодорхойлох.</li> <li>- Үйл ажиллагааны бүхий л шатанд, бүхий л талуудад мэдээллийг хүргэдэг, нээлттэй байлгах.</li> <li>- Удирдлагын гишүүдийн төлөөлөл баталж, тодорхой огноо тавьсан байх.</li> </ul> |

Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Беовулф Майнинг” (Beowulf Mining) компани БОНЗ-ын зарчмуудаа хэрхэн тодорхойлсон жишээг дор танилцуулав.

### БЕОВУЛФ МАЙНИНГ ИНК

“Беовулф Майнинг ПиЭлСи”-ийн эрхэм зорилго нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг ногоон эдийн засгийн шилжилтэд шаардлагатай чухал ашигт малтмалыг олборлох замаар хувьцаа эзэмшигчид төдийгүй нийгэм болон байгаль орчинд үнэ цэнийг бий болгогч шинэлэг, хариуцлагатай компани байх явдал юм. Бид уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг байгаль орчин болон нийгэмд нөлөөлөл үзүүлж, өгөөж бий болгох боломжтой салбарт үйл ажиллагаа явуулж буйгаа бүрэн дүүрэн ойлгож байна. БОНЗ-ын чиглэлээрх дэлхийн түвшний арга туршлагыг хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлэх замаар нүүрсхүчлийн тэг ялгарал бүхий тогтвортой ирээдүйд шилжихэд материаллаг дэмжлэг үзүүлэх боломж бидэнд гарч байна. Бид БОНЗ-ын дараах зарчмуудыг бизнесийн стратеги, үйл ажиллагаандаа тусгаж, оролцогч талуудын хүлээлт, олон улсын стандартуудыг бүрэн хангах гүйцэтгэлийг хийнэ.

#### БИД БҮХЭН:

1. Олон улс, дотоодод хэвшин тогтсон байгаль орчин, нийгэм, засаглал, ёс зүйн стандартуудыг даган мөрдөж буйгаа баталгаажуулж, илтгэн харуулж байх.
2. Хүртээмжтэй, тэгш, олон янз байдал болон хүний эрхийг хүндэтгэсэн байгууллагын соёлыг бүрдүүлж, тогтвортой хадгалах.
3. Ажилтнууд, хөрөнгө оруулагчид, ханган нийлүүлэгчид, нутгийн иргэд, эрх эзэмшигчид болон үйлчлүүлэгчдээ тодорхойлж, тэднийг сонсож, зөвлөлдөх, оролцоог хангах замаар БОНЗ-той холбогдох асуудал, үзэл бодлыг таньж мэдэх.
4. Ажилтнууд, үйл ажиллагаа болон бүтээгдэхүүний сөрөг нөлөөлөлд өртөж буй хүмүүсийн эрүүл аюулгүй, сайн сайхан байдлыг ханган баталгаажуулж байх.
5. Уурхайн бүхий л мөчлөгийн туршид анхны үзэл баримтлал болон ТЭЗҮ-ээс эхлээд үйл ажиллагаа, нөхөн сэргээлт, хаалтын үе шат хүртэл БОНЗ-ын удирдлагын хүрээллийг хэрэгжүүлэх.
6. Байгаль орчин, нийгмийн аливаа нөлөөллөөс зайлсхийх, бууруулах гүйцэтгэлээ сайжруулахын тулд шийдвэр гаргах явцдаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, цэвэр өгөөжийн арга аргачлалыг тусган хэрэгжүүлэх.
7. Тогтвортой, хариуцлагатай худалдан авах ажиллагааны хүрээнд БОНЗ-ын стандарт, ёс зүйн дүрмүүдийг даган мөрдөхийг ханган нийлүүлэгч талуудаас шаардах.
8. Нутгийн иргэдтэй түншлэн, тэдний нийгэм-эдийн засгийн хөгжлийг материаллаг байдлаар дэмжих.
9. БОНЗ-ын зарчмуудыг нэвтрүүлэхэд гарч буй ахиц дэвшлээ ил тод мэдээлдэг байх.



### БОНЗ-ЫН УДИРДЛАГЫН ХҮРЭЭЛЭЛ НЬ ДАРААХ АНГИЛЛЫН ДАГУУ ҮНДСЭН 12 ЧИГЛЭЛД ТӨВЛӨРСӨН БАЙНА:

- **Байгаль орчин:** Агаар мандлын болон хүлэмжийн хийн ялгарал, Биологийн олон янз байдал, Шингэн хаягдлын удирдлага, Нөөцийн хэрэглээ болон үр ашигт байдал, Хог хаягдлын удирдлага
  - **Нийгэм:** Нутгийн иргэдийн оролцоо болон хөгжил, Соёлын өв, Хүний капитал, Хүний эрх, Уугуул иргэд, Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
  - **Засаглал:** Онцгой үеийн бэлэн байдал, Засаглал болон ёс зүй, Тогтвортой худалдан авалт болон Ханган нийлүүлэлтийн сүлжээний менежмент
- Эдгээр чиглэл тус бүрээр бид өндөр амбиц бүхий зорилтуудыг дэвшүүлж, түүндээ мониторинг хийн, удирдаж, үр дүнг нь хэвлэн нийтэлж байх болно.

### БОНЗ-ын зорилго, зорилт

БОНЗ-ын зорилго, зорилтууд нь компанийн тогтвортой байдлыг хангах стратегийн амин чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Зорилго, зорилтуудыг тодорхойлохдоо SMART (Specific- Онцлог, Measurable- Хэмжигдэхүйц, Achievable- Хүрэх боломжтой, Relevant- Хамааралтай, Time-Bound- Цаг хугацаатай) зарчмыг баримтлах нь зүйтэй. БОНЗ-ын зорилгууд нь компанийн үйл ажиллагаа, оролцогч талуудад хамаарсан байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлуудад төвлөрдөг. Эдгээр зорилтыг тодорхойлохдоо бодит үзүүлэлт, хэмжээсийг ашиглах нь тогтвортой байдлыг хангах чиглэлд гарч буй ахицаа хэмжихэд тустай юм.

Байгаль орчны зорилгууд нь хүлэмжийн хийн ялгарал, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ, ус болон хог хаягдлын менежменттэй холбоотой үзүүлэлтүүд болон байгаль орчны эрсдэлийг бууруулахтай холбоотой байна. Нийгмийн зорилтууд нь ажилтнуудын олон янз байдал болон хүртээмж, хөдөлмөрлөх эрх, хүний эрх, орон нутгийн хөгжил, эдгээрт хамаарах хэмжүүр болох жендэрийн харьцаа, цөөнхийн харьцаа, орон нутгийн төслүүдэд хуваарилсан санхүүжилт зэрэг юм. Засаглалын зорилгуудад ТУЗ-ийн олон талт байдлыг сайжруулах, ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах, ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх зэрэг багтана. Засаглалын зорилгыг хэмжих үзүүлэлтэд ТУЗ дэх цөөнхийн төлөөлөл, гишүүдийн ур чадварын нийлмэлийн хувь хэмжээ, авлигын эсрэг бодлоготой эсэх зэрэг нь багтаж болно. БиЭйчПи компанийн БОНЗ-ын зорилгуудыг жишээ болгон дор харууллаа.

## БИЭЙЧПИ (ВНР)

Нийгмийн үнэт зүйлийн талаарх бидний хандлага бол нийгмээ илүү тогтвортой ирээдүйд хөтлөхөд шаардлагатай бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх үүрэг хариуцлага юм. Энэхүү үүргээ БиЭйчПи компани хариуцлагатайгаар гүйцэтгэхийг хичээдэг. Бидний тогтвортой байдлын менежмент нийгмийн үнэт зүйлийг бүрдүүлэхэд тусалдаг. Манай оролцогч талууд, түншлэгчид тогтвортой байдлын гүйцэтгэлд илүүтэй төвлөрч БиЭйчПи болон манай салбарыг үнэлэх гол үзүүлэлтээ болгож байна. Бид энэхүү хүлээлтэд нийцсэн гүйцэтгэлийг үзүүлэх төдийгүй байнга сайжруулж, хүлээлтээс ч давах болно.

### ЗОРИЛГУУД:

**Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах** - Бидний үйл ажиллагаатай холбоотойгоор ялгарч буй хүлэмжийн хийг багадаа 30% бууруулах; БиЭйчПи компанийн бүтээгдэхүүнийг тээвэрлэдэг далайн тээврийн хөлөг онгоцны хүлэмжийн хийг 40%-иар бууруулахад дэмжлэг үзүүлэх, ган үйлдвэрлэлийн явц дахь хүлэмжийн хийн ялгарлыг 30%-иар бууруулахад шаардлагатай технологи, арга замыг бий болгоход дэмжлэг үзүүлэх.

**Эрүүл орчин** - Байгаль орчны нөхөн сэргээлт, хамгаалах үйл ажиллагаа хэрэгжүүлж буй газрын багадаа 30%-д нь эерэг үр дүн гаргах. Ингэхдээ үйл ажиллагаанд хамаарах болон үл хамаарах экосистемийн өндөр үнэ цэн бүхий газруудад төвлөрч, уугуул иргэд болон нутгийн иргэдтэй түншлэн ажиллана.

**Уугуул иргэдтэй түншлэх** - Уугуул иргэдийн эрх, хүсэл тэмүүлэл, ирээдүйн төлөвлөгөөг сонсож, хүндэтгэлтэй харилцаа үүсгэн, харилцан үр ашигтай байж өгөөж хүртээхэд дэмжлэг үзүүлэх.

**Хөгжин цэцэглэж буй, эрх мэдэл бүхий нутгийн иргэд** - Эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжлийг хангах төлөвлөгөөг хамтран боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлээр нутгийн иргэд болон оролцогч талуудтай түншлэн ажиллах.

**Аюулгүй, хүртээмжтэй ирээдүйд бэлтгэгдсэн ажиллах хүч** - Эрүүл, аюулгүй, бүх шатандаа жендэрийн тэнцвэртэй, соёлын олон талт, ур чадвар бүхий ажиллах хүчийг бий болгоно.

**Ханган нийлүүлэлтийн хариуцлагатай сүлжээ** - Түншлэгч талуудтайгаа хамтран тогтвортой, ёс зүйтэй, ил тод ханган нийлүүлэлтийн сүлжээ үүсгэнэ.

### Бусад баримт бичгүүд

Компаниудын батлан хэрэгжүүлэх БОНЗ-ын багц баримт бичгүүдэд үндсэн гурван чиглэлээр хязгаарлагдахгүйгээр бусад төрлийн бодлого, дүрэм журмууд багтаж болно. Уул уурхайн бараг бүх компаниуд байгаль орчин, эрүүл, аюулгүй ажлын байранд хамаарах дүрэм журмуудтай байдаг. Үүний зэрэгцээ олон талт байдал болон хүртээмж, авлигын эсрэг, хүний эрхийг хамгаалах, ялгаварлан гадуурхахгүй байх, хариуцлагатай худалдан авалт, шүгэл үлээх бодлого зэрэг баримт бичгийг батлан хэрэгжүүлэх боломжтой.

#### Жишээг үзнэ үү:

• Сандвик (Sandvik) компанийн ханган нийлүүлэгчдийн дүрэм:

<https://www.home.sandvik/en/about-us/sustainability/governance-and-compliance/code-of-conduct/supplier-code-of-conduct/>

• Элексир (Elixir) компанийн Авлига, хээл хахуулийн эсрэг бодлого:

<https://elixirenergy.com.au/wp-content/uploads/2022/11/EXR-Anti-Bribery-Corruption-Policy.pdf>

### АРГАЧЛАЛ 3: ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЗУРАГЛАЛЫГ ХЭРХЭН ГАРГАХ ВЭ?

#### АРГАЧЛАЛ 3

Ямар  
аргачлал  
вэ?

Энэхүү аргачлал нь БОНЗ-ын чиглэлээр ашигладаг нэг гол үзэл баримтлал болох оролцогч талуудыг зураглах аргыг танилцуулна.

Яагаад  
ах  
холбог-  
долтой  
вэ?

БОНЗ нь тухайн компани болон бизнесийн үйл ажиллагаанаас оролцогч талуудад үзүүлдэг нөлөөллийг авч үзэх бөгөөд оролцогч талуудаа ойлгох нь БОНЗ-ын чухал хүчин зүйл юм.

Хэрхэн  
ашиглах  
вэ?

1. Тодорхойлолтыг судлан үзэх.
2. Төрөл бүрийн оролцогч тал болон тэдэнд компанийн зүгээс үзүүлж буй нөлөөллийг судлан үзэх.
3. Тодорхой алхам, арга техникуудийг ашиглан оролцогч талуудыг зураглах.

Олон улсын тайлагналын санаачилга (GRI) нь оролцогч талуудыг “таны үйл ажиллагааны нөлөөнд ашиг сонирхол нь өртөж буй талууд” хэмээн тодорхойлсон байдаг. Тиймээс тухайн улс, компанийн зүгээс ямар сөрөг нөлөө үзүүлж буйгаас хамааран оролцогч талууд өөр өөр байх хэдий ч бүхий л оролцогч талыг тодорхойлж, зураглан гаргах нь чухал.

### Оролцогч талуудын жишээ:

1. Бизнесийн түншүүд
2. Иргэний нийгмийн байгууллагууд
3. Салбарын холбоод
4. Хэрэглэгч, үйлчлүүлэгчид
5. Ажилтнууд болон бусад ажилчид
6. Үйлдвэрчний эвлэл
7. Төрийн байгууллагууд
8. Төрийн бус байгууллагууд
9. Хувьцаа эзэмшигчид, санхүүжүүлэгчид
10. Ханган нийлүүлэгчид
11. Нутгийн иргэд

### Харгалзан үз:

- Оролцогч тал бүр бизнестэй шууд хамааралтай байдаггүй
- Гэвч зарим үед бизнесийн үйл ажиллагаа нь тэдний ашиг сонирхолд ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлдэг.

Ерөнхийдөө компаниуд оролцогч талуудыг зураглахдаа түгээмэл ашигладаг дараах алхмуудыг хэрэгжүүлж болно.

**1) Гол оролцогч талуудыг тодорхойлох:** Сөрөг нөлөөнд өртөж буй эсвэл компанийн үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэр, гүйцэтгэлд нөлөөлж буй хувь хүмүүс, бүлэг, байгууллагуудын жагсаалтыг бэлтгэн гаргах. Үүнд ажилтнууд, үйлчлүүлэгчид, ханган нийлүүлэгчид, хөрөнгө оруулагч, зохицуулах эрх бүхий байгууллага, нутгийн иргэд, ТББ-ууд болон бусад ашиг сонирхол бүхий талуудыг харгалзан үзнэ.

**2) Оролцогч талуудын ерөнхий шинж байдал, хэрэгцээ, хүлээлтэд дүн шинжилгээ хийх:** Оролцогч талуудыг тодорхойлж, ангилсны дараа тэдгээрийн хэрэгцээ, хүлээлт болон тулгарч буй асуудалд дүн шинжилгээ хийх нь чухал. Үүнд судалгаа, ярилцлага, фокус бүлэг болон оролцооны бусад арга аргачлалыг ашиглаж болно.

**3) Оролцогч талуудыг эрэмбэлэх:** Оролцогч талуудын шинжилгээнд үндэслэн компанийн зүгээс хамгийн их нөлөөлөл үзүүлж буй талуудыг эрэмбэлэн тогтооно.

**4) Нөлөөллийн үнэлгээ боловсруулах:** Оролцогч талуудын зураглал, дүн шинжилгээнд үндэслэн нөлөөллийн үнэлгээг боловсруулна.


Компаниудын оролцогч талуудын жагсаалт, тэдгээрт үзүүлж буй нөлөөлөл өөр өөр байх бөгөөд үйл ажиллагаа явуулж буй салбараас хамааран эрс ялгаатай байж болно.

Зэс болон нүүрсний компаниудын жишээн дээр оролцогч талуудад үзүүлдэг ялгаатай нөлөөллийг судлан үзье. Үйл ажиллагаанаас хамааран байгаль орчинд үзүүлж буй ялгаатай нөлөөлөл нь бүтээгдэхүүний эцсийн хэрэглээнээс шалтгаалан хувьсан өөрчлөгдөж байдаг. Зэсийн уурхай нь сэргээгдэх эрчим хүч, эрүүл мэнд, барилга, цахилгаан машины хөгжилд шаардлагатай металлын хүдрийг үйлдвэрлэдэг. Тэгвэл нүүрс олборлолт нь эсрэгээрээ хүлэмжийн хий ихээр ялгаруулахаас гадна бусад бохирдуулагч бодисыг ус болон агаар мандалд

цацдаг цахилгаан станцын нүүрсний хэрэгцээг хангадаг. Үүний улмаас нүүрсний уурхайнууд агаарын бохирдолд өртөгч олон тооны оролцогч талуудтай байдаг.

Доорх зурагт буй оролцогч талуудыг зураглах аргыг мөн ашиглах боломжтой.

График 8.



Эх сурвалж: [www.mural.co](http://www.mural.co)

Компанийн оролцогч талуудыг зураглах нь БОНЗ-ын стратеги боловсруулах чухал үе шат юм. Энэ нь компанийн тогтвортой хөгжилд чухал үүрэг бүхий талуудыг тодорхойлох, эрэмбэлэх боломжийг олгодог. Оролцогч талуудтай идэвхтэй, үр дүнтэй хамтран ажиллаж, оролцоог нь хангаснаар итгэлцэл бий болж, нэр хүндээ сайжруулахын зэрэгцээ оролцогч талуудтайгаа хамтын үнэт зүйл бүтээж чадна.

## АРГАЧЛАЛ 4: МАТЕРИАЛЛАГ НӨЛӨӨЛЛИЙГ ХЭРХЭН ТОДОРХОЙЛОХ ВЭ?

### АРГАЧЛАЛ 4

Ямар  
аргачлал  
вэ?

Энэхүү аргачлал нь БОНЗ-ын чиглэлээр ашигладаг гол үзэл баримтлал болох материаллаг нөлөөллийг танилцуулж, үүнийг хэрхэн тодорхойлох алхам бүрийг тусгасан хөтөч юм.

Яагаад  
энэ нь ач  
холбог-  
долтой  
вэ?

БОНЗ нь компани эсвэл бизнесээс оролцогч талуудад үзүүлдэг нөлөөллийг авч үздэг тул өөрийн үзүүлж буй нөлөөлөл, тэр дундаа материаллаг нөлөөллийг сайтар ойлгох нь БОНЗ-ын чухал хэсэг байдаг.

Хэрхэн  
ашиглах  
вэ?

1. Тодорхойлолтыг шалгах.
2. Материаллаг нөлөөллийг тодорхойлох алхмуудыг ашиглах.
3. Нүүрсний салбарт тогтоосон материаллаг нөлөөллийн жишээ болон бусад салбаруудын материаллаг нөлөөллийг судлан үзэх.

### Материаллаг нөлөөлөл болон үүнийг тодорхойлох алхмууд

Материаллаг байдал, материаллаг сэдэв эсвэл материаллаг нөлөөлөл зэрэг нь ямар ч байгууллагын хувьд БОНЗ-ын тогтолцоо, тогтвортой хөгжлийг ярихад зайлшгүй хөндөгдөх чухал үзэл баримтлалуудын нэг юм. Олон улсын тайлагналын санаачилга (GRI) нь БОНЗ-ын хүрээнд “нөлөөллийг” дараах байдлаар тодорхойлдог. “Материаллаг нөлөөлөл гэдэг нь байгууллагын зүгээс эдийн засаг, хүрээлэн буй орчин, хүмүүс болон хүний эрхэд үзүүлж буй хамгийн том нөлөөллийг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг.<sup>20</sup>

Компани өөрийн үзүүлж буй материаллаг нөлөөлөл, тэр тусмаа материаллаг сөрөг нөлөөллийг тодорхойлдог байх ёстой. Олон улсын тайлагналын санаачилгаас материаллаг нөлөөллийг тодорхойлохдоо дараах 4 алхмыг ашиглахыг зөвлөдөг.

#### Нөлөөлөл

Байгууллагаас эдийн засаг, байгаль орчин, хүмүүс болон хүний эрхэд үзүүлж буй эсвэл үзүүлж болох нөлөөлөл бөгөөд үүгээр дамжуулан тогтвортой хөгжилд үзүүлж буй хувь нэмрийг (эерэг болон сөрөг) тусган харуулдаг.

#### Олон улсын тайлагналын санаачилга

<sup>20</sup> <https://globalreporting.org/publications/documents/english/gri-3-material-topics-2021/>

График 9.

### Материаллаг нөлөөллийг тодорхойлох нь



### Алхам 1. Компанийн үйл ажиллагаа, бизнесийн харилцаа, тогтвортой байдал, оролцогч талуудад үнэлгээ хийх

#### 1. Үйл ажиллагаанд дараах зүйлс багтаж болно:

- Зорилго, үнэт зүйл, эрхэм зорилго
- Бизнесийн загвар болон стратеги
- Үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл
- Салбар, ажилтнууд болон бусад ажилчид

#### 2. Бизнесийн харилцаа гэдэгт франчайз, ханган нийлүүлэлт, хамтарсан аж ахуйн нэгж, үйлчилгээ, ханган нийлүүлэлт зэрэг төрлүүдийг авч үзнэ,

#### 3. Салбарын болон орон нутгийн, олон улсын түвшний сорилтуудыг багтаасан тогтвортой байдлын орчин; эрх зүйн болон зохицуулалтын шаардлагууд,

#### 4. Оролцогч талууд,

#### Харгалзан үз:

- Өөрийн хяналтад байдаг болон нэмүү өртгийн сүлжээн дэх ашиг сонирхол/ хувьцаа бүхий компанийг тооцон харгалз.
- Энэхүү нөлөөлөлд танай компанийн үйл ажиллагаа ямар хамааралтай вэ?
- Орон нутаг, бүс нутаг, дэлхийн хэмжээнд гарч буй эдийн засаг, байгаль орчин, хүний эрх болон нийгмийн бусад өөрчлөлт.

## Алхам 2. Бодит болон боломжит нөлөөллийг тодорхойлох

Нөлөөлөл нь бодитоор үүсэж буй эсвэл үүсэн гарах боломжтой нөлөөлөл байхаас гадна эерэг болон сөрөг байна.

График 10.

56

### Нөлөөллийн ангилал



Эерэг нөлөөлөл  
Бодит  
Боломжит



Сөрөг нөлөөлөл  
Бодит  
Боломжит

Эх сурвалж: Олон улсын тайлагналын санаачилга (GRI)

Эерэг нөлөөлөлд тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмэр, харин сөрөг нөлөөлөлд оролцогч талууддаа хор хохирол учруулж буйг хэлнэ. Бодит нөлөөлөл гэдэгт бодитоор үүссэн, хэдийнэ гарсан эсвэл гарч буй нөлөөллийг хэлнэ. Боломжит нөлөөлөл гэж компанийн үйл ажиллагаанаас хамааран ирээдүйд гарч болох нөлөөлөл юм.

Нөлөөллийг тодорхойлохын тулд бизнесийн байгууллагууд үйл ажиллагаандаа үнэлгээ хийж, оролцогч талууддаа үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөллийг зураглах шаардлагатай. Энэхүү үйл явцад компани оролцогч талуудтайгаа зөвлөлдөж болно.

## Алхам 3. Нөлөөллийг ач холбогдлоор нь үнэлэн үзэх

Компаниуд нь оролцогч болон хамаарах талууддаа нөлөөлөл үзүүлж болох олон талтай тул нийт үйл явцынхаа хүрээнд эдгээрийг харгалзан үзэх нь чухал байдаг.

График 11.

### Компаниуд оролцогч талууддаа хэрхэн нөлөөлдөг вэ?




Эх сурвалж: Олон улсын тайлагналын санаачилга (GRI)



Нөлөөллийн жагсаалтыг нэгтгэн гаргасны дараа тухайн нөлөөллийн ноцтой байдал, ялангуяа сөрөг нөлөөллийн ноцтой байдлыг үнэлэх. Үүнд бодит болон боломжит нөлөөллийг багтаана. Бодит сөрөг нөлөөллийг ноцтой байдлаар нь хэмжин үнэлэхдээ хамрах хүрээгээр нь тодорхойлно. Харин боломжит сөрөг нөлөөллийн хувьд үүсэх магадлалыг харгалзан үзнэ.

График 12.

**Сөрөг нөлөөллийг  
хэмжих нь**



Эх сурвалж: Олон улсын тайлагналын санаачилга (GRI)

**Алхам 4. Материаллаг нөлөөллийг сонгож, тодорхойлох**

Сүүлийн алхам нь доорх графикт дүрслэн харуулсан үйл явцыг хэрэгжүүлэх замаар материаллаг нөлөөллийг сонгож, жагсаалтыг эцэслэн гаргах юм.

График 13.

**Материаллаг нөлөөллийг сонгох нь**



Эх сурвалж: Олон улсын тайлагналын санаачилга (GRI)

## Материаллаг нөлөөллийн жишээнүүд

Хамгийн түгээмэл хүрээллийн нэг болох Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартаар (SASB) **Нүүрсний салбарын 10 материаллаг сэдвийг**<sup>21</sup> тодорхойлжээ:

- 1. Хүлэмжийн хийн ялгаруулалт** – Нүүрс олборлолт нь эрчим хүч ихээр хэрэглэдэг, хүлэмжийн хийн ялгарал өндөртэй үйлдвэрлэл. Олборлох болон олборлолтын дараах үйл ажиллагааны үеэр нүүрсний давхаргаас метан хий ялгардаг бол түлшний хэрэглээнээс нүүрсхүчлийн давхар исэл ихээр ялгардаг.
- 2. Усны менежмент** – Нүүрс олборлолт нь орчныхоо усны нөөц болон чанарт ихээхэн нөлөөлөл үзүүлдэг төдийгүй усны хэрэглээ өндөртөйд тооцогддог. Нүүрсэнд агуулагдаж буй хүхрийг цэвэрлэх зорилготой нүүрс угаах үйл явц, өрөмдлөгийн тоног төхөөрөмжийг хөргөх, шугам хоолойн шингэн тээвэрлэлт зэрэг нь ус ихээр хэрэглэдэг. Эдгээр эрсдэлийн ноцтой байдал нь тухайн бүс нутгийн усны хангамж, зохицуулалтын орчноос ихээхэн хамааралтай.
- 3. Хог хаягдлын менежмент** – Нүүрс олборлолтоос их хэмжээний эрдэслэг болон эрдэслэг бус хог хаягдал гарна. Тэрхүү хатуу чулуулаг, шаварлаг хаягдал, боловсруулалтын хаягдал, шингэн нүүрсний хог зэрэг нь мөнгөн ус, кадмий, мышьяк зэрэг хортой нэгдлүүдийг агуулдаг. Нүүрс олборлох, боловсруулах явцад гарсан хаягдлыг төрлөөс нь хамааран цэвэрлэж хаяхаас гадна уурхай дээр болон уурхайгаас гадна хадгалах боломжтой. Хорт хаягдал болон олборлолтын хаягдлыг буруу хаях, хадгалах нь гадаргын болон гүний усыг бохирдуулж, улмаар хүний эрүүл мэнд, байгаль орчинд урт хугацаандаа ихээхэн аюул учруулах боломжтой.
- 4. Биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөлөл** – Нүүрс олборлолт нь биологийн олон янз байдалд нөлөөлөл үзүүлж болно. Ил уурхайн олборлолтын хүрээнд хөрс хуулж, газрын гадарга өөрчлөгдөхөөс үүдэн үржил шимтэй хөрс, зэрлэг амьтны суурьшил алдагдана. Уурхайн хүчиллэг ус нь их хэмжээний сөрөг нөлөө үзүүлэх ба хүчил, хүнд металлын агууламж бүхий овоолго гадаргын болон гүний усанд нэвчих тохиолдолд хүн, амьтан, ургамалд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.
- 5. Уугуул иргэдийн эрх** – Нүүрсний чиглэлээр ажиллаж буй компаниуд уугуул иргэдийн эзэмшдэг газар нутагт үйл ажиллагаа явуулах тохиолдол гардаг. Компаниуд хүний эрхийн зөрчил гаргах, уугуул иргэдийн эрх ашгийг хангаагүй тохиолдолд эсэргүүцэл гарч, улмаар тусгай зөвшөөрөл цуцлагдах эрсдэлтэй. Ингэснээр компаниуд нөхөн төлбөр болон нүүлгэн шилжүүлэлтээс үүдэлтэй их хэмжээний алдагдалд орж, тухайн бүс нутаг дахь нөөц баялгийн үнэ цэн буурахад хүрнэ.
- 6. Орон нутгийн харилцаа** – Нүүрс үйлдвэрлэл нь олон жил үргэлжилдэг үйл ажиллагаа тул нүүрсний компаниуд шаардлагатай тусгай зөвшөөрлөөс гадна тогтвортой үйл ажиллагаа явуулахад нутгийн иргэдийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай. Олон жил үйл ажиллагаа явуулдагтай холбоотойгоор тухайн нутгийн иргэдэд урт хугацааны олон төрлийн сөрөг нөлөөлөл үзүүлж болно.

<sup>21</sup> [https://www.sasb.org/standards/materiality-finder/find/?industry\[0\]=EM-CO](https://www.sasb.org/standards/materiality-finder/find/?industry[0]=EM-CO)

Иргэд агаар дахь хорт нэгдэл, хог хаягдлын сөрөг нөлөөнд нэрвэгдэхээс гадна хаягдал усны байгууламжуудыг буулгахтай холбоотой сөрөг нөлөөлөлд өртөж болно.

**7. Хөдөлмөрийн харилцаа** – Нүүрс олборлогч компаниуд үнээр өрсөлдөхийн тулд ажиллах хүчний зардлыг бага байлгах, эсвэл урт хугацааны гүйцэтгэлээ хангахын тулд хүний нөөцөө зөв удирдах гэсэн зөрчилтэй тулгардаг. Нүүрсний уурхайн ажиллах нөхцөл ихэнхдээ биеийн хүч шаардсан, аюултай ажлын байранд тооцогддог. Тиймээс үйлдвэрчний эвлэл нь ажилчдын эрхийг хамгаалах, цалин, ажиллах нөхцөлийн талаар хэлцэл хийх, гэрээ байгуулахад томоохон үүрэгтэй. Энэ нь хөдөлмөрийн харилцааны менежментийг чухал ач холбогдолтой болгодог. Ажиллагсадтайгаа зөрчилдөх нь ажил хаялт, бусад саад тотгорыг үүсгэж, үйлдвэрлэл зогсох эрсдэлд хүргэх, улмаар санхүүгийн алдагдал, нэр хүндийн эрсдэл учруулна.

**8. Ажиллах хүчний эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа** – Нүүрсний уурхайн хувьд хүнд, хортой нөхцөлийн улмаас аюулгүй ажиллагаа чухал ач холбогдолтой байдаг. Осол, нуралт, тэсэлгээ, үер зэрэг уурхайд хамаарах аюултай нөхцөл байдлаас үүдэн хүний амь нас эрсдэх, бэртэж гэмтэх эрсдэл ихтэй. Нүүрсний үйлдвэрлэл нь осол, гэмтэл, амь насаа алдах үзүүлэлтээр бусад үйлдвэрлэлийн дунджаас өндөр байдаг. Мөн уурхайчид урт хугацаандаа уушги тоосжих (силикоз) өвчинд нэрвэгдэх эсвэл удаан хугацаагаар халуун, химийн хортой нэгдлүүд үүсдэг орчинд ажилладагтай холбоотойгоор эрүүл мэндийн асуудлуудтай тулгардаг.

**9. Нөөцийн үнэлгээ болон капитал зарцуулалт** – Тооцооллоос үзвэл Парисын гэрээний дагуу хүлэмжийн хийн ялгарлыг хязгаарлаж, дэлхийн дулаарлыг 2 хэмээс хэтрүүлэхгүй байхыг зоривол нүүрсний компаниуд нөөцийнхөө ихээхэн хэсгийг олборлох боломжгүйд хүрнэ. Энэхүү дунд, урт хугацааны хандлагыг харгалзан үзэхийн зэрэгцээ капитал нөөц хөрөнгөө зөв удирдах, ялангуяа уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх чиглэлтэй үйл ажиллагаатай уялдуулах нь актив хөрөнгийн чанар муудах, ашигт ажиллагааг хадгалах, зээлжих зэрэглэлээ өндөр байлгахад чухал үүрэгтэй. Олон улсын түвшинд нүүрсний гол хэрэглэгч болох цахилгаан станцуудын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлээр зохицуулалтын бодлого, журмууд цөөнгүй гарсаар байгаа бөгөөд энэ бүхний улмаас нүүрсний эрэлт, үнэ буурах нь зайлшгүй юм. Хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах зохицуулалтууд нэмэгдэх тусам дунд болон урт хугацаандаа нүүрсний компаниудад санхүүгийн сөрөг нөлөөлөл ихэснэ. Сэргээгдэх эрчим хүчний технологи илүү өрсөлдөх чадвартай болсон нь нүүрсний үйлдвэрлэлд нөөц болон зардлын хувьд урт хугацааны эрсдэл авчирна.

**10. Хаягдал хадгалах байгууламжийн менежмент** – Хаягдал хадгалах байгууламжийг буруу удирдсанаас болж усны нөөцийг бохирдуулаад зогсохгүй байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх боломжтой. Энэ нь олборлогчдод санхүүгийн эрсдэл авчрах ба үүнд зохицуулах байгууллагын зүгээс оногдуулсан торгууль, шийтгэл, нөхөн төлбөр болон үйл ажиллагааг хэвийн байдалд эргүүлэн оруулахад шаардлагатай зардлууд багтана.

Компаниуд нарийн ширхэгт нүүрс болон хаягдлын хэмжээг бууруулах, бүтээцийн тогтвортой байдлыг хангах зэрэг нь энэ төрлийн эрсдэлийг бууруулна.

Компанийн үзүүлж буй материаллаг нөлөөллийг тодорхойлох болон баталгаажуулахад ашиглаж болох дараах эх сурвалжуудтай танилцана уу:

- Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөлийн (SASB) зөвлөмж болгосон Металл болон уул уурхайн салбарын материаллаг нөлөөллийн чиглэлүүдийг **эндээс** үзнэ үү.

<https://sasb.org/standards/materiality-finder/find/?industry%5b0%5d=EM-MM>

- Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөлийн (SASB) зөвлөмж болгосон Газрын тос, байгалийн хийн салбарын материаллаг нөлөөллийн чиглэлүүдийг **эндээс** үзнэ үү.

<https://sasb.org/standards/materiality-finder/find/?industry%5b0%5d=EM-EP>

- Олон улсын тайлагналын санаачилгын (GRI) салбарын стандартууд болон зөвлөмж болгож буй материаллаг нөлөөллийн чиглэлүүдийг **эндээс** үзнэ үү.

<https://www.globalreporting.org/how-to-use-the-gri-standards/gri-standards-english-language/>

## АРГАЧЛАЛ 5: БОНЗ-ЫН ХҮРЭЭЛЭЛ/ ШААРДЛАГА, СТАНДАРТ БОЛОН АРГА ЗҮЙГ ХЭРХЭН СОНГОХ ТУХАЙ

### АРГАЧЛАЛ 4

Ямар  
аргачлал  
вэ?

Компанид хэрэгжүүлэх БОНЗ-ын хүрээллийг сонгоход энэхүү аргачлал тусална.

Яагаад  
энэ нь ач  
холбог-  
долтой  
вэ?

Хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагууд эдгээр хүрээллийг ашиглан санхүүжилт өгөхөөр төлөвлөж буй компанийн БОНЗ-ын нөхцөл байдлыг үнэлдэг. Эдгээр хүрээлэл нь компанийн талаарх стандартчилсан тоймыг гаргаж ирдэг.

Хэрхэн  
ашиглах  
вэ?

1. БОНЗ-ын хүрээллийг сонгох шалгууруудтай танилцах.
2. БОНЗ-ын зарим хүрээллийн жагсаалт, онцлогуудыг шалган үзэж, компанидаа тохирохыг сонгоно.

Хавсралт 1-д Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн компаниудад хамааралтай БОНЗ-ын дотоодын 11, олон улсын 22 сайн дурын хүрээллийг жагсаан тайлбарласан. Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг компаниуд БОНЗ-ын зөв зохистой хүрээллийг сонгохдоо эдгээрийг судалж болно. Дотоодод гарч буй хүрээллүүд нь компаниудад БОНЗ-ыг хэрэгжүүлэх зөв эхлэл болохын зэрэгцээ олон улсын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагуудын шаардлагын талаарх мэдээллийг өгдөг. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг дагаж мөрдөх үед дотоодын шаардлагыг хангасан байх нь ихээхэн тус дэм болно.

**БОНЗ-ын хүрээлэл, стандарт болон арга зүйг сонгохдоо компаниудын баримтлах түгээмэл зарчмуудыг дор харууллаа:**

- **Хамааралтай байдал:** Хүрээлэл эсвэл стандарт нь компанийн үнэт зүйл, зорилго болон зорилтуудад нийцэж байна уу? Энэ нь компанийн үйл ажиллагаа, оролцогч талуудад чухал хамаарал бүхий БОНЗ-ын асуудлуудад чиглэж байна уу?
- **Бодит байдал:** Хүрээлэл эсвэл стандартыг хөрөнгө оруулагч, зохицуулах байгууллага болон бусад оролцогч талууд өргөн хүрээнд хүлээн зөвшөөрсөн үү? Хараат бус баталгаажуулалт болон магадлан итгэмжлэл хийгддэг үү?
- **Иж бүрэн байдал:** Хүрээлэл эсвэл стандарт нь БОНЗ-ын өргөн хүрээний асуудлыг хамаардаг уу, эсвэл нарийвчилсан тодорхой асуудлыг хамардаг уу? Энэ нь компанийн нэмүү өртгийн сүлжээнд БОНЗ-ын эрсдэл болон боломжуудыг хэрхэн авч үзэх талаар заавар чиглэл өгдөг үү?
- **Материаллаг байдал:** Хүрээлэл эсвэл стандарт нь компанийн үйл ажиллагаа, оролцогч талуудад хамгийн их материаллаг нөлөөлөл бүхий БОНЗ-ын асуудлуудыг тодорхойлох болон эрэмбэлэх зааварчилгааг хангаж өгч байна уу? Энэ нь БОНЗ-ын ямар асуудлууд бизнест нь хамгийн их ач холбогдолтойг, үйл ажиллагаагаа хаашаа чиглүүлэхээ тодорхойлоход дэмжлэг болж байна уу?
- **Ил тод байдал:** Хүрээлэл эсвэл стандарт нь компаниудаас БОНЗ-ын гүйцэтгэл, нөлөөллөө олон нийтэд ил тод болгохыг шаардаж байна уу? БОНЗ-ын мэдээллийг хэрхэн үнэн зөв, зохистой, ил тодоор тайлагнах тухай зааварчилгааг багтаасан байна уу?
- **Практик байдал:** Хүрээлэл/стандарт нь компанийн хувьд хэрэгжүүлэх бодит боломжтой байна уу? Хүрээлэл/стандарт нь БОНЗ-ын гүйцэтгэлийг хэрхэн хэмжих, тайлагнах болон гүйцэтгэлээ сайжруулахын тулд ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэх талаар тодорхой зааварчилгааг багтаасан байна уу? Үүнийг хэрэгжүүлэх зардал өндөр байна уу?

Доорх хүснэгтэд сонгон авсан зарим хүрээллийн үндсэн шинжүүдийг тоймлон харуулав.

| Хүрээлэл                                                                                 | Онцлог                                                                                                                                                                                                                                                                                                                                       | Хэнд тохиромжтой вэ?                                                                                                                                                                                                                      | Тайлбар                                                                                                                            |
|------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хариуцлагатай уул уурхайн кодекс (2018), МУУҮА                                           | Тус кодекс нь Монголын уул уурхайн компаниудад зориулагдсан ба компанийн засаглал, ил тод байдал, хөдөлмөрийн харилцаа, ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, хүрээлэн буй байгаль орчны хамгаалал, Орон нутгийн хөгжил, нутгийн иргэдийн оролцоо гэсэн 5 чиглэлд тавигдах шаардлага, зөвлөмжүүдийг тусгасан.                          | Монгол Улсын уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд аж ахуйн нэгжүүд                                                                                                                                                    | Одоогоор хөндлөнгийн баталгаа-жуулалтын үйл явцыг бий болгож байна.                                                                |
| Монголын компаниудад зориулсан БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамж (2022), СЗХ | Удирдамж нь бүхий л компаниудад зориулагдсан бөгөөд аль нэг салбарт хамаарах тусгайлсан зөвлөмж тусгаагүй. Компаниуд тайлан гаргахдаа харгалзан үзэх БОНЗ-ын тайлагналын 24 үзүүлэлтийг тайлбарласан.                                                                                                                                        | СЗХ-ны зүгээс даатгалын компани, брокерын компаниуд, хөрөнгө оруулалтын сан болон МХБ дээр бүртгэлтэй компаниудад хандан зөвлөмж болгож байгаа.                                                                                           | Одоогоор сайн дурын шинжтэй бөгөөд 2023 оноос заавал мөрдөгдөхөөр хүлээгдэж буй.<br><br>Уул уурхайн салбарт тусгайлан зориулаагүй. |
| Олон улсын тайлагналын санаачилгын стандартууд (2021), Олон улсын тайлагналын санаачилга | Энэ нь дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, хамгийн түгээмэл баримталдаг БОНЗ-ын шаардлагуудын нэг юм. Стандарт тайлагналын зарчим, үйл явц, хэмжүүрийг тодорхойлсны зэрэгцээ нүүрсний, газрын тосны болон байгалийн хийн салбарын бие даасан стандартуудтай. Уул уурхайн салбарын стандартыг боловсруулан олон нийтийн саналыг авч байна. | Олон улсын тайлагналын санаачилгын стандартууд нь томоохон компаниудад илүү тохиромжтой ч ямар ч компани хөтөч болгон ашиглах боломжтой. Шаардлагуудын дагуу тайлагнах боломжгүй бол уг стандартыг жишиг болгон тайлан бэлтгэх боломжтой. | Олборлох үйлдвэрлэлийн салбарт чухал ач холбогдол бүхий тайлагналын шаардлагууд болон материаллаг сэдвүүдийг тодорхойлсон.         |

| Хүрээлэл                                                                            | Онцлог                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | Хэнд тохиромжтой вэ? | Тайлбар                                                                                                                                                                                                                                              |
|-------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөлийн (SASB) стандартууд | Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын сан (IFRS) нь ТБНББС болон Нэгдсэн тайлагналын хүрээллийг (IRF) хариуцан ажилладаг. Тус сан анх удаа Олон улсын ТБНББС-ын хороог (ISSB) байгуулж, тогтвортой байдлын бүртгэлийн стандартын хэрэглээг дэмжиж байна. СТОУС нь тогтвортой байдалтай холбоотой ил тод мэдээлэх олон улсын хэмжээний иж бүрэн стандартыг гарган, хөрөнгө оруулагч болон санхүүгийн бусад оролцогч талуудад компаниудын тогтвортой байдалтай холбоотой эрсдэлийн талаар мэдээлэл өгч, шийдвэр гаргахад нь дэмжлэг болох зорилготой. |                      | Ил тод байдлын стандарт. Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөлөөс 77 салбарт хамаарах тайлагналын стандарт гаргаж, 2021 онд нийтлүүлсэн. Үүнд Нүүрс, Газрын тос, Металл болон Уул уурхайн салбарын стандартууд багтаж байна. |
| Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийн мэдээллийг тайлагнах Ажлын хэсэг (TCFD)     | Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийн мэдээллийг тайлагнах Ажлын хэсгийг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс үүсгэн байгуулсан. Уур амьсгалын өөрчлөлтөөс санхүүгийн салбарт үзүүлж буй нөлөөллийн талаарх иж бүрэн мэдээллээр хангах замаар санхүүгийн мэдээллийн тайлагналыг сайжруулах зорилготой. Ажлын хэсэг нь шийдвэр гаргахад чухал хэрэгцээтэй, ирээдүйг харсан мэдээллийг санхүүгийн тогтолцоонд нэвтрүүлэхээр ажилладаг.                                                                                                                  |                      | Уур амьсгалын өөрчлөлтөд хамаарах санхүүгийн мэдээлэлд төвлөрдөг.                                                                                                                                                                                    |

| Хүрээлэл                                                           | Онцлог                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | Хэнд тохиромжтой вэ?                                                             | Тайлбар                                                                                                                                                                                                                                          |
|--------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Олборлолтын зарчмууд (2022), Олон улсын металл, уул уурхайн зөвлөл | Олборлолтын зарчмууд нь нийт 39 гүйцэтгэлийн хүлээгдэж буй үр дүн, хамаарах албан ёсны 8 байр суурийн мэдэгдлээр дамжуулан гишүүн компаниудад БОНЗ-ын шаардлага тавьдаг. Олборлолтын зарчмууд нь НҮБ-ын ТХЗ болон Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх Парисын гэрээний хэрэгжилтийг дэмждэг.                                                                                    | Металл болон уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудад зориулсан. | Олон улсын металл, уул уурхайн зөвлөлийн Зарчим 10.3 нь гишүүдээсээ "Жил тутам эдийн засаг, байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг Олон улсын тайлагналын санаачилгын (GRI) тогтвортой хөгжлийн тайлангийн стандартын дагуу тайлагнахыг" шаарддаг. |
| БеттерКоул (Илүү сайн нүүрс) стандарт Код 2.0 (2021), БеттерКоул   | Энэхүү Кодын хүрээнд нүүрс үйлдвэрлэгчдийн БОНЗ-ын үндсэн гурван шатыг үнэлэх замаар тухайн үйлдвэрлэгчдэд кодоор тавигддаг шаардлагыг хангах чиглэлд ахиц гарах эсэхийг баталгаажуулдаг. Тус код нь 12 зарчим, 144 заалтаас бүрдэнэ. Эдгээр нь БОНЗ-ын өргөн хүрээний сэдвийг хамардаг. Ингэснээр нүүрсний хариуцлагатай ханган нийлүүлэлтийн сүлжээ бий болгоход төвлөрдөг. | Нүүрсний компаниудад тусгайлан зориулсан.                                        |                                                                                                                                                                                                                                                  |
| Компанийн тайланд ТХЗ-уудыг уялдуулах нь, Практик хөтөч            | ТХЗ-уудыг бизнесийн болон тайлагналын үйл явцтай уялдуулах гурван шатлалт үйл явцыг тусгасан. Бизнесийн байгууллагууд ТХЗ-д үзүүлж буй нөлөөллөө тайлагнаснаар хамааралтай талуудын мэдээллийн хэрэгцээг хангах боломжтой болно. Тус хөтчийг НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн зарчмууд болон Олон улсын тайлагналын санаачилгын стандартуудтай уялдуулан боловсруулагдсан.       | Бүх төрлийн компаниудад тохиромжтой.                                             | ТХЗ-уудад төвлөрсөн                                                                                                                                                                                                                              |



## АРГАЧЛАЛ 6: БАЙГАЛЬ ОРЧИНД ТӨВЛӨРӨХ НЬ – ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРУУЛАЛТАА ХЭРХЭН ТООЦООЛОХ ВЭ?

### АРГАЧЛАЛ 6

Ямар  
аргачлал  
вэ?

Энэхүү аргачлал нь байгаль орчны сэдэвт хамаарах бөгөөд хүлэмжийн хийг тооцоолох алхам нэг бүрийг тусгасан юм.

Яагаад  
энэ нь ач  
холбог-  
долтой  
вэ?

Хүлэмжийн хийн ялгарлын түвшин нь уул уурхайн компаниудын хамгийн түгээмэл ашигладаг үзүүлэлт юм.

Хэрхэн  
ашиглах  
вэ?

1. Хүлэмжийн хийн ялгарал гэж юу болох, яагаад тооцох ёстой талаар ойлгох.
2. Хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолохдоо уг аргачлалыг ашиглах.
3. Рио Тинто болон БиЭйчПи компаниудын ашигладаг хүлэмжийн хийн ялгарлын тооцооллын аргачлалуудыг судлах.

### Хүлэмжийн хийн ялгаруулалт гэж юу вэ?

Нүүрс хүчлийн давхар исэл (CO<sub>2</sub>), метан хий (CH<sub>4</sub>), азотын исэл (N<sub>2</sub>O) болон фторт хийн нэгдлүүд зэрэг агаар мандалд дулааныг барьдаг хийнүүдийг нийтэд нь хүлэмжийн хий гэж нэрлэдэг. АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлагаас хүлэмжийн хий ялгаруулагчаар дараах эх үүсвэрүүдийг тодорхойлжээ.

График 14.

### Хүлэмжийн хийнүүд

| Нүүрс хүчлийн давхар исэл (CO <sub>2</sub> )                                                                                                                                                                                      | Метан хий (CH <sub>4</sub> )                                                                                                                                                                                                                       | Азотын исэл (N <sub>2</sub> O)                                                                                                                                                                     | Фторт хийн нэгдэл                                                                                                      |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <ul style="list-style-type: none"> <li>Хатуу түлш шатаах (нүүрс, байгалийн хий, газрын тос)</li> <li>Хатуу хог хаягдал, мод болон бусад биологийн материал</li> <li>Химийн тодорхой урвал (жишээ нь цемент үйлдвэрлэл)</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Нүүрс, байгалийн хий, газрын тос үйлдвэрлэл, тээвэрлэлт</li> <li>Мал аж ахуй, бусад хөдөө аж ахуйн үйл ажиллагаа, газар ашиглалт</li> <li>Хот суурин газрын хатуу хог хаягдлын ландфиллын илжрэл</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Хөдөө аж ахуй, газар ашиглалт, аж үйлдвэрийн үйл ажиллагаа</li> <li>Хатуу түлш, хог хаягдал шатаах</li> <li>Хаягдал ус цэвэршүүлэх үйл ажиллагаа</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Өрхийн, бизнесийн болон үйлдвэрлэлийн олон төрлийн хэрэглээ, үйл явц</li> </ul> |

Эх сурвалж: АНУ-ын Байгаль хамгааллын агентлаг


### Яагаад бид хүлэмжийн хийн ялгаруулалтаа тооцоолох шаардлагатай вэ?

Хүлэмжийн хий нь дэлхийн дулааралд хамгийн гол хувь нэмэр оруулагч, уур амьсгалын өөрчлөлтийг өдөөгч юм. Бүлэг 1-т дурдсанчлан улс орнууд Парисын гэрээг соёрхон баталж, агаарын температурын дулаарлыг аж үйлдвэржилтийн өмнөх түвшнээс 2 хэмээс үл хэтрүүлэх, улмаар 2050 он гэхэд тэг хэмжээнд хүргэх зорилт тавьсан. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд улс орнууд ялгарлыг бууруулахад оруулах хувь нэмрээ тодорхойлсон үндэсний төлөвлөгөөнүүд хэрэгжүүлдэг. Монгол Улсын хувьд хүлэмжийн хийн ялгарлаа 27.2%-иар бууруулж, олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна гэж амласан.

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлээр гарч буй ахиц дэвшлийг хянахын тулд улс орнуудын хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолон хэмждэг байх шаардлагатай. Зарим салбарын хувьд аж ахуйн нэгж, байгууллагууд ялгаруулж буй хүлэмжийн хийн ялгарлаа тооцож, тайлагнах үүрэг хүлээсэн байдаг. Гэхдээ үүрэг хүлээгээгүй ч компаниуд сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх боломжтой. Тооцооллын үр дүнг ашиглан, төлөвлөлт хийж, ялгарлыг бууруулах зорилтуудаа тодорхойлдог. Тайлагналын хувьд хүлэмжийн хийн ялгарлыг дор харуулсан бүлгээр хуваан ангилдаг.

График 15.

### Хүлэмжийн хийн ялгарлын Цар хүрээ 1, 2, 3



### ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРУУЛАЛТ

**Цар хүрээ 1. Шууд ялгаруулалт** Компанийн эзэмшил эсвэл хяналтдаа байлгаж буй эх үүсвэрээс гардаг.

**Цар хүрээ 2. Эрчим хүчний шууд бус ялгаруулалт** Компанийн хэрэглэсэн эрчим хүчийг үйлдвэрлэх явцаас ялгарсан ялгарал.

**Цар хүрээ 3. Бусад шууд бус ялгаруулалт** (Цар хүрээ 2-т багтаагүй) Компанийн хяналт, эзэмшлээс гадуур явагдаж буй үйл ажиллагааны үр дүнд үүсэж буй ялгарал.

Эх сурвалж: Хүлэмжийн хийн протокол

## Хүлэмжийн хийн ялгарлыг хэрхэн тооцоолох вэ?

Олон тооны тооцоолох аргачлал байдаг ч түгээмэл ашигладаг үндсэн хэдэн алхам бий. Жишээ нь: Хүлэмжийн хийн протоколд хэмжээнээс үл хамааран бүх компани ашиглаж болох дараах алхмуудыг тодорхойлжээ.

График 16.

### Хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох нь



Эх сурвалж: Хүлэмжийн хийн протокол

### Алхам 1: Эх үүсвэрийг тодорхойлох

Бизнесийн үйл ажиллагаа болгон өөрийн гэсэн үйл явц, бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээтэй тул эдгээр нь шууд болон шууд бусаар хүлэмжийн хийг ялгаруулж байдаг.

- **Суурин төхөөрөмжийн шатаалтаас үүдэх ялгарал:** бойлер, зуух, турбин, халаагуур, шатаагч зуух, хөдөлгүүр, гэрэлтүүлэг зэрэг суурин тоног төхөөрөмжийн түлш шатаалт.
- **Явуулын төхөөрөмжийн шатаалтаас үүдэх ялгарал:** автомашин, ачааны машин, автобус, галт тэрэг, онгоц, хөлөг онгоц, завь зэрэг тээврийн хэрэгслийн түлш шатаалт.

• **Процессоос үүдэх ялгарал:** цемент үйлдвэрлэлийн кальцжуулалт, нефть-химийн үйлдвэрлэлээс гарах нүүрсхүчлийн давхар ислийн, хөнгөн цагаан хайлуулах үйлдвэрийн фторт хийн нэгдлийн ялгарал.

• **Дэгдэмхий хийн ялгарал:** тоног төхөөрөмжийг битүүмжилсэн хэсэг, холбоос, баглаа боодол зэргээс үүссэн санаатай, санамсаргүй ялгарал, мөн нүүрсний овоолго, хаягдал ус цэвэршүүлэх байгууламж, хөргөх цамхаг, хий боловсруулах үйлдвэрээс гарах ялгарал.

Эдгээр эх сурвалжийг ашиглан компани нь Цар хүрээ 1, 2 болон 3-т хамаарах хүлэмжийн хийн ялгарлыг тодорхойлно.

| Цар хүрээ 1                                                                                                                                                                                                                                                                                                                                          | Цар хүрээ 2                                                                                                                             | Цар хүрээ 3                                                                                                                                                                                                                 |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Өөрийн шууд ялгарлын эх сурвалжийг тодорхойлох (дээр жагсаан оруулсан эх сурвалжийн ангилал нэг бүрээр)                                                                                                                                                                                                                                              | Цахилгаан болон дулааны эрчим хүч, уур худалдан авч ашиглах замаар шууд бусаар ялгаруулж буй эх үүсвэрүүдийг тодорхойлох.               | Компанийн үйл ажиллагааны бүхий л шатлалыг, мөн бусдаар үйлдвэрлүүлж буй зүйлс, түрээс, эсвэл франчайз зэрэг Цар хүрээ 1 болон 2-т тусгагдаагүй эх сурвалжуудыг харгалзан шууд бус ялгаруулагч эх үүсвэрүүдийг тодорхойлох. |
| Процессын ялгарал үүсгэдэг эсвэл эрчим хүч үйлдвэрлэгч байгууламж эзэмшдэг уул уурхайн компаниуд нь эх сурвалжийн бүхий л ангиллаар шууд ялгаруулагч байна. Харин оффист суурилсан байгууллагууд нь шатаах зориулалтын эсвэл хөргөлт, эйр кондиционерын ямар нэгэн төхөөрөмж эзэмшиж, ашигладаггүй л бол хүлэмжийг хийг шууд ялгаруулахгүй гэж үзнэ. | Үйл ажиллагаа, үйлчилгээнд хэрэглэх зориулалтаар эрчим хүч хэрэглэж буй бизнесийн бүх байгууллага шууд бусаар хүлэмжийн хий ялгаруулна. | Сонголтоор байж болох ч өөрийнх нь нэмүү өртгийн сүлжээнд том хэмжээний ялгаруулагч байхгүй гэдгээ судлан баталгаажуулах шаардлагатай.                                                                                      |

## Алхам 2. Тооцооллын арга хандлагыг сонгох

Тооцооллын хоёр арга зүй байж болно. Эдгээр нь шууд хэмжилт болон баримтжуулсан коэффициентын аргууд байдаг. Шууд хэмжилт нь зардал өндөртэй. Ялангуяа компани олон газар, олон тооны байгууламжтай бол зардал ихтэй. Компаниуд хүлэмжийн хийн ялгарлын коэффициентийг ашиглан тооцоолол хийдэг.

График 17.

### Хүлэмжийн хийн ялгарал тооцох аргачлалууд

#### Шууд хэмжих

- Хийн ялгарал болон урсацын хэмжээнд мониторинг хийх
- Зардал өндөр, хийхэд хэцүү байж болно

#### Баримтжуулсан коэффициент ашиглах

##### Томьёо:

Хүлэмжийн хийн ялгарал  
=  $\text{ҮЙЛ АЖИЛЛАГАА} \times$   
ЯЛГАРЛЫН КОЭФФИЦИЕНТ

Хэмжих нэгж – тонн  
нүүрсхүчлийн давхар исэл

- Хүлэмжийн хийн ялгаралтай холбоотой тооцсон харьцааг ашиглан үйл ажиллагааг орлуулан тооцох
- Хэрэглэхэд хялбар

## Алхам 3. Үйл ажиллагаатайгаа холбоотой өгөгдөл цуглуулж, ялгарлын коэффициент сонгох

Энэхүү алхамд компаниуд үйл ажиллагаатайгаа холбоотой өгөгдөл цуглуулж болно. Жижиг, томоос үл шалтгаалан ихэнх компаниуд Цар хүрээ 1-т хамаарах ялгарлыг тооцохдоо бэлэн коэффициент ашиглан бизнесийн зориулалтаар худалдан авсан шатахуун, түлшний хэмжээнд үндэслэж болно. Цар хүрээ 2-т хамаарах ялгарлын хувьд тоолуураар гарсан цахилгаан эрчим хүчний хэрэглээнд үндэслэн эрчим хүч нийлүүлэгчийн эсвэл дотоодын дамжуулах сүлжээний эсвэл бусад талуудын гаргасан коэффициент ашиглан тооцож болно. Цар хүрээ 3-т хамаарах ялгарлыг түлшний хэрэглээ, зорчсон зай зэрэгт үндэслэн гуравдагч талын гаргасан коэффициент ашиглан тооцож болно.

Ялгарлын коэффициентыг хэвлэн нийтэлдэг олон тооны байгууллага, агентлагууд бий бөгөөд тэдгээрийн зарим жишээг дараах холбоосоор үзнэ үү.

- АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлаг, [Хүлэмжийн хийн ялгарлын коэффициентын нэгдсэн сан](#)
- Үндэсний статистикийн газар, [Хүлэмжийн хийн тооллого хийх арга зүй](#)
- НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц, Монгол Улсын үндэсний цахилгаан дамжуулах сүлжээний хүлэмжийн хийн ялгарлын коэффициент

- Шинэ Зеланд улсын Байгаль орчны яам, Хүлэмжийн хийн ялгарлын коэффициентын тойм (Summary of Emission Factors)

#### Алхам 4. Тооцооллын аргачлал ашиглах

Том компаниуд төрөл бүрийн аргачлал ашиглан хүлэмжийн хийн ялгарлаа тооцоолдог. Салбар, үйл ажиллагаа, бизнесийн хамрах хүрээ зэргээс хамаарсан олон янзын аргачлалууд байдаг. Тухайлбал, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн салбараас Excel office-д суурилсан аргачлал гаргасныг **эндээс** үзэж болно.

<https://unfccc.int/documents/271269>

#### Алхам 5. Хүлэмжийн хийн ялгарлын өгөгдлийг ашиглан нэгтгэх

Энэхүү алхмын хүрээнд компаниуд өгөгдөл мэдээллүүдээ нэгтгэн нийт хүлэмжийн хийн ялгаруулалтаа тайлагнана. Жишээ болгож уул уурхайн томоохон хоёр компанийн ашигладаг арга зүйг дор танилцууллаа.

Рио Тинто компанийн ашигладаг арга зүйг **эндээс** үзнэ үү.

<https://www.riotinto.com/-/media/Content/Documents/Invest/Reports/Climate-Change-reports/RT-Climate-scope-123-report-2021.pdf?rev=02ff321e0574403a91912babebb341cd>

БиЭйчПи компанийн ашигладаг арга зүйг **эндээс** үзнэ үү.

[https://www.bhp.com/-/media/documents/investors/annual-reports/2021/210914\\_bhpscope12and3emissionscalculationmethodology2021.pdf](https://www.bhp.com/-/media/documents/investors/annual-reports/2021/210914_bhpscope12and3emissionscalculationmethodology2021.pdf)

### АРГАЧЛАЛ 7: НИЙГМИЙН ЧИГЛЭЛД ТӨВЛӨРӨХ НЬ – ЖЕНДЭР БОЛОН ХҮНИЙ ЭРХ

#### АРГАЧЛАЛ 7

Ямар аргачлал вэ?

Энэхүү аргачлал нь нийгмийн шаардлагуудын хүрээнд Жендэр болон Хүний эрхэд төвлөрсөн.

Яагаад энэ нь ач холбогдолтой вэ?

Жендэрийн тэгш байдал хүний суурь эрх тул бүхий л компаниудын хувьд хэрэгжилтийг хангах нь чухалд тооцогддог.

Хэрхэн ашиглах вэ?

1. Энэ чиглэлээр Монгол Улсад сүүлд гарч буй санаачилгуудтай танилцаж, мэдээлэлтэй болох.
2. Эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх зарчмуудад судалгаа хийх.
3. Хийдлийн шинжилгээний арга зүйг ашиглах.

Жендэрийн тэгш байдал нь хүний суурь эрхэд тооцогддог. Монгол Улсын УУХҮЯ-наас 2019 онд **Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг**<sup>23</sup> боловсруулан баталсан. Энэхүү бодлого нь уул уурхайн салбарт хүний эрх, жендэрийн тэгш байдлыг хангах, олон талт байдал болон хүртээмжийг сайжруулах зорилготой. Энэ чиглэлд ахиц дэвшил гаргах хүсэлтэй компаниудад зориулсан жендэрийн тэгш байдал, хүний эрхийн цахим сургалтыг АМЕР-2 хөтөлбөр УУХҮЯ, Эрдэс баялаг эмэгтэйчүүдийн холбоо ТББ хамтран боловсруулсан. Энэхүү сургалтыг **эндээс** үзнэ үү.

<https://mmhi.gov.mn/эрдэс-баялгийн-салбарын-хүний-эрх-жен/>

Түүнчлэн ажлын байр, зах зээл, орон нутагт жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх үйл явцыг идэвхжүүлэх багц зарчмыг багтаасан зааварчилгаа бүхий Эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх зарчмуудыг (WEPs) ашиглаж болно. НҮБ-ын Даян дэлхийн гэрээ, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн салбарын бэлтгэн гаргасан эдгээр зарчим нь олон улсын хөдөлмөрийн болон хүний эрхийн стандартыг баталгаажуулдаг. Зарчмууд нь доорх 7 сэдвийн хүрээнд бэлтгэгдсэн:

График 18.

### Эмэгтэйчүүдийг чадавхижуулах 7 зарчим, НҮБ

|                                                                                                                                                                       |                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                       |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p><b>1</b>  Зарчим</p> <p>Компанийн өндөр түвшинд манлайлал үзүүлэх</p>             | <p><b>2</b>  Зарчим</p> <p>Бүх эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш, шударгаар, алагчлахгүй хандах</p>                       | <p><b>3</b>  Зарчим</p> <p>Ажилтнуудын эрүүл мэнд, сайн сайхан байдал, аюулгүй ажиллагааг хангах</p> |
| <p><b>4</b>  Зарчим</p> <p>Албан тушаал ахих боловсрох, сурах боломж бүрдүүлэх</p> | <p><b>5</b>  Зарчим</p> <p>Байгууллагын хөгжил, ханган нийлүүлэлтийн сүлжээ, маркетингийн практикт нэвтрүүлэх</p> | <p><b>6</b>  Зарчим</p> <p>Орон нутгийн иргэдийн санаачилга, нөлөөлөл</p>                          |
| <p><b>7</b>  Зарчим</p> <p>Хэмжих, тайлагнах</p>                                   |                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                       |

Эх сурвалж: НҮБ-ын Даян дэлхийн гэрээ, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага

<sup>23</sup> <https://mmhi.gov.mn/бодлогын-бичиг-баримтууд/>



Түүнчлэн жендэрийн тэгш байдлын гүйцэтгэлээ үнэлэн, давуу болон сул тал, хийдэл, боломжуудыг илрүүлэн тогтооход дэм болох Хийдлийн шинжилгээний аргачлал (WEPs Tool) гэж байдаг. Компаниуд дараах зорилгоор энэхүү аргачлалыг ашиглах боломжтой:

- Компанийн жендэрийн тэгш байдлын хандлагыг үнэлэх
- Хийдлийг илрүүлж, байнгын сайжруулалт, шинэчлэл хийх боломжуудыг тодорхойлох
- Жендэрийн тэгш байдлын талаарх олон улсын сайн туршлагаас суралцах
- Цаашид ахиц дэвшил гаргах зорилго, зорилтоо тодорхойлон, хэмжиж үнэлэх
- Ижил төстэй компаниуд болон салбарын стандарттай харьцуулах
- Олон улсын жендэрийн тэгш байдлын нөөц эх үүсвэрийг ашиглан ирээдүйн үйл ажиллагаагаа чиглүүлэх
- Олон улсын зорилгууд, эмэгтэйчүүд, охидод тэгш боломж олгох, орон нутгийн бизнест хөрөнгө оруулалт хийх замаар НҮБ-ын ТХЗ-уудын хэрэгжилтэд хувь нэмэр оруулах. Эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх аргачлал нь жендэрийн тэгш байдал, тэгш цалин, ажилд авах тэгш боломж, эцэг эхчүүд болон асран хамгаалагчдад дэмжлэг үзүүлэх, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, хүртээмж, жендэрийн тэгш байдлын чиглэлээрх нөлөөлөл зэрэг олон сонголт бүхий асуултаас бүрддэг. Энэхүү аргачлалын талаар **эндээс** үзнэ үү.

<https://weps-gapanalysis.org/accounts/login/?next=/gat/>

Өөр нэг сайн аргачлал болох НҮБХХ-ийн гаргасан Хүний эрхийн магадлан шинжилгээний сургалтын гарын авлага монгол хэл дээр гараад байна. Энэхүү гарын авлага нь бизнес болон хүний эрхийн үзэл баримтлалыг тусгаж, компаниуд хүний эрхийн магадлан шинжилгээ хийх үйл явцыг тайлбарлан чиглүүлсэн зарчмуудыг тусгажээ. Гарын авлагыг **эндээс** үзнэ үү.

<https://www.undp.org/mongolia/publications/hrdd-training-facilitation-guide>

## АРГАЧЛАЛ 8: ЗАСАГЛАЛЫН ЧИГЛЭЛД ТӨВЛӨРӨХ НЬ – ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН, БОНЗ-ЫН ХОРОО

### АРГАЧЛАЛ 8

Ямар  
аргачлал  
вэ?

Энэхүү аргачлал нь ТУЗ, түүний хороодын зүгээс БОНЗ-тай хамаарах чиг үүрэгт төвлөрдөг.

Яагаад  
энэ нь ач  
холбог-  
долтой  
вэ?

ТУЗ нь БОНЗ-ын үзэл баримтлалыг компанид нэвтрүүлэхэд чухал үүрэгтэй. Дээрээс доошоо чиглэлтэй энэхүү аргачлалыг үр дүнтэй арга зүй гэж үздэг.

Хэрхэн  
ашиглах  
вэ?

1. ТУЗ-ийн БОНЗ-ын хороо байгуулах талаар ойлголттой болох.
2. Хорооны чиг үүргийг мэдэх.

### ТУЗ-ийн бүрэлдэхүүн

ТУЗ нь БОНЗ-ын хороотой байх нь компанийн зүгээс удирдлагын манлайллын чиглэлд хүчин чармайлт гаргаж буйг илтгэх сайн үзүүлэлт юм. Жижиг компаниудын хувьд ТУЗ-дөө тогтвортой хөгжлийн мэргэжилтэн сонгох эсвэл БОНЗ-ын зөвлөх ажиллуулж болно. Дээрх хоёр сонголт боломжгүй бол ТУЗ-ийн аль нэг гишүүнийг БОНЗ-ын асуудал хариуцуулахаар томилж болно. БОНЗ болон тогтвортой хөгжлийн асуудлууд нь цаашид уул уурхайн компаниудын ТУЗ-ийн үйл ажиллагаанд ихээхэн чухал байх нь дамжиггүй юм.

## БОНЗ-ын хорооны чиг үүрэг

БОНЗ-ын хорооны гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагад доорх зүйлс багтдаг:

- БОНЗ-ын бодлого, стратеги, арга хандлагыг судлан үзэх;
- БОНЗ-ын чиглэлээрх заавал даган мөрдөх шаардлага, хуульд заасан шаардлагуудын биелэлтийг хангах;
- БОНЗ-ын Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд/ зорилтуудыг судлан үзэж, батлах;
- БОНЗ-ын хөтөлбөр, санаачилга, үйл ажиллагааны төлөвлөгөөг стратегид нийцүүлэн батлах, хэрэгжилтийг хангах, хяналт тавих;
- БОНЗ-ын хэмжүүрийг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Материаллаг нөлөө бүхий сэдвийг батлах;
- ТУЗ-өөр батлуулахаас өмнө жилийн тайлан/ тогтвортой хөгжлийн тайланг хянан үзэх, БОНЗ-тай холбоотой ил тод болгож буй мэдээллийг эцэслэн баталж байх;
- Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-д БОНЗ-ын асуудлаар чиглэл өгөх;
- БОНЗ-тай холбоотой жил тутмын төслийг хянан үзэх;
- Зохицуулах байгууллагын зүгээс хийсэн хяналт шалгалт, аудитын үр дүн, зөвлөмжүүдийг хянан үзэх;
- БОНЗ-ын чиглэлээр бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж болох асуудлыг судлан үзэх, ТУЗ-ийн анхааралд хүргэх;
- БОНЗ-тай холбоотой эрсдэл, боломжуудыг хянах/ мониторинг хийх.

Ньюкрест Майнинг компанийн ТУЗ-ын БОНЗ-ын хорооны журмын жишээг дор харууллаа.

## НЬЮКРЕСТ МАЙНИНГ КОМПАНИЙН ТУЗ-ИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХОРООНЫ ЖУРАМ

### ЗОРИЛТУУД

ТУЗ-д аюулгүй ажиллагаа, ажлын байрны эрүүл мэнд болон эрүүл ахуй, нийгмийн гүйцэтгэл, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжил, хүний эрх, нутгийн иргэд, ажилтнууд болон аюулгүй ажиллагааны Нийгэм, Аюулгүй байдал, Тогтвортой байдал (НАТ) чиглэлээрх компанийн үйл ажиллагаа, засаглалд хяналт тавихад дэмжлэг үзүүлэх.

### ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Дээрх зорилтуудыг хангахын тулд Хороо нь:

1. Үндсэн чиглэлийн бодлого, стратегийн талаар ТУЗ-д зөвлөмж боловсруулж өгөх.
2. НАТ-ын чиглэлээр компанийн эрсдэлийн менежмент, удирдлагын тогтолцооны зохистой байдалд хяналт тавих.
3. НАТ чиглэлээр компанийн чиг үүрэг, үйл ажиллагааг судлах, хяналт тавих.
4. Бодлого, хууль тогтоомж, эрх зүйн болон зохицуулалтын хүрээнд тавигддаг бүхий л шаардлагыг даган мөрдөж, хэрхэн хэрэгжүүлж буйгаа баталгаажуулах.
5. НАТ чиглэлээр олон нийтийн өмнө хүлээх зорилтуудаа тодорхойлох, хэрэгжүүлэх үйл явцыг хянах, тухайн зорилтуудын гүйцэтгэлд мониторинг хийх.
6. НАТ чиглэлд хамаарах эрсдэлийг удирдах болон бууруулах үйл ажиллагааг тодорхойлох, тэрхүү үйл ажиллагаанд хяналт тавих.
7. НАТ чиглэлээрх компанийн гүйцэтгэлд хяналт тавих.
8. НАТ чиглэлд хамаарах асуудлууд болон дагаж мөрдөхгүй байгаатай холбогдох асуудлыг судлан үзэх.
9. Удирдлагын зүгээс НАТ-тай холбоотой салбарын чиг хандлага болон стандартуудын талаарх зөвлөмжүүдийг судлан үзэх.
10. Компанийн бодлого, стандартын хэрэгжилттэй холбоотой дотоод нөөц, эх үүсвэрт хяналт тавих.
11. НАТ чиглэлд хамааралтай олон нийтэд хийх мэдэгдэл, тайлангуудтай холбоотой зөвлөмжийг ТУЗ-д боловсруулж өгөх.
12. ТУЗ-ын хүсэлт, шаардлагаар хорооны эрх үүргийн хүрээнд тодорхой асуудлаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
13. Хорооны үйл ажиллагаа, үр дүнгийн талаар ТУЗ-д тайлагнах, шаардлагатай бол зөвлөмж гаргах.

## ЭРХ МЭДЭЛ/ ЧИГ ҮҮРЭГ

Тус хороо нь хянах, зөвлөх эрх бүхий байна. Хороо шууд шийдвэр гаргах эрхгүй бөгөөд ТУЗ-ийн зүгээс шилжүүлэн өгсөн ямар нэгэн эрх мэдлийг эдлэхгүй. Хороонд ТУЗ-ийн зүгээс шаардлагатай бол гадны мэргэжилтнүүдийн зөвлөгөө авах, чиг үүргээ холбогдох мэргэжилтнүүдэд шилжүүлэх эрх олгосон. Энэхүү чиг үүргийг гүйцэтгэхдээ Хороо нь гүйцэтгэх удирдлага, дотоод болон хөндлөнгийн аудитор эсвэл мэргэжилтнүүдтэй харилцаж, шаардлагатай мэдээлэл, тайлбарыг гаргуулан авах эрхтэй байна.

## ГИШҮҮНЧЛЭЛ

Хорооны бүрэлдэхүүнд ТУЗ-ийн гурван гишүүн багтах ба нэг нь Хороог даргална. ТУЗ нь Хорооны гишүүд болон даргыг томилж, чөлөөлнө.

## ХУРАЛДААН

Хурлын ирцийг бүрдүүлэхийн тулд Хорооны дарга (эсвэл түүний томилсон нэг гишүүн) болон нэг гишүүн хуралд оролцсон байна. Хороо нь шаардлагатай бүхий л тохиолдолд хуралдах ба жилдээ гурваас доошгүй удаа хуралдана. Хорооны бүх гишүүнд ажлын баримт бичгүүд, хурлын зарыг хүргүүлнэ. Хорооны хуралд гүйцэтгэх удирдлагын гишүүд оролцож болно. Гүйцэтгэх удирдлагын багийн бусад гишүүд, мэргэжилтнүүд болон зөвлөхүүд нь Хорооны хуралд урилгаар оролцож болно.



Танилцуулга

БОНЗ-ын экосистем

БОНЗ-ын аргачлал

## БҮЛЭГ 4. СУДАЛГААНЫ ЖИШЭЭ: БРУМАДИНО (BRUMADINHO) ДАХЬ ХАЯГДЛЫН ДАЛАН ЗАДАРСАН ТҮҮХ

Хавсралт 1, 2

## Бүлэг 4. Судалгааны жишээ: Брумадино (Brumadinho) дахь хаягдлын далан задарсан түүх

### ЮУ ТОХИОЛДСОН БЭ?

2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Бразил улсын Брумадино дахь Коррего до Фелйао (Córrego do Feijão) уурхайн хаягдлын далан задарч, 270 хүний амь үрэгджээ.

#### Компани:

- Вале (Vale S.A.) 1942 онд байгуулагдсан.
- Вале нь Бразилын үндэстэн дамнасан компани бөгөөд төв нь Бразилын Рио де Жанейро хотод байрладаг. Тус компани дэлхийн хамгийн том уул уурхайн компаниудын нэг бөгөөд 20 гаруй улсад салбартай, 70,000 гаруй ажилтантай.
- Төмрийн хүдэр, никелийн хамгийн том үйлдвэрлэгч бөгөөд манган, төмрийн хайлш, зэс, мөнгө, кобальтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

#### Далан:

- Хаягдлын нэгдүгээр далан нь уурхай дахь 7 далангийн хамгийн том нь. Нийт 12 сая шоо метр хаягдал агуулах багтаамжтай.
- Даланг 1976 онд Фертеко Минерасио (Ferteco Mineração) компани байгуулсан бөгөөд 2001 оны 4 дүгээр сарын 27-нд Вале компани худалдан авч, өөртөө нэгтгэжээ.
- Нуралт үүсэх үед далан нь шинээр хаягдал хүлээн авдаггүй, зөвхөн өмнө нийлүүлсэн хаягдлыг хадгалах зориулалттай байжээ.
- Далангийн өндөр 86 метр, хөндлөн тэнхлэг нь 720 метрийн урттай.

#### Хаягдал:

- Хаягдал нийт 249.5 мянган квадрат км талбайг эзэлсэн.
- Нийт хаягдлын хэмжээ 11.7 сая цоо метр.

### Ослын шалтгаан юу байв?

Ослын шууд шалтгаан нь хаягдлын хэт шингэрэлт юм. Ийм нөхцөлд бороо их орж, далангийн усны даралт нэмэгдсэнээр хаягдал шингэрч, далан нурахад хүрсэн байна.

#### Тодорхойлолт:

Шингэрэх –Хатуу биет материал болон даланд хуримтлагдсан хаягдал хатуулгаа алдаж, шингэн төлөвт шилжих үйл явц.

## ҮР ДАГАВАР, НӨЛӨӨЛӨЛ

- **Амь насаа алдсан хүний тоо:** 270

- **Байгаль орчны гамшиг:** Уул уурхайн олборлолтоос үлдсэн их хэмжээний хаягдал, хүнд металл болон бусад бохирдуулагч задарч, хүрээлэн буй орчинд тархсан. Шаварлаг хаягдлууд олон км газарт урсаж, ойролцоох гол, усны нөөц газрыг бохирдуулан, экосистем, зэрлэг амьтны суурьшлыг устгасан.

- **Археологийн бүс нутагт хохирол учруулсан:** Коррего до Фелйао хэмээх археологийн дурсгалт газар уурхайн ойролцоо байжээ. Хадны сүг зураг, археологийн бусад төрлийн дурсгал бүхий соёл, түүхийн асар үнэ цэнтэй өвийг хадгалсан газар байсан. Ослын тайланд дурдсанаар далангаас урссан шаварлаг хаягдал Коррега до Фелайод их хэмжээний газраар тархаж, олон тооны хадны сүг зураг, бусад өвийг устгасан байна.

- **Санхүүгийн алдагдал:**

- Гамшигийн дараа Вале компанийн зах зээлийн үнэлгээ 4 тэрбум ам.доллаар буурчээ.

- **Торгууль, төлбөр:** Вале компанид эрх бүхий байгууллагуудаас их хэмжээний торгууль оногдуулсан. Бразилын Засгийн газар тус компанийг 7 сая ам.доллаар торгосноос гадна бусад зохицуулалтын байгууллагууд ч торгууль оногдуулсан байна. АНУ-ын Үнэт цаас, биржийн хорооноос мөрдөн шалгах ажиллагаа явуулаад Вале нь далангийн талаар хөрөнгө оруулагчдад зохих ёсоор мэдээлээгүй гэж дүгнэжээ. Мөрдөн шалгах ажиллагаа хаягдлын далан задарсан болон гамшгаас үүдэн гарч болох хохирлын талаар компани ил тод мэдээлж байсан эсэхэд төвлөрчээ. 2020 оны 3 дугаар сард Үнэт цаас, биржийн хороо болон компани зөвшилцөлд хүрснээр Вале компани 107 сая ам.доллар төлөхөөр болсон.

- **Ашиг орлогод үзүүлсэн нөлөөлөл:** Энэхүү осол Вале компанийн санхүүд ихээхэн сөргөөр нөлөөлсний улмаас зарим уурхайгаа түр зогсоосон. Компанийн зүгээс 2019 оны 1 дүгээр улиралд 1.6 тэрбум ам.долларын алдагдал хүлээснээ тайлагнасан.

- **Хохирогчдод олгох нөхөн төлбөр:** Вале компани нь Төлбөр төлж хохиролгүй болгох ерөнхий гэрээний хүрээнд гамшигт өртсөн хүмүүст 7 тэрбум гаруй ам.долларын нөхөн төлбөр олгох үүрэг хүлээсэн.

- **Нэр хүнд:**

- Зөвхөн Вале компани төдийгүй нийт уул уурхайн бизнесийн нэр хүндийг муутгаж, хөрөнгө оруулагчдын хандлагад сөргөөр нөлөөлсөн.

- **Эдийн засгийн үр дагавар:** Энэхүү гамшиг орон нутгийн эдийн засагт, ялангуяа уул уурхай, хөдөө аж ахуйн салбарт томоохон сөрөг нөлөө авчирсан. Уурхайг хааж, орон нутгийн усан хангамж тасалдаж, фермүүдийн үйл ажиллагаа зогсож, орлогоо алдсан.



• **Зарга:**

- **Нийтийн эрх ашгийг хамгаалсан зарга:** Компанийн хувьцааны үнэ унаснаас үүдэн алдагдалд орсон хөрөнгө оруулагчид Вале компанийн эсрэг нийтийн эрх ашгийн төлөө хэд хэдэн зарга үүсгэсэн. 2020 оны 9 дүгээр сард заргалдагч талуудтай зөвшилцөлд хүрснээр Вале компани 25 сая ам.доллар төлөхөөр тохирсон.
- **Иргэний хэрэг:** Гамшигт өртсөн хувь хүмүүс, байгууллагууд хамтран компанийн эсрэг нэхэмжлэл гаргаж, хохирол нөхөн төлөхийг шаардсан. Энэхүү нэхэмжлэлээр Вале компани хайхрамжгүй байж, эс үйлдсэний улмаас нутгийн иргэд болон байгаль орчныг хамгаалах чиглэлээр хангалттай арга хэмжээг аваагүй хэмээн буруутгасан.
- **Эрүүгийн хэрэг:** Бразилын прокуроруудын зүгээс Вале компанид эрүүгийн хэрэг үүсгэж, хэд хэдэн захирлыг гамшигт осолд буруутгасан. Үүнд хүний амь нас эрсэдсэн болон байгаль орчны гэмт хэрэг, хуурамч мэдээлэл өгсөн зэрэг үндэслэл багтжээ.

## ЯАГААД ЭНЭ ЗҮЙЛ ТОХИОСОН БЭ?

Гамшигт нөхцөл байдал үүссэн шууд шалтгаан нь даланд агуулагдаж байсан хаягдал хэт шингэрч, далан нурахад хүргэсэн ч энэ нь компанийн ажилтнуудын буруутай үйлдлээс шууд хамааралтай байжээ. Вале нь аюулгүй байдал, мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой ноцтой зөрчил гаргаж, далан болон хаягдлын аюулгүй байдлын журмыг зөрчсөн бөгөөд мэргэжлийн чиг үүргээ хөсөрдүүлэн, аюулгүй байдлын аудитыг хууран мэхлэх, гэрчилгээг хуурамчаар үйлдэх, БОНЗ-ын мэдээллийг хуурамчаар гаргасан зэрэг үйлдэлд буруутгагдсан.

2016 оноос эхлэн Вале нь далангийн аюулгүй байдлын аудитыг олон удаа хууран мэхэлж, далангийн тогтвортой байдлын гэрчилгээг хуурамчаар гаргуулан авч, БОНЗ-ын тайландаа Брумадино далангийн аюулгүй байдлын талаар худал мэдээлж, орон нутгийн захиргаа, нутгийн иргэд, хөрөнгө оруулагчдыг төөрөгдүүлж иржээ. Үнэт цаас, биржийн хорооны гаргасан гомдолд Вале компани нь уул уурхайн олборлолтоос гарсан хорт нэгдэл бүхий хаягдал агуулсан Брумадино даланг далангийн аюулгүй байдлын олон улсын стандартад нийцэхгүйг мэдэж байсан хэмээн буруутгасан. Гэтэл компанийн зүгээс олон нийтэд хандан гаргасан Тогтвортой хөгжлийн тайлан болон бусад баримт бичигт далангийн аюулгүй байдлын үнэлгээ “олон улсын сайн практикт” нийцсэн, 100% тогтвортой хэмээн дүгнэсэн гэж хуурамч мэдээлэл өгч байжээ.

**Үнэт цаас, биржийн хорооны гаргасан нэхэмжлэл**

## СУРГАМЖ

**Алдаанаасаа сургамж авахын ач холбогдол:** 2015 онд Вале болон БиЭйчПи компанийн хамтран ажиллуулдаг Самарко уурхайд хаягдлын далан нурж, 19 хүн амь үрэгджээ. Энэхүү осолд мөрдөн шалгах ажиллагаа явуулж, дүн шинжилгээ хийн, засаж залруулах арга хэмжээ авсан бол уг гамшгаас сэргийлэх боломжтой байсныг тогтоосон байна. Цугларсан баримт нотолгооноос үзвэл тухайн далан 16 жилийн турш тогтворжилт хангалтгүй байж иржээ.

Одоогийн байдлаар Бразилд саяхан нурсан далантай ижил байдлаар баригдсан 87 хаягдлын далан байна. Эдгээрийн 4-өөс бусдыг Засгийн газрын зүгээс эрсдэлтэй гэж дүгнэжээ. Хамгийн их анхаарал татаж буй асуудал нь эдгээр далангийн 27 нь 100,000-аас дээш хүн ам бүхий хот, суурин газрын дээд талд байрласан нь тэдгээр хот суурин газарт томоохон эрсдэл үүсгэж байна.

*Нью-Йорк Таймс сэтгүүл*

**Аюулгүй байдлын хяналт шалгалт байнга хийх шаардлага:** Вале компани олон жилийн туршид тухайн даланд аюулгүй байдлын шалгалт хийгээгүй бөгөөд далан нурж болзошгүй шинж илрээд байхад ч хайхралгүй орхисон байна.

**Салбарын журам, зохицуулалтыг сайжруулах хэрэгцээ:** Брумадино уурхайд гарсан осол нь Бразил улсад уул уурхайн салбарын зохицуулалттай холбоотой олон асуудлыг ил гаргасан. Энэ ослоос хойш Бразилын Засгийн газраас уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хатуу дүрэм, журам хэрэгжүүлэх болсон бөгөөд хаягдлын даланд аюулгүй байдлын бие даасан, хөндлөнгийн аудит хийлгэх зохицуулалт бий болсон.

**БОНЗ-ын мэдээллийн ач холбогдол:** Тухайн хэрэг БОНЗ-ын мэдээллийн ил тод байдал, үнэн зөвийн баталгаажуулалт, хөрөнгийн зах зээлийн дүрэм журмыг дагаж мөрдөхийн ач холбогдлыг харуулсан. Хөрөнгө оруулагчдын хувьд ч гэсэн БОНЗ-ын мэдээллийг илүү нарийн нягтлан шалгахын зэрэгцээ уул уурхай зэрэг өндөр эрсдэл бүхий салбарт түлхүү анхаарал хандуулах болсон юм.

**Олон улсын хэмжээнд салбарын зохицуулалт хийх явцыг түргэтгэсэн:** 2020 оны 8 дугаар сард Олон улсын металл, уул уурхайн зөвлөл, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр болон Олон улсын тайлагналын санаачилга хамтран Олон улсын **Хаягдлын менежментийн стандартыг** батлан гаргасан. Энэхүү стандарт “хүн болон байгаль орчинд тэг хохирол учруулах, хүний амь нас хохирох явдлыг арилгах” зорилгыг өмнөө тавьжээ. Уг стандартаар компаниуд үйл ажиллагааныхаа бүхий хугацааны турш, хаалт болон хаалтын дараах шатанд ч хаягдал хадгалах байгууламжийн аюулгүй байдлыг бүрэн хариуцаж, тэргүүлэх ач холбогдол өгөх үүрэг хүлээсэн. Стандарт нь мөн хамаарах мэдээллийг олон нийтэд ил тодоор мэдээлэхийг шаарддаг. Энэ тохиолдол хөрөнгө оруулагчдыг БОНЗ-ын асуудалд



цоо шинээр хандахад хүргэж, салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний явцыг улам түргэтгэсэн. Үр дүнд нь хөрөнгө оруулагчид идэвхтэй байж, илүү өндөр стандартыг хангуулахын тулд салбартай хамтран ажиллах шаардлага үүссэн байна.

“Осол гэмтлийг тэг хэмжээнд хүргэх зорилго бүхий, аюулгүй ажиллагааны жишиг болохуйц Хаягдлын далангийн олон улсын стандартыг өргөн барьж буйдаа таатай байна.

“Брумадино дахь Вале компанийн Коррего до Фелайо уурхайн далан задарсан гамшигт осол нь хүн төрөлхтөн хийгээд байгаль орчны хувьд эмгэнэлт явдал болж, дэлхийн хэмжээнд буй хаягдал хадгалах байгууламж, далангуудын аюулгүй байдал, засаглалыг сайжруулах чиглэлээр шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагыг үүсгэсэн. Хаягдлын байгууламжийн иж бүрэн, зохистой менежментийг багтаасан олон талт баримт бичгийг хүргүүлж буйдаа баяртай байна.

“Энэ ажлыг удирдан ажиллах нь миний хувьд нэр төрийн хэрэг байлаа. Уул уурхайн компаниуд, Засгийн газар болон хөрөнгө оруулагчдыг энэхүү Стандартыг ашиглан, дэлхийн хэмжээнд хаягдлын байгууламжуудын аюулгүй ажиллагааг хангах чиглэлээр хамтран ажиллахыг уриалж байна. Стандартыг цаашид хараат бус байгууллагууд улам чанаржуулан, сайжруулж явна гэдэгт итгэж байна.”

**Др Бруно Оберле, Олон улсын хаягдлын хяналт,  
Дарга**



## Танилцуулḡа

БОНЗ-ын экосистем

БОНЗ-ын аргачлал

Судалḡааны жишээ:

Брумадино (Brumadinho) дахь хаяḡдлын  
далан задарсан түүх

**ХАВСРАЛТ 1, 2** 

# Хавсралт 1. Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн салбарт хамаарах дотоод, гадаадын хүрээлэл/шаардлагууд

## БОНЗ-ын дотоодын хүрээлүүд

Доорх хэсэг нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компаниудад зориулан хамаарах байгууллага болон төрийн байгууллагуудын зүгээс бэлтгэн гаргасан БОНЗ-ын хүрээлүүдийг багтаасан. Мөн энэ ангилалд Монгол Улсын соёрхон баталсан болон хууль тогтоомжоор баталсан БОНЗ-ын олон улсын хүрээлүүдийг багтаав.

## БОНЗ-ЫН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЛҮҮД: НИЙТЛЭГ

### 1) Монголын компаниудад зориулсан БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамж (2022), Санхүүгийн зохицуулах хороо

Монголын компаниудад зориулсан БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамж хэмээх баримт бичиг нь олон улсын тогтвортой хөгжлийн тайлагналын хүрээлэл болон чиг хандлагыг тусгасны зэрэгцээ хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд болон бусад үнэт цаас гаргагчдын зүгээс тогтвортой хөгжлийн бодлого, үйл ажиллагаагаа хэрхэн тайлагнах тусгайлсан алхмуудыг тусгасан байдаг. Удирдамж нь тогтвортой хөгжлийн чиглэлээр ил тод тайлагнах, мэдээлэхэд ашиглаж болох үзүүлэлт, шалгууруудыг багтаасан. Энэхүү удирдамжийг Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ), Монголын хөрөнгийн бирж (МХБ), Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо (ТоС), Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК), НҮБ-ын Тогтвортой байдлын төлөөх санхүүгийн төвүүдийн олон улсын сүлжээ (ТБТСОУС- FC4S), НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (НҮБ БОХ), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), Монгол Улс дахь НҮБ-ын Суурин төлөөлөгчийн газар, Даян дэлхийн байгаль орчны сан (GEF) болон НҮБ-ын ТХЗ-ын хамтарсан сан зэрэг байгууллагуудын санхүүжилтээр боловсруулсан.

Удирдамж нь бүхий л компаниудад зориулагдсан бөгөөд аль нэг салбарт хамаарах тусгайлсан зөвлөмж тусгагдаагүй. Удирдамжийг сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлнэ. Тус баримт бичгийг СЗХ-ны зохицуулалтад хамаарах байгууллагууд болон даатгалын компаниуд, брокерын компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд, хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд болон бусад байгууллагуудад хүргэжээ. СЗХ одоогоор удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьдаггүй, харин МХБ дээр бүртгэлтэй компаниудад 2023 оноос эхлэн хэрэгжилтийн тайлан ирүүлж байх шаардлага тавихаар төлөвлөж байна.

## **2) ОУИТБС-ын стандарт (2019), Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга**

Монгол Улс нь Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгад (EITI) 2006 онд анх нэгдсэн. ОУИТБС нь Норвег улсад төвтэй олон улсын санаачилга юм. Байгалийн нөөцийн удирдлагын талаарх ойлголтыг бий болгох, төр болон компанийн засаглал, тайлагнал, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх, олборлох салбарын бодлого боловсруулагчид болон олон талт оролцогчдыг өгөгдөл мэдээллээр хангах зэрэг зорилготой. ОУИТБС-ын гишүүн орнууд нь олборлох үйлдвэрлэлийн салбарын нэмүү өртгийн сүлжээнд хамаарах тусгай зөвшөөрөл олголт, төрд хэрхэн орлого төвлөрүүлдэг, олон нийт үүнээс хэрхэн үр шим хүртдэг зэрэг багц мэдээллийг ил тод болгож нийтлэх үүрэг хүлээдэг.

2019 онд ОУИТБС нь ОУИТБС-ын Стандартыг батлан гаргасан. Энэ нь байгалийн баялгийн засаглалын сайжруулах ил тод байдлын олон улсын стандарт юм. ОУИТБС-ын стандарт нь ашигт малтмал, байгалийн хий, газрын тосны салбарын үйл ажиллагааг тайлагнах шаардлага, удирдамжаар хангаж, уг мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгахыг шаарддаг. Стандарт нь мөн тусгай зөвшөөрлийн ил тод байдал, төрийн өмчид хамаарах газрын тосны борлуулалт зэрэг олон салбар чиглэлд хамааралтай. Монгол Улсын ОУИТБС-ын анхдугаар нэгтгэл тайланг 2006 онд боловсруулан гаргасан бол хамгийн сүүлд 2020 оны 15 дугаар нэгтгэл тайланг боловсруулжээ.

Монголын ОУИТБС-ын чухал үзүүлэлт нь иж бүрэн тайлагналын (ereporting.eiti.mn) болон гэрээний ил тод байдлын (iltodgereee.mn) цахим систем юм. Тайлагналын цахим систем нь санхүүгийн мэдээллийг үзэх, татаж авах боломжийг олгодог бөгөөд үүнд байгаль орчны нөхөн сэргээлт, төв болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад төлсөн татвар төлбөр хураамжийн мэдээллүүд багтдаг. Гэрээний ил тод байдлын сан нь төрийн байгууллагуудтай (мөн орон нутгийн) хийсэн гэрээ болох газар ашиглах гэрээ, ус ашиглах гэрээ болон нийгмийн хариуцлагын гэрээ зэргийг ил тод болгохыг уул уурхайн компаниудаас шаарддаг.

Монголын ОУИТБС нь компаниудтай аливаа албан ёсны гэрээ хэлцэл байгуулдаггүй. Төрийн байгууллагууд нь ОУИТБС-ыг тусгай зөвшөөрлийн нөхцөл болгодог. Монголын ОУИТБС нь компаниудын тайлагнал, ил тод болгож буй байдалд хяналт тавьдаг ч албан ёсны эрх мэдэл байхгүй. Монголын ОУИТБС-ын 2020 оны 15 дугаар нэгтгэл тайланд 59 компани хамрагджээ.

## **УУЛ УУРХАЙН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДЫН ГАРГАСАН БОНЗ-ЫН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЛҮҮД**

### **3) Хариуцлагатай уул уурхайн кодекс (2018), Монголын уул уурхайн үндэсний ассоциаци**

Монголын уул уурхайн үндэсний ассоциаци (МУУҮА) нь хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэхийн төлөө ажилладаг ашгийн бус, төрийн бус байгууллага юм. Тус байгууллагын зүгээс олон тооны санаачилгууд боловсруулан гаргасны дотор 2018 онд гаргасан Хариуцлагатай уул уурхайн кодекс багтаж байна. Тус кодекс нь Монголын уул уурхайн компаниудад зориулагдсан бөгөөд Компанийн засаглал болон ил тод байдал, Хөдөлмөрийн харилцаа, ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, Хүрээлэн буй байгаль орчны хамгаалал, Орон нутгийн хөгжил, нутгийн

иргэдийн оролцоо гэсэн 5 чиглэлд тавигдах шаардлага, зөвлөмжийг тусгасан. Кодекс нь мөн уул уурхайн үйл ажиллагаанд байгаль орчин, хүний эрхийг хангахад чиглэсэн алхмуудыг багтаажээ. Кодексыг боловсруулахад НҮБХХ-ийн санхүүжилт бүхий Байгаль орчны засаглал хөтөлбөр дэмжин ажилласан байна.

Кодексын хэрэгжилтийг компаниуд өөрсдөө үнэлэх бөгөөд хараат бус аудитад хамрагдан хэрэгжилтээ баталгаажуулдаг.

“Эрдэнэт” болон “Эрдэнэс Тавантолгой” зэрэг уул уурхайн компаниуд энэхүү сайн дурын шаардлагад нэгдэн орохоор Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Кодексыг 2019 онд хэрэгжүүлж эхэлснээс хойш нийт 30 орчим компани энэхүү шаардлагад нэгдэн оржээ.

## ТОДОРХОЙ ЧИГЛЭЛЭЭРХ БОНЗ-ЫН ҮНДЭСНИЙ ШААРДЛАГУУД

### 4) Монгол Улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний кодекс (2020 оны төсөл), МОНВАЛ хороо

Монголын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний (МОНВАЛ) кодексийг Австралийн ЖОРК (JORC) болон Канадын ашигт малтмалын нөөцийн тодорхойлолт (CIM) зэрэгтэй ижил төстэй ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний стандарт бий болгох зорилгоор боловсруулжээ. Энэ нь ашигт малтмалын хайгуулын үр дүн, нөөц болон баялгийг тайлагнасан бодит, найдвартай мэдээлэлтэй байх боломжийг хөрөнгө оруулагчдад олгодог. 2015 оноос хойш Австрали-Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн (АМЕР 2) зүгээс олон улсын шаардлага хангасан МОНВАЛ кодексийг боловсруулахад Санхүүгийн зохицуулах хороонд дэмжлэг үзүүлэн ажилласан байна. Дэмжлэгийн үр дүнд 2021 оны 02 дугаар сарын 5-ны өдөр МОНВАЛ хороог байгуулжээ.

МОНВАЛ кодексийг боловсруулахад Монгол Улсын төрийн холбогдох байгууллагууд, мэргэжлийн холбоод, үндэсний болон олон улсын мэргэжилтнүүд, IMVAL буюу Олон улсын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний хороо, АМЕР хөтөлбөр хамтран ажилласан байна. Хороо нь МОНВАЛ кодексийг боловсруулахдаа үндэсний код болон стандартад тавигдах шаардлагуудыг тусгаж, зэрэгцээ санхүүгийн байгууллагуудын зүгээс үнэн бодит хэмээн үздэг маягтуудыг боловсруулдаг Олон улсын ашигт малтмалын үнэлгээний хорооны кодоод үндэслэн боловсруулжээ. Тухайн хороо нь Австрали улсын уул уурхайн мэргэжлийн дээд байгууллага болох AusIMM буюу Австралийн уул уурхай, металлургийн институтын дэмжлэгтэйгээр ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ, техникийн үнэлгээг олон нийтэд тайлагнах Австрали-Азийн кодыг удирдамж болгон, МОНВАЛ кодексийг боловсруулсан байна.

Кодексийн зорилго нь ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг стандартчилагдсан, системтэй байдлаар, өндөр мэргэшсэн үнэлгээчид хийснээр компанийн тайланд иж бүрнээр ил тод мэдээлэх боломжийг олгох юм. Уг кодексийг дагалдах гарын авлагуудыг боловсруулан “стандарт үйл ажиллагааны журам” болгож, ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний хандлага, арга зүйд ашиглах нь чухал тул МОНВАЛ хороо гарын авлагуудыг боловсруулж байна.

МОНВАЛ кодекс хараахан батлагдаагүй байгаа ч эрх зүй, зохицуулалтын чиглэлээр зарим ахиц гараад байна. 2022 оны Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ хийх заалт нэмэгдэж

МОНВАЛ кодексийг нэвтрүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн. (ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ хууль 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжсэн (legalinfo.mn)).

### **5) Компанийн засаглалын кодекс (2022), Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)**

Компанийн засаглалын кодексийг СЗХ-ноос боловсруулан гаргасан ба МХБ дээр бүртгэлтэй компаниуд заавал, бусад компани аж ахуйн нэгж сайн дурын үндсэн дээр даган мөрдөж болно. Энэхүү кодексийн гол зорилго нь олон улсын сайн туршлагаудыг нэвтрүүлэх, урт хугацааны үнэ цэн бий болгох замаар хөрөнгө оруулагч болон оролцогч талуудын ашиг сонирхлыг хамгаалахад оршино. Тус кодекс үндсэн 9 зарчмыг тусгасан бөгөөд үүнд ТУЗ, түүний бүрэлдэхүүн, ТУЗ-ийн хороод болон чиг үүрэг, Тайлагнал болон мэдээлэл ил тод болгох, Аудитын болон хяналтын тогтолцоо, Эрсдэлийн удирдлага, Цалин хөлс, Компанийн соёл болон Хувьцаа эзэмшигчдийн эрх зэрэг багтдаг.

МХБ дээр уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 15 компани бүртгэлтэй байна. Бүртгэлийн ерөнхий журмын хувьд тухайн компаниуд дараах гол мэдээллийг олон нийтэд ил тод болгох үүрэг хүлээнэ:

1. Санхүүгийн тайлангууд
2. Компанийн засаглалын өөрийн үнэлгээний тайлан
3. Гол хувьцаа эзэмшигчид, хувьцаа эзэмшигчдэд гарсан өөрчлөлтүүд
4. Үйл ажиллагааны тайлангууд
5. ТУЗ-ийн хурал, гаргасан шийдвэрүүд

Эдгээр тайлангуудыг МХБ-ийн вэбсайт дээр нийтэлдэг.

### **6) Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2019), УУХҮЯ**

УУХҮЯ-ны зүгээс 2019 онд салбарт жендэрийн талаар баримтлах бодлогыг батлан гаргасан. Энэхүү бодлогын баримт бичиг нь жендэрийн тэгш байдлыг хангах, олон талт байдал болон хүртээмжийг сайжруулах, хүний эрхийг хүндэтгэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой. Салбарын хувьд оролцогч талуудын жендэр болон хүний эрхийн асуудлаарх мэдрэмжийг сайжруулахыг зорьжээ.

АМЕП 2 хөтөлбөрөөс “Эрдэс баялгийн салбар дахь хүний эрх жендэрийн цахим сургалтын хөтөлбөр” боловсруулж, УУХҮЯ-наас дэмжин ажилласан байна. Эрдэс баялгийн салбарын ажиллагсад, менежерүүдэд зориулсан энэхүү цахим сургалтын хөтөлбөр нь ажлын байран дахь жендэр, хамтын оролцоо, хүний эрхийн ойлголт, мэдрэмжийг дэмжих зорилготой. 2022 оны 6 дугаар сард эхлүүлсэн 7 модуль бүхий цахим сургалтад нийт 1,198 ажилтан хамрагдаад байна.

УУХҮЯ-ны зүгээс бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон гарч буй ахиц дэвшилд системтэйгээр дүн шинжилгээ хийгээгүй байна. Харин Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл (MERIT) энэхүү бодлогын үр дүнд үнэлгээ хийсэн бөгөөд тайлан нь 2023 оны 2 дугаар сард эцэслэгдэн гарчээ.



### **7) Монгол Улсын үндэсний стандарт MNS 9001: 2016 (2016), Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар**

2016 онд Монгол Улс нь Олон улсын стандартчиллын байгууллагын ISO 9001 Чанарын менежментийн стандартыг Монгол Улсын үндэсний стандарт (MNS) 9001:2016 хэмээн баталсан байна. Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь төрийн байгууллага бөгөөд Монгол Улсад баримталж буй бүхий л стандартыг батлах, хэвлэн нийтлүүлэх чиг үүрэгтэй. Мөн Олон улсын стандартчиллын байгууллагад Монгол Улсаа төлөөлдөг. Чанарын менежментийн стандартын үндсэн зорилго нь хэрэглэгчдийн шаардлагад нийцүүлэх, хэрэглэгчдийн хүлээлтээс давсан стандартыг хангах явдал юм. Энэ нь компаниудын менежментийн тогтолцоонд чухал нөлөө бүхий стандарт.

СХЗГ-ын вэбсайт дээр уул уурхай болон уул уурхайн ханган нийлүүлэлтийн чиглэлээр ажилладаг хоёр компани болох “Эрдэнэт” болон “Мера” компаниуд MNS 9001 стандартыг ханган магадлан итгэмжлэгдсэн тухай дурджээ. Гэхдээ энд дурдагдаагүй ч уг стандартыг ханган, магадлан итгэмжлэгдсэн компани, аж ахуйн нэгжүүд олон байна.

### **8) Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах үндэсний стандарт, СХЗТ**

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр үндэсний хэд хэдэн стандарт буйн дотор MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн стандарт багтаж байна. Эдгээр стандартыг энэхүү тайланд зориулан бүлэглэн багтаав.

### **9) Монгол Улсын усны менежментийн үйл ажиллагааны сайн дурын кодекс (2016), ОУСК**

Олон улсын санхүүгийн корпорац (IFC) нь Монгол Улсын усны менежментийн үйл ажиллагааны сайн дурын кодексийг 2016 онд боловсруулжээ. Энэхүү кодексийг хэрэгжүүлэх амлалт авсан компаниуд нь усны тогтвортой ашиглалтыг хангах чиглэлээр үүрэг хариуцлага хүлээж, даган мөрдөж, тогтвортой ашиглах үүрэг хүлээнэ. Компаниуд нь ус ашиглалт дээр хэмнэлт гаргах, мониторингийн ил тод байдлыг хангах, усны менежментэд өргөн хүрээний оролцоог хангах үүрэгтэй.

Энэхүү кодексийг зөвшөөрөн нэгдэн орсон компаниудад “Энержи Ресурс”, “Эрдэнэс Монгол”, “Эрдэнэ Ресурс Девелопмент”, “Эрдэнэс Тавантолгой”, “Гоби Коул энд Энержи”, “Оюутолгой”, “Саус Гоби Сэндс” болон “Терра Энержи” нар багтжээ. Нэгдэн орсон компаниуд жил тутам тайлан гаргаж, дараах чиглэлээр үнэлгээ хийх үүрэг хүлээдэг:

1. Ил тод, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах
2. Дотоодын хууль тогтоомж болон олон улсын стандартуудыг даган мөрдөх
3. Идэвх санаачилга, хүртээмжтэй оролцоог хангах
4. Усны нөөцийн үр дүнтэй удирдлага болон хамгаалал хэрэгжүүлэх
5. Орон нутгийн дэд бүтэц, үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх

Австралийн “Састайнабилити” компанийн Монгол дахь салбар 2019 оноос хойш тус хөтөлбөрийн Ажлын албаны үүргийг гүйцэтгэж иржээ. Тус байгууллага нэгдэн орсон компаниудтай улирал тутамд дугуй ширээний уулзалт зохион байгуулж, кодексийн хэрэгжилттэй холбоотой жил тутмын тайлан ирүүлэхийг шаарддаг.

## САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДААС ГАРГАСАН БОНЗ-ЫН ДОТООДЫН ШААРДЛАГУУД

### **10) Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн 8 зарчим (2014), Монголын тогтвортой санхүүжилтийн хөгжлийн холбоо**

Монголын Тогтвортой санхүүжилтийн хөгжлийн холбоо нь эгнээндээ 15 арилжааны банкныг нэгтгэдэг. Гишүүн банкнууд нь Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн 8 зарчмыг дагаж мөрдөх үүрэг хүлээдэг. Зарчмууд нь банкны үйл ажиллагаа болон санхүүжилтийн бүтээгдэхүүнийг хамарсан зөвлөмжүүдийг тусгадаг. Зарчимд заасны дагуу гишүүн банкууд уул уурхай, барилга, үйлдвэрлэл болон хөдөө аж ахуйн салбарын аж ахуйн нэгжүүдэд зээл олгохдоо урьдчилсан магадлан шинжилгээ хийх үүрэгтэй. Гэвч холбооны зүгээс Зарчмын хэрэгжилтийн тайлан гаргахыг шаарддаггүй, хэрэгжилтэд ямар нэг хяналт тавьдаггүй байна.

### **11) Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн зарчим, Уул уурхайн салбарын удирдамж (2014), Монголын тогтвортой санхүүжилтийн хөгжлийн холбоо**

Тогтвортой санхүүжилтийн хөгжлийн холбооноос байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөлөл ихтэй уул уурхай, барилга, хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын төслүүдийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлэх, удирдах зорилгоор Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудын дагалдах баримт бичиг болгож боловсруулсан. Банкнууд эдгээр удирдамжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Уул уурхайн салбарын удирдамж нь уул уурхайн салбар, уул уурхайн үйл ажиллагаанд зээл олгож буй байгууллагад зориулсан Тогтвортой санхүүжилтийн хөгжлийн холбооны баримтлах баримт бичиг хэлбэрээр боловсруулагджээ. Монголын тогтвортой санхүүжилтийн хөгжлийн холбоонд удирдамжийг уул уурхайн компаниуд хэрхэн ашиглаж буй талаар ямар нэгэн мэдээлэл байхгүй байна.

### **БОНЗ-ын олон улсын шаардлага/ хүрээллүүд**

БОНЗ-ын олон улсын шаардлагууд нь олон улсын хэмжээнд ашиглахад зориулан олон улсын байгууллагуудаас гаргасан БОНЗ-ын шаардлага/хүрээ юм.

### **БОНЗ-ЫН ОЛОН УЛСЫН ШААРДЛАГУУД: НИЙТЛЭГ**

#### **1) Олон улсын тайлагналын санаачилгын стандартууд (2021), Олон улсын тайлагналын санаачилга**

Олон улсын тайлагналын санаачилга (GRI) нь байгууллагуудын тогтвортой байдлыг сайжруулах, тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилготой. Энэ нь дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, хамгийн түгээмэл баримталдаг БОНЗ-ын шаардлагуудын нэг. 100 гаруй улсад 10,000 байгууллага баримталж буй бөгөөд Форчун сэтгүүлийн жагсаалтад багтдаг 500 компанийн 67% нь сүүлд гаргасан тогтвортой байдлын тайландаа Олон улсын тайлагналын санаачилгын стандартыг ашиглажээ. Стандарт нь компаниудад тогтвортой байдлын тайлагналаа сайжруулах, оролцогч талууддаа эдийн засаг, байгаль орчин болон нийгмийн үр өгөөж бий болгоход дэмжлэг болдог. Стандарт нь Нүүрсний, Газрын тосны болон

Байгалийн Хийн салбарын бие даасан стандартуудтай.

## **2) Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартууд (2021), Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын сан**

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын сан (IFRS) нь (цаашид СТОУС гэх) Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандарт болон Нэгдсэн тайлагналын хүрээг (IRF) хариуцан ажилладаг. Тус сан анх удаа Олон улсын тогтвортой байдлын стандартын хороог (ISSB) байгуулж, тогтвортой байдлын бүртгэлийн стандартын хэрэглээг дэмжиж байна. СТОУС нь тогтвортой байдалтай холбоотой ил тод мэдээллийн олон улсын стандарт гаргаж, хөрөнгө оруулагч болон санхүүгийн бусад оролцогч талуудад компанийн тогтвортой байдлын мэдээлэлд суурилсан шийдвэр гаргахад дэмжлэг болох зорилготой. Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын хүрээнд 77 салбарт хамаарах стандартыг боловсруулж, 2021 онд хэвлэн нийтэлсэн. Үүнд нүүрс, газрын тос, байгалийн хий, ашигт малтмал болон металлын стандартууд багтсан байна.

## **3) Компанийн тайланг ТХЗ-уудтай уялдуулах нь, практик хөтөч (2018), НҮБ-ын Даян дэлхийн гэрээ**

НҮБ-ын Даян дэлхийн гэрээ нь тогтвортой хөгжлийн нийтлэг зорилтуудыг дэмжих, хэрэгжүүлэхийн тулд үүрэг амлалт хүлээн нэгдэж ордог сайн дурын санаачилга юм. Энэхүү санаачилга нь бүхий л салбарын компаниудыг стратеги, үйл ажиллагаагаа олон улсын тогтвортой хөгжлийн зарчмуудад нийцүүлэхийг уриалдаг. Гэрээнд нэгдсэн байгууллагууд хүний эрхийг дээдлэх, хөдөлмөр эрхлэлтийн зохистой орчин бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, авлигал, хээл хахуулийн эсрэг тууштай үйл ажиллагаа явуулах гэсэн 4 үндсэн чиглэлээр 10 зарчмыг бизнесийн үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг. Практик хөтөч нь тогтвортой байдлын гүйцэтгэл, явцаа хэрхэн тайлагнах болон ТХЗ-уудтай уялдуулахтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан байдаг.

Дэлхийн хэмжээнд 162 орны 20,000 гаруй компани, байгууллагууд Даян дэлхийн гэрээнд нэгдээд байна. Өнөөгийн байдлаар Монгол Улсаас 5 компани энэхүү санаачилгад нэгдээд байгаа нь олборлох салбарын бус компаниуд юм.

## **4) Үндэстэн дамнасан компанийн удирдамж (2011), Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)**

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) Үндэстэн дамнасан компанийн удирдамж нь үндэстэн дамнасан үйл ажиллагаа явуулдаг компаниудад зориулсан зөвлөмж бөгөөд дэлхийн аль ч өнцөгт явуулж буй бизнесийн үйл ажиллагаандаа хариуцлагатай хандахыг уриалдаг. Хүний эрх, хөдөлмөр эрхлэлт, байгаль орчин, мэдээллийн ил тод байдал, авилгал, татвар зэрэг өргөн хүрээний асуудлыг хамаардаг. Олон улсад ёс зүйтэй бизнес явуулах удирдамж, жишгийг хамаарсан хууль тогтоомжууд, хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээнд нийцүүлэн гаргасан бөгөөд заавал даган мөрдөх үүрэггүй, бизнесийн хариуцлагатай үйл ажиллагааны иж бүрэн зөвлөмж юм. Үүнийг олон талууд хүлээн зөвшөөрч, Засгийн газруудын зүгээс түгээн дэлгэрүүлэхээр ажиллаж байна.

Монгол Улс нь ЭЗХАХБ-ын гишүүн бус бөгөөд энэхүү удирдамжийг хариуцсан үндэсний эрх бүхий этгээд байхгүй.

## УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МЭРГЭЖЛИЙН ХОЛБООДЫН ГАРГАСАН БОНЗ-ЫН ОЛОН УЛСЫН ШААРДЛАГА/ ХҮРЭЭЛЛҮҮД

### 5) *Олборлолтын зарчмууд (2022), Олон улсын металл, уул уурхайн зөвлөл*

Уул уурхай ба металлын олон улсын зөвлөлийн (ICMM) Олборлолтын зарчмууд нь нийт 39 гүйцэтгэлийн хүлээгдэж буй үр дүн болон хамаарах 8 албан ёсны байр суурийн мэдэгдлээр дамжуулан гишүүн компаниудад байгаль орчин, нийгэм болон засаглалын шаардлагуудыг тавьдаг. Олборлолтын зарчмуудын хэрэгжилт нь НҮБ-ын ТХЗ болон Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх Парисын гэрээний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлдэг. Уул уурхай ба металлын олон улсын зөвлөлийн Зарчим 10.3 нь гишүүдээсээ “Жил бүр эдийн засаг, байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлээ Олон улсын тайлагналын санаачилгын (GRI) тогтвортой хөгжлийн тайлангийн стандартын дагуу тайлагнах”-ыг шаарддаг.

Уул уурхай ба металлын олон улсын зөвлөлд Монгол Улсаас одоогоор ямар нэгэн аж ахуйн нэгж гишүүнчлэлгүй. Гэхдээ энэхүү зарчмыг даган мөрдөхөөр гарын үсэг зурж нэгдэн орсон “Рио Тинто” Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байна.

### 6) *Хариуцлагатай уул уурхайн индекс (2022), Хариуцлагатай уул уурхайн сан*

Хариуцлагатай уул уурхайн сангаас боловсруулсан Хариуцлагатай уул уурхайн индекс (RMI) тайлан нь томоохон уул уурхайн компаниудын бодлого, үйл ажиллагааг компани болон уурхайн түвшинд нь үнэлдэг. Тус үнэлгээ эдийн засаг, байгаль орчин, нийгэм болон засаглалын олон асуудлыг хамардаг бөгөөд компаниудын зүгээс БОНЗ-ын асуудалд системтэй байдлаар хандаж буй цар хүрээг нь судлан үздэг. Үүнд 6 ерөнхий сэдвийн 44 сэдэв багтах ба Ерөнхий сэдвүүдэд Эдийн засгийн хөгжил, Бизнесийн ёс зүй, Үйл ажиллагааны мөчлөгийн удирдлага, Олон нийтийн сайн сайхан байдал, Ажиллах нөхцөл болон Байгаль орчны хариуцлага зэрэг нь багтана. Үнэлгээг олон нийтэд нээлттэй буй мэдээлэлд суурилан хийдэг.

Хариуцлагатай уул уурхайн индексийн 2022 оны тайлан нийтдээ 22 улсын компаниудыг хамарсан бөгөөд үүнд олон нийтэд нээлттэй, төрийн өмчит болон хувийн компаниуд багтжээ. Тухайн компаниуд нь 57 улсад 1,000 гаруй уурхай ажиллуулдаг. “Рио Тинто”-д хамаарах Оюутолгойн уурхай Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байна.

Хариуцлагатай уул уурхайн индексийн тайлангийн хувьд шаардлага/хүрээлэл биш боловч гуравдагч талын хараат бус үнэлгээ нь БОНЗ-ын экосистемийн нэг чухал хэсэг юм. Хөрөнгө оруулагчдын зүгээс үнэлгээний үр дүнг хянадаг тул энэхүү гарын авлагад оруулав.

### 7) *Байгалийн баялгийн тунхаг (2010), Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн*

Байгалийн Баялгийн Тунхаг нь нөөц баялгийг хамгийн зөвөөр удирдахын тулд явуулах бодлогын сонголт, хэрэгжүүлэх практик зөвлөгөөг төр засаг, нийгэм ба олон улсын хамтын нийгэмлэгт санал болгодог. Баялаг ихтэй улс орнууд өөрт тулгарах сорилтуудыг дангаар сөрөх бус, харин өмнө хуримтлагдсан туршлагаас суралцан, урьд гарсан алдааг давтахаас зайлсхийх боломжийг энэхүү удирдамж олгоно. Шийдвэр гаргахад нь төр засагт туслах 12 дүрмийг уг тунхагт тусгасан.

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн (ББЗХ)-гээс Баялгийн засаглалын индекс (БЗИ)-ийг улс орнуудад зориулан гаргадаг бөгөөд энэ чиглэлийн дэлхийд тэргүүлэх мэргэжилтнүүдийн боловсруулсан аргачлалын дагуу хийгддэг, олборлох салбарын засаглалын түвшинг тодорхойлох олон улсын тэргүүлэх судалгаа болно. Энэ нь дэлхийн улс орнуудын байгалийн баялгийн засаглалын нөхцөл байдлыг сайтар ойлгоход тусалдаг.

Монгол Улсын Баялгийн засаглалын индексийг хамгийн сүүлд 2021 онд гаргажээ.

Энэ нь ямар нэгэн шаардлага бус боловч төрийн зүгээс уул уурхайн компаниудаас хүлээх хүлээлт, БОНЗ-д хамаарах компанийн бодлого, үйл ажиллагаанд нөлөөлдөг тул энэ шалтгаанаар тунхагийг гарын авлагад оруулав.

#### **8) Тогтвортой уул уурхайн төлөө (2004), Канадын уул уурхайн ассоциаци**

Канадын Уул уурхайн Ассоциациас 2004 онд санаачлан боловсруулж хэрэгжүүлсэн Тогтвортой уул уурхайн төлөө (TSM) (цаашид ТиЭсЭм гэх) үйл ажиллагааны үнэлгээний систем нь уул уурхайн компаниудад байгаль орчин, нийгмийн томоохон эрсдэлүүдээ удирдахад нь туслах зорилго бүхий олон нийтэд танигдсан тогтвортой хөгжлийн хөтөлбөр юм. Энэхүү системийг холбооны гишүүд заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд одоогоор 11 улсын уул уурхайн ассоциаци хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Уул уурхайн бизнесүүд нь ТиСиЭм хөтөлбөрт хамаарах багц журмын дагуу гүйцэтгэлээ хэмжин, үр дүнг олон нийтэд ил тод болгодог. Хөтөлбөр нь байгаль орчин, нийгмийн чиглэлд хамаарах гүйцэтгэлтэй холбоотой багц үзүүлэлтүүдийг багтаадаг. Улс орнууд өөр өөрийн онцлог шаардлагад нийцүүлэн бага зэрэг өөрчлөлт оруулах боломжтой.

Тогтвортой уул уурхайн төлөө хөтөлбөрт Монгол Улсаас ямар нэгэн оролцогч гишүүн байхгүй.

#### **9) Хариуцлагатай уул уурхайн баталгаажуулалтын санаачилга (2021), "Хариуцлагатай уул уурхайн санаачилгын баталгаажуулалт" Олон улсын мэргэжлийн байгууллагуудын эвсэл**

Хариуцлагатай уул уурхайн баталгаажуулалтын санаачилгыг (IRMA) анх 2006 онд төрийн бус байгууллагууд, ашигт малтмал, металлын худалдан авалтын чиглэлээр ажилладаг компаниуд, уул уурхайн компаниуд болон үйлдвэрчний эвлэл хамтран үүсгэсэн. Уг санаачилга нь Хариуцлагатай уул уурхайн баталгаажуулалтыг гуравдагч талын хараат бус баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлтээр хийдэг. 2021 оны 12 дугаар сард тус санаачилга нь олон нийтээр хэлэлцүүлэхээр Хариуцлагатай ашигт малтмалын хайгуул, баяжуулалтын стандартын хөтөлбөр гаргасан.

Энэхүү санаачилгад одоогоор Монгол Улсаас ямар нэгэн оролцоо байхгүй.

#### **10) БеттерКоул (Илүү сайн нүүрс) стандарт: Код 2.0 (2021), БеттерКоул**

БеттерКоул стандартыг нүүрсний томоохон худалдан авагчдын хамтран байгуулсан төрийн бус байгууллага боловсруулсан. Уг код нь нүүрсний ханган нийлүүлэлтийн хариуцлагатай сүлжээ бий болгоход зорьдог. Энэхүү стандартаар БОНЗ-ын үндсэн гурван шатыг үнэлэх замаар нүүрсний үйлдвэрлэгч нь кодоор тавигдаж буй шаардлагыг хангах чиглэлд захиц гаргаж буй эсэхийг баталгаажуулдаг. БеттерКоул стандарт нь нүүрсний салбарын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн

стандарт болжээ. Тус код 12 зарчим, 144 заалтаас бүрдэх бөгөөд БОНЗ-ын өргөн хүрээний сэдвийг хамардаг. Кодын гурав дахь хувилбарыг 2021 онд гаргасан. Энэ нь уул уурхайн салбарын олон улсын практикт бүрэн нийцсэн, иж бүрэн байдлаар боловсруулагдсан.

Монгол Улсад БеттерКоул байгууллагын гишүүн байхгүй.

#### **11) Хариуцлагатай алтны удирдамж (2010), Лондоны алтны зах зээлийн холбоо**

Хариуцлагатай алтны удирдамжийг нь Лондоны алтны зах зээлийн холбоо (LBMA)-ноос боловсруулсан. Гол зорилго нь алтны салбар дахь хүний эрхийн зөрчлийг шийдэх, зөрчилдөөнийг багасгах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх явдал. Энэхүү удирдамжаар ашигт малтмал, металлыг зөвхөн хариуцлагатай, зөрчилгүй эх үүсвэрээс импортлохыг шаарддаг. Мөн компанийн засаглал болон байгаль орчин, тогтвортой хөгжлийн чиглэлийн үүрэг хариуцлагыг тодорхойлж, магадлан шинжилгээ хийлгэх шаардлагыг Лондоны алтны зах зээлийн холбооны гишүүд баримтлахаар тусгасан байдаг.

Лондоны алтны зах зээлийн холбооны гишүүн байгууллага Монгол Улсад байхгүй.

#### **12) Арга ажиллагааны код, Хариуцлагатай үнэт эдлэлийн зөвлөл (2019), Үйлдвэрлэлийн сүлжээний гэрчилгээжүүлэлт (2017), Хариуцлагатай үнэт эдлэлийн зөвлөл**

Хариуцлагатай үнэт эдлэлийн зөвлөл (RJC) нь 2005 онд алт, очир алмааз эдлэлийн салбарын арав гаруй байгууллага хамтран байгуулсан байгууллага юм. Энэхүү байгууллага үнэт эдлэлийн ханган нийлүүлэлтийн сүлжээний гишүүдээсээ хоёр стандартыг даган мөрдөхийг шаарддаг. Үүний нэг нь сүлжээнд хамаарах компаниуд хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг удирдлага, үйл ажиллагаандаа уялдуулах боломжийг олгосон Үйлдвэрлэлийн сүлжээний практик ажиллагааны стандарт юм. Энэ нь ёс зүй, нийгэм, хүний эрх, хүрээлэн буй орчны нөхцөл байдлын үйл ажиллагаанд хамаардаг бол Сүлжээний стандарт нь мөшгих тогтолцоо, хариуцлагатай худалдан авалтад суурилсан.

Монгол Улсаас тус зөвлөлд гишүүнчлэлтэй байгууллага байхгүй.

#### **13) Хариуцлагатай алт олборлолтын зарчмууд (2019), Дэлхийн алтны зөвлөл**

Дэлхийн алтны зөвлөл нь Хариуцлагатай алт олборлолтын зарчмуудыг 2019 онд гаргаж, нийт нэмүү өртгийн сүлжээний хэмжээнд хариуцлагатай алт олборлолтыг дэмжих хүлээлтүүдийг тодорхойлсон. Эдгээр зарчмууд нь хүчин төгөлдөр стандартуудыг алтны салбарт зориулан нэг хүрээлэлд оруулан нэгтгэснээрээ алт олборлогч компаниудад хариуцлагатай үйлдвэрлэл явуулах боломж олгодог.

Монгол Улсаас тус зөвлөлд гишүүнчлэлтэй байгууллага байхгүй.

#### **14) Зэс, хар тугалга, никель болон цайрын хамтарсан магадлан шинжилгээний стандарт, Хариуцлагатай уул уурхайн санаачилга (2020), Хариуцлагатай зэс үйлдвэрлэгч (The Copper Mark)**

Зэс, хар тугалга, никель болон цайрын хамтарсан магадлан шинжилгээний

стандартыг Хариуцлагатай зэс үйлдвэрлэгч (The Copper Mark), Олон улсын хар тугалганы холбоо (ILA), Никелийн хүрээлэн (NI), Олон улсын цайрын холбоо (IZA) болон Хариуцлагатай ашигт малтмалын санаачилга (RMI) зэрэг байгууллага хамтран гаргасан. Гол зорилго нь зэс, хар тугалга, никель, цайрын үйлдвэрлэлийн олон улсын ханган нийлүүлэлтийн сүлжээний хариуцлагатай байдал, удирдлагыг сайжруулах юм. Стандарт нь сайн дурынх бөгөөд эдгээр металлын ханган нийлүүлэлтийн сүлжээний эрсдэлийг үнэлэх замаар үйлдвэрлэгч болон худалдаачдыг магадлан итгэмжилдэг.

Монгол Улсаас энэхүү стандартыг хангахаар “Оюутолгой” ХХК ажиллаж байна.

## ТОДОРХОЙ ЧИГЛЭЛД ХАМААРАХ БОНЗ-ЫН ОЛОН УЛСЫН ХҮРЭЭЛЛҮҮД

### **15) Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийг нээлттэй тайлагнах Ажлын хэсгийн зөвлөмж (2017), Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийг нээлттэй тайлагнах Ажлын хэсэг (TCFD)**

Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилтийг нээлттэй тайлагнах Ажлын хэсгийг (TCFD) Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс үүсгэн байгуулсан. Сайн дурын үндсэн дээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэж болзошгүй санхүүгийн эрсдэлийн талаарх мэдээллийг боловсруулах, тэдгээрийг ашиглан оролцогч талуудад мэдээлэл өгөх зорилготой. Ажлын хэсгийн зөвлөмжүүд нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэн засаглал, стратеги, эрсдэл, гүйцэтгэлд учрах эрсдэлийн талаар иж бүрэн, нэгдсэн мэдээллийг боловсруулах бөгөөд үүнд төлөвлөлтийн хувилбарууд, салбарын онцлогт тохирох шалгуур үзүүлэлтүүд мөн багтдаг.

### **16) ISO 14001 Байгаль орчны менежментийн систем 2015), Стандартчиллын олон улсын байгууллага (ISO)**

Стандартчиллын олон улсын байгууллагын (ISO) 14001 стандарт нь байгаль орчны менежментийн системийг тодорхойлдог бөгөөд үүнийг хангасан гэдгээ магадлан итгэмжлэлээр баталгаажуулдаг. Стандарт нь байгууллагуудад байгаль орчны менежментийн үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэхэд туслах хүрээллийг тогтоож өгдөг. Мөн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хэмжих, сайжруулах боломжоор хангадаг.

СХЗГ-ын вэбсайт дээр ISO 14001 стандартыг хангасан нь баталгаажсан 5 компани байгааг дурдсаны дотор уул уурхайн компани байхгүй байна. Гэхдээ уул уурхайн салбарын хэд хэдэн компани энэхүү стандартыг даган мөрддөг гэж мэдээлдэг байна.

### **17) ISO 26000 Нийгмийн хариуцлагын удирдамжууд (2010), Стандартчиллын олон улсын байгууллага (ISO)**

ISO 26000 стандарт нь нийгэм болон байгаль орчинд үзүүлэх эерэг нөлөөллийг тэргүүлэх чиглэл болгоход чиглүүлдэг. ISO 26000 стандартыг хангах нь компанийн тогтвортой байдлын талаарх хүсэл эрмэлзлийг үнэлэх чухал хүчин зүйлд тооцогддог болж байна.

Монгол Улсад олборлох үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй нэг компани



энэхүү стандартыг бүрэн хангасан хэмээн өөрийгөө тодорхойлжээ.

**18) ISO 45001 Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн систем (2018), Стандартчиллын олон улсын байгууллага (ISO)**

ISO 45001 нь ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны менежментийн систем нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ нь үр дүнтэй бодлого гаргах замаар гүйцэтгэлээ сайжруулах болон эрүүл мэнд, аюулгүй ажиллагаатай холбоотой эрсдэлийг удирдах боломжоор хангадаг. Уг стандартыг нэвтрүүлснээр ажлын байрны осол болон ажил таслалтыг бууруулах, ажилтнууд ажлаас гарах үйл явцыг багасгахад тусалдаг. Улмаар бүтээмжийг сайжруулан, даатгалын зардлыг бууруулан, эрүүл, аюулгүй ажиллагааны соёл бүрдүүлдэг.

СХЗГ-ын вэбсайт дээр 9 компани ISO 45001 стандартыг хангасан талаар мэдээлсэн ч тэр дунд уул уурхайн компани байхгүй байна. Гэхдээ олборлох салбарт үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн компани энэхүү стандартыг даган мөрддөг гэжээ.

**19) Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд (2011), Нэгдсэн үндэсний байгууллага (НҮБ)**

НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмууд нь бизнесийн байгууллагын зүгээс хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндлэх, хамгаалах, хангах чиглэлээр улс орнууд болон компаниудад зориулсан багц удирдамж юм. Заавал даган мөрдөх албагүй ч энэ зарчмууд нь хүний эрхийг хүндэтгэх компанийн хариуцлагыг тодорхойлдог. Компаниуд болон хөрөнгө оруулагчид хүний эрхийн асуудалд түлхүү анхаарал хандуулдаг болж байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гаргасан Үндэстэн дамнасан компаниудад зориулсан удирдамж нь энэхүү НҮБ-ын зарчимтай нийцсэн ба хувь хүмүүс болон ТББ-уудын зүгээс өөрийн улс хариуцсан этгээдэд хандан гомдол гаргах боломжийг нээж өгсөн байдаг.

**САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ГАРГАСАН БОНЗ-ЫН  
ОЛОН УЛСЫН ШААРДЛАГУУД**

**20) Экваторын зарчим (2020), Экваторын зарчмын санхүүгийн байгууллага**

Дэд бүтэц, үйлдвэрлэлийн томоохон төслүүдээс олон нийт, байгаль орчинд эерэг болон сөргөөр нөлөөлж болно. Санхүүгийн байгууллагуудад зориулан боловсруулсан Экваторын зарчим нь дэлхий дахинд болон нийт салбарын хэмжээнд мөрдөгдөх байгаль орчин, нийгмийн чиглэлийн бодлого, удирдамжийг нийтлэг шинжтэй уялдаа холбоотойгоор хөгжүүлэхийг зорьдог бөгөөд нийгэм, байгаль орчны хамгааллын шаардлагыг хангаагүй зээлдэгчид төслийн зээл олгохгүй байх үүрэг хүлээдэг.

Зарчмууд нь бүхий л салбарт, ялангуяа санхүүгийн дараах 5 бүтээгдэхүүнд хамаарна:

- a) Төслийн санхүүгийн зөвлөх үйлчилгээ,
- b) Төслийн санхүүжилт,
- c) Төсөл хэрэгжүүлэх зорилгоор байгууллагад олгосон зээл,
- d) Гүүрэн зээл



е) Төсөлд хамаарах дахин санхүүжилт болон төсөлд хамаарах хөрөнгө худалдан авах санхүүжилт.

38 улсын 137 санхүүгийн байгууллага Экваторын зарчмыг албан ёсоор батлан хэрэгжүүлдэг. Монгол Улсаас санхүүгийн ямар нэгэн байгууллага тус холбоонд гишүүнчлэлгүй байна.

## **21) Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн стандартууд (2012), ОУСК**

ОУСК нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөг багасгах зорилготой төслүүдийг идэвхтэй санхүүжүүлж оролцдог ба хэрэгжүүлж буй төсөл, үүнд тавигдах шаардлагаа зохион байгуулах үүрэг, хариуцлагын талаар тодорхойлж дараах төслүүдэд тавигдах Гүйцэтгэлийн 8 стандартыг батлан гаргажээ. Гүйцэтгэлийн 8 стандарт нь Нийгэм, байгаль орчны эрсдэл, нөлөөллийн үнэлгээ, удирдлага, Ажиллах хүч ба ажлын байрны нөхцөл, Нөөцийг үр ашигтай ашиглаж, бохирдлоос урьдчилан сэргийлэх, Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, Газар чөлөөлөлт, албадан нүүлгэн суурьшуулалт, Биологийн олон янз байдлын хамгаалал, амьд байгалийн нөөцийн тогтвортой удирдлага, Нутгийн уугуул иргэд, Соёлын өвийн эрсдэлийг хамардаг. Эдгээр стандарт нь нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн нэгдсэн үнэлгээ хийх, талуудын оролцоог хангах, төслийн хугацаанд байгаль орчин, нийгмийн эрсдэлийг удирдахыг тусгайлан заадаг. Стандарт нь мөн төслийн түвшинд тайлагнаж байх, тогтвортой хөгжлийн тайлан гаргаж байхыг хөхиүлэн дэмждэг. ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандартыг ямар ч компани ашиглаж болох бөгөөд энэ нь ОУСК-аас санхүүжилт авах урьдчилсан нөхцөл байдаг.

ОУСК нь Монгол Улсын уул уурхайн салбарт Оюутолгой төслөөс өөр оруулсан хөрөнгө оруулалт байхгүй.

## **22) Байгаль орчин, нийгмийн бодлого (2019), Европын сэргээн босголт, хөгжлийн банк**

Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зүгээс хөрөнгө оруулж буй, эсвэл зээл олгосон бүхий л компаниуд Байгаль орчин, нийгмийн бодлогыг заавал даган мөрдөх үүрэг хүлээдэг. Санхүүжүүлж буй төслийн нөхцөл байдлаас хамааран ЕСБХБ нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэсэн байхыг шаардаж болно. Төслийн үйл ажиллагааг удирдаж буй талууд нь санхүүжилтийн баримт бичигт дурдсан БОНЗ-ын шаардлагуудыг биелүүлэх үүргийг хүлээнэ. ЕСБХБ-ны үйлчлүүлэгчид нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон үүний Нийцлийн тайланг олон нийтэд ил тод болгох үүрэг хүлээдэггүй.

ЕСБХБ нь Монгол Улс дахь хамгийн том хувийн хэвшлийн хөрөнгө оруулагч бөгөөд нийт 2.275 сая еврогийн багцтай. Одоогоор ЕСБХБ нь Монгол Улсад 32 төсөл хэрэгжүүлж буйгаас 4 нь уул уурхайнх бөгөөд тэдгээр нь “Монголын Алт”, “Алтайн хүдэр”, “Оюутолгой”, “ЖиСиАр” компаниуд байна.

## Хавсралт 2. БОНЗ-тай холбоотой түгээмэл ашигладаг үг хэллэгүүд

**Нүүрсхүчлийн давхар ислийн хөрвүүлсэн дүн** гэж төрөл бүрийн хүлэмжийн хийн ялгарлыг дэлхийн дулаарал үүсгэх боломжтой харьцуулан харуулсан хэмжээг хэлнэ.

**Нүүрсхүчлийн ул мөр** гэж хувь хүн, байгууллага эсвэл бүтээгдэхүүний ялгаруулж буй хүлэмжийн хийн нийт хэмжээг нүүрсхүчлийн давхар исэлд хөрвүүлэн илэрхийлсэн хэмжээг хэлнэ.

**Нүүрстөрөгчийн дүйцүүлэлт** гэж өөрийн ялгарлыг дүйцүүлэхийн тулд худалдан авч болох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан болохыг баталгаажуулсан гэрчилгээ, эсвэл төлбөрийг хэлнэ.

**Тойрог эдийн засаг (Circular economy)** гэж хог хаягдлыг багасгаж, материалын дахин хэрэглээ, дахин боловсруулан ашиглахад чиглэсэн эдийн засгийн загварыг хэлнэ.

**Уур амьсгалын эрсдэл** гэдэгт уур амьсгалын өөрчлөлтөөс компани болон хөрөнгө оруулалтад учруулж буй эрсдэлийг багтаан ойлгоно.

**Уур амьсгалын өөрчлөлт** гэж агаарын хэм болон цаг уурын хэв шинжид урт хугацаанд гарах өөрчлөлтийг хэлнэ.

**Компанийн засаглал** гэж компанийг удирдаж хянадаг систем, тогтолцоо, үйл явц, зарчим зэргийг нийлүүлсэн агуулгаар ойлгоно.

**Олон янз байдал, хүртээмж** гэж олон янз хувь хүмүүст тэгш боломж олгож, тэгш хандах явц юм.

**БОНЗ** гэж Байгаль орчин, нийгэм, засаглал хэмээх үгсийн товчлол ба бизнесийн зүгээс тогтвортой хөгжилд нөлөөлж байдаг гурван гол салбарыг ойлгоно.

**БОНЗ-ын хүрээлэл** гэдэг нь БОНЗ-ын чиглэлээр боловсруулан гаргасан, компаниуд өөрийн БОНЗ-ын гүйцэтгэлээ сайжруулахын тулд ашиглаж болох стандарт, зааварчилгаа, удирдамж, код, журам, санаачилга болон сайн туршлагаудыг хамтад нь илэрхийлсэн хэллэг юм.

**БОНЗ-ыг уялдуулах** гэдэгт БОНЗ-ын хүчин зүйлсийг компани, байгууллагын хөрөнгө оруулалтын шийдвэр, стратеги, бодлого болон тогтолцоонд урт хугацааны тогтвортой өгөөжийг бий болгох зорилгоор тусгах үйл явцыг хамруулна.

**БОНЗ-ын хөрөнгө оруулалт** хэмээх нь уламжлалт санхүүгийн сэдвээс гадна

БОНЗ-ын хүчин зүйлсийг харгалзан, эрэмбэлэн тусгасан хөрөнгө оруулалтын стратеги юм.

**БОНЗ-ын рейтинг** гэдэгт ихэвчлэн гуравдагч талууд, эсвэл рейтингийн агентлагуудын зүгээс компани, хөрөнгө оруулалтад тэдний БОНЗ-ын гүйцэтгэлд нь суурилан олгосон оноо, эрэмбийг ойлгоно.

**Ялгаруулалт** гэдэгт хүлэмжийн хий болон бусад бохирдуулагчийг агаар мандалд ялгаруулж буй үйлдлийг ойлгоно.

**Байгаль орчин** гэж БОНЗ-ын үзэл баримтлалын хүрээнд уур амьсгалын өөрчлөлт, бохирдол, биологийн олон янз байдал, байгалийн нөөц болон байгаль орчны бусад хүчин зүйлсийг хамарсан чиглэлийг хэлнэ.

**Засаглал** гэж БОНЗ-ын үзэл баримтлалын хүрээнд эрсдэлийн удирдлага, кибер аюулгүй байдал болон ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, гүйцэтгэх удирдлагын цалин хангамж, хувьцаа эзэмшигчийн эрх зэрэг компанийн засаглалын чиглэлийг хэлнэ.

**Ногоон зээл** нь байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтөд эерэг нөлөөлөл бүхий төсөл, бизнесийн санаа, үйл ажиллагааг дэмжих зорилгоор санхүүгийн байгууллагуудын олгож буй санхүүжилт юм.

**Материаллаг нөлөөлөл (Material impact)** гэж БОНЗ-ын чиглэлд компаниудын үйл ажиллагаанаас учрах томоохон хэмжээний нөлөөллийг хэлнэ.

**Тэг хэмжээ (Net zero)** гэж бууруулах болон дүйцүүлэх арга хэмжээний хүрээнд хүлэмжийн хийн ялгарлыг тэг хэмжээнд хүргэх зорилгыг ойлгоно.

**Нийгэм** гэдэгт БОНЗ-ын үзэл баримтлалын хүрээнд хүний эрх, хөдөлмөрийн харилцаа, нутгийн иргэд/ оролцогч талуудын оролцоо болон бусад нийгмийн хүчин зүйлсийг багтаасан чиглэлийг үзнэ.

**Оролцогч тал** гэж байгууллагын үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртсөн эсвэл өртөж болзошгүй ямар нэгэн ашиг сонирхол бүхий хувь хүн эсвэл бүлгийг хэлнэ.

**Тогтвортой байдал/ хөгжил** гэж өнөө үеийн хэрэгцээг хангахдаа ирээдүй үеийн хэрэгцээг хангах боломжийг үл хязгаарлахад суурилсан үзэл баримтлалыг ойлгоно.

**Тогтвортой хөгжлийн зорилтуудад** НҮБ-ын гишүүн орнууд ядуурал, тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлт зэрэг дэлхий нийтэд тулгарч буй сорилтуудыг шийдэх зорилгоор 2015 батлан гаргасан 17 зорилт багтана.

**Усны үр ашигтай хэрэглээ** гэж усны нөөцийг удирдах хариуцлагатай үйл ажиллагааг ойлгоно.

Тэмдэглэл: .....

баярлалаа.

# БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ГАРЫН АВЛАГА

## Adam Smith International



2A Temple View Residence, Sukhbaatar  
District-1 Ulaanbaatar 15160, Mongolia



/AMEP2



infoamep.mn



www.amep.mn



976-7000 8595



Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл  
ажиллагаа явуулж буй компаниудад зориулав.